

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ • 2019 ОНЫ 6-Р САР

Лиахоно

Бид Их Эзэний
мудар билээ,
8, 12, 20-р хуудас

Бурхан *таныг* хэрхэн ашиглаж
болох вэ?, 28-р хуудас

Гэр орондоо сайн мэдээний
хувьд дэмжлэг туслалцаа
авдаггүй хүүхдүүдийг дэмжиж
туслах нь, 40-р хуудас

СҮМ
ЭНД
БИЙ

Мексика

Такско



ЭЙН



Өмнө нь уул уурхайн хот байсан Мексикийн Герреро дахь Такско де Аларкон нь өнөө үед мөнгөн эдлэлийн үйлдвэрлэл, Испанийн колончлолын үеийн архитектур, ойр орчмын хөдөө нутгийнхаа гоо үзэсгэлэнгээр алдартай, улсынхаа *pueblos magicos* буюу шидэт хотуудын нэг гэдгээрээ олонд танигдах болжээ. Хот уулархаг газар нутагт байрладаг бөгөөд эгц дээшээ өгссөн эмх замбараагүй гудамжуудтай. Түүхийн дурсгалт гол барилга нь 18-р зууны үеийн Санта Приска сүм юм.

Мөн Такскод Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Такско салбар байдаг бөгөөд ням гараг бүр *avenida de los Plateros* буюу Дархчуудын өргөн чөлөөн дэх байранд цуглардаг. Уг салбар нь Мексикийн Игуала гадсанд харьяалагддаг ба Мексик дэх Сүмийн 1,4 сая гаруй гишүүн, 34 номлол, 13 ариун сүм, 1987 хожмын үеийн гэгээнтнүүдийн цуглааны нэгэн хэсэг юм. Мөн Мексикт Мехико хотын Номлогч Бэлтгэх Төв байдаг ба энэ нь хэмжээгээрээ Сүмийн хоёр дахь том НБТ юм. Энэ төв нь нэг зэрэг 1000 гаруй номлогч хүлээн авах хүчин чадалтай.

© GETTY IMAGES-ИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

- Мексикийн анхны таван гишүүн 1876 онд баптисм хүртсэн.
- Мексик бол Америкийн Нэгдсэн Улсыг тооцохгүйгээр, 100 гадастай болсон анхны орон юм.
- Мехико хотын Мехико ариун сүм бол Мексикт баригдсан хамгийн анхны ариун сүм бөгөөд 1983 онд онцгойлон адислагджээ. Хамгийн сүүлд Мексикийн Тихуана Мексик ариун сүм 2015 онд онцгойлон адислагдсан. Мексикийн Пуебла ариун сүмийг 2018 оны 10-р сард зарласан.
- 1994 онд ерөнхийлөгч Ховард В.Хантэр (1907–1995) Мексикт айлчлан очихдоо Сүмийн 2000 дахь гадас болох Мехико хотын Контрерас гадсыг зохион байгуулсан.





Тохинуулах гэдэг нь Аврагчийн адилаар бусдыг харахыг хэлнэ
8



Илүү ариун арга замаар тохинуулах нь
Ахлагч Нийл Л.Андэрсэн

12

Бидний тохинуулал бусдын эдгэрэхэд туслах болов уу?

Би нэг ням гарагт ариун ёслолын цуглаан дээр судраас уншиж байхдаа, Аврагчийн хийсэн ажлуудыг бид хийх ёстой талаар бодож суув (3 Нифай 27:21-ийг үзнэ үү). “Дэлхий дээр хийх Христийн ажлууд юу юм бол?” гэж надад бодогдлоо. Шуудхан л үйлчлэх, эдгээх гэсэн хоёр зүйл санаанд минь орж ирэв. Би үйлчилж чадна л даа, харин яаж эдгээх билээ?

Эдгээх гэсэн ойлголтын талаар би байнга боддог байлаа. Тухайн үед би амьдралынхаа туршид 16 мэс засал хийлгэсэн байсан ба эдгэрэхэд дахиад *урт удаан хугацаа* шаардлагатай байв. Гэвч би хэрхэн Есүс Христтэй адил байж, бусдад эдгэрэхэд нь тусалж чадах билээ гэж бодлоо. Мэдээж надад Түүнд байсан шиг эдгээгч хүч байсангүй. Ийм байхад Тэр яаж намайг газар дэлхий дээр Түүний эдгээх ажлыг хийхийг хүссэн юм бол? Би юу хийж чадах вэ?


Бусад хүн надад хэрхэн эдгэрэхэд минь тусалж байсныг тунгаан бодох үед бусдын миний амьдралд хийж байсан эдгээх буюу тайтгаруулах мөн үйлчлэх, тохинуулах гэсэн гайхалтай сайхан ажлуудыг би оюун санаандаа олж харсан юм. Аврагчийн арга замаар бусдад тохинуулахад анхаарлаа хандуулах юм бол бусдад эдгэрэхэд нь туслах гэсэн энэ ойлголт улам хүчирхэгждэг. Бидний хүн нэг бүр дэлхий дээрх мөнх бус амьдралын аяллынхаа туршид зовлон шаналлыг мэдэрдэг. Олон хүн бие махбодын юм уу сэтгэцийн өвчнөөр өвдөж байхад зарим нь сүнслэг байдлын хувьд зовж шаналсаар байна. Бид бүгдийг эдгэрэхэд тусламж хэрэгтэй. 20-р хуудсан дээрх миний өгүүлэлд тайлбарласнаар мөн 12-р хуудсан дээрх ахлагч Нийл Л.Андэрсэний өгүүлэлд зааснаар, бид бусдад эдгэрэхэд нь туслах арга замаар тохинуулан энэ ажилд оролцох боломжтой.

Хүндэтгэсэн,
Мэррилий Бояк



Бусдад Их Эзэний эдгээлтийг хүлээн авахад туслах нь
Мэррилий Браун Бояк









20




Тэнгэрээс удирдуулсан шавь байх нь
Бишоп Дийн М.Дэйвийс

28



- 5 **Эцгийн дуудлага** 
Судраас болон бошиглогчдын үгсээс эцгийн талаарх дуртай сургаалуудаа унш.
- 6 **Итгэлийн хөрөг:**
Родриго Квинтанилла—Чили, Валпарайсо 
- 8 **Тохинууллын зарчмууд:**
Тохинуулах гэдэг нь Аврагчийн адилаар бусдыг харахыг хэлнэ
- 12 **Илүү ариун арга замаар тохинуулах нь**
Ахлагч Нийл Л.Андэрсэн
Тохинуулах арга замыг эрэлхийлэх юм бол Бурхан таныг Өөрийн охид, хөвгүүд рүү удирдан чиглүүлэх болно.
- 20 **Бусдад Их Эзэний эдгээлтийг хүлээн авахад туслах нь**
Мэррилий Браун Бояак
Бид зовж шаналж байгаа хүмүүсийг эдгээхэд хэрхэн тусалж болох талаар олж мэд.
- 24 **Бие даасан байдлаас ирдэг адислалууд:**
Цэцэгс ба санхүүгийн хувьд баталгаатай болсон нь 
Мичэл Волл
- 26 **Шинэ Гэрээний хичээлүүд:**
Марта, Мариа хоёр 
Камилла Фронк Олсон
- 28 **Тэнгэрээс удирдуулсан шавь байх нь**
Бишоп Дийн М.Дэйвийс
Та Бурханы шавь болохоор эрэлхийлбэл Тэрээр танд тэнгэрлэг удирдамж өгөх болно.
- 32 **Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой** 
Амьдралыг нь өөрчилсөн ухаарлын мөч; тэр үргэлж номлогч байснаа ухааран ойлгосон явдал; Түүнийг Сүмд авчирсан аялал; гэрчлэлийг нь хүчирхэгжүүлсэн үг.
- 36 **Бид юунд итгэдэг вэ:**
Би Христээр төгс байхад итгэдэг 
- 38 **Бидний гэр орон, гэр бүл:**
Хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлсэн цаг мөч ба хонин гүрвэл, дэвхрэг хоёр 
Нанси Томас
- 40 **Өсвөр үеийн болон бага насны хүүхдүүдэд заах нь:**
Эцэг эхийнх нь аль нэг нь эсвэл аль аль нь сүмд явахгүй байхад 
Кармел Ньюл

 Богино өгүүллүүд



Хавтсан дээр
Жэнэди Пэйж,
Чөлөөлөгдсөн нь.

Хэсгүүд

Залуучуудад зориулав

42

Хэзээ хүүхэдтэй болох, хэдэн хүүхэдтэй болох мөн төлөвлөснөөр тань болохгүй байвал хэрхэн дасан зохицох гэх мэт асуултууд гэр бүлээ төлөвлөх үед тань гарч ирж магадгүй. Энэ сарын тусгай хэсгээс бусад залуучуудын хувийн туршлагыг уншаарай.



Өсвөр үеийнхэнд зориулав

51

Хэрхэн бодит зорилго тавих, авралын төлөвлөгөөгөөр дамжуулан амар амгаланг олох, цахим хэрэгсэлдээ анхаарлаа хандуулахаа болих талаар энэ сарын өгүүллүүдээс суралцаарай.




Хүүхдүүдэд зориулав

Хэрхэн шинэ найзтай болох мөн хуучин найздаа хэрхэн тусалж болох талаар олж мэд. **Ариун Сүнсний** тухай илүү ихийг мэдэж ав. Мөн ахлагч Күкийн Бразилд хийсэн аялалар юу болсныг олж мэдээрэй.



ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР ГАРАХ НИЙТЛЭЛҮҮД



Эцэст нь ариун сүмд оров

Рамона Моррис

Барбадогоос ирсэн нэг залуухан эмэгтэй ариун сүмд ороход бэлтгэж, эцэст нь ариун сүмд орсон түүхээ хуваалцав.



Та өдөр бүр ямар нэг шинэ зүйл сурч байна уу?

Бие даах чадвар хөгжүүлэх үйлчилгээний хэлтсээс:

Альцгеймераас урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндээ сайжруулах гээд шинэ зүйл сурах нь үр өгөөжтэй.

2019 ОНЫ ЗУРГААДУГААР САР, 20, №3
Лиахона 18604 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Рэссэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс, Хэнри Б.Айринг

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга: М.Рэссэл Баллард, Жэффри Р.Холланд, Дийтр Ф.Угдорф, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Күж, Д.Тодд Кристоффарсон, Нийл Л.Андерсон, Роналд А.Расбанд, Гари И.Стивэнсон, Дэйл Г.Рэнланд, Гэррит В.Тонг, Улиссэс Соарэс

Эрхлэгч: Рэнди Д.Фанк

Зөвлөхүүд: Бриан К.Эштон, Рэндэлл К.Бэннэтт, Бэки Крайвэн, Шэрон Юбанк, Кристина Б.Франко, Доналд Л.Холлстром, Ларри С.Качер, Эрик В.Копишкэ, Линн Г.Роббинс

Гүйцэтгэх захирал: Ричард И.Хийтон

Сүмийн сэтгүүлийн захирал: Аллан Р.Лойборг

Бизнесийн менежер: Гарфф Каннон

Гүйцэтгэх редактор: Адам С.Олсон

Гүйцэтгэх захирлын туслах: Раян Карп

Хэвлэлийн туслах: Камила Кастрион

Редакцийн баг: Мэрисса Дэннис, Дэвид Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Гаррэтт Х.Гарфф, Жон Райн Жэнсэн, Шарлотт Ларкэбэл, Майкл Р.Моррис, Эрик Б.Мөрдок, Салли Жонсон Оджөрк, Жошуа Ж. Пэркий, Жан Пинбороу, Ричард М. Ромни, Минди Сэлу, Лори Фүлэр Соса, Чакэлл Вардлэй, Марисса Виддисон

Зураглал чимэглэлийн удирдагч менежер: Ж.Скотт Кнудсэн

Зургийн дарга: Тадд Р.Пэтэрсон

Уран бүтээлийн ажилтнууд:

Жинэтт Эндрыос, Фэй П.Андрус, Мэндий Бэнгли, С.Кимбалл Ботт, Томас Чайлд, Жошуа Дэннис, Дэвид Грийн, Коллийн Хинкли, Эрик П.Жонсон, Сюзан Лофгрэн, Скотт М.Моой, Эмили Чизко Рэмингтон, Марк В.Робисон, Брэд Тиэри, К.Никол Вокенорст

Оюуны өмчийн зохицуулагч: Коллэтт Нэбэкэр Аун

Хэвлэлийн менежер: Жэйн Анн Пэтэрс

Хэвлэх баг: Ира Глэн Адэйр, Жюли Бердэтт, Томас Ж.Кронин, Брайн В. Гайги, Жинни Ж.Нилсон, Мэрисса М.Смит

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жошуа Дэннис, Аммон Харрис

Хэвлэлийн захирал: Стивэн Т.Льюис

Хуваарилалт хариуцсан захирал: Трой Р.Баркэр

Нэгдсэн Улс, Канадаас бусад орон дахь захиалга болон үнийн талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

Лиахона (Мормоны Номон дахь утгаараа бол "луужин" буюу "залагч") нь албани, англи, армен, бислам, болгар, вьетнам, гайти, герман, грек, дани, индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати, латви, литов, малагаш, маршалл, монгол, нидерланд, норвеги, орос, польш,

португал, румын, свахили, самоа, себү, словени, солонгос, сингал, тагалог, тай, тамил, тахити, телуг, тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хинди, хорват, хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр байна.)

© 2019 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

Зохиогчийн эрхийн талаарх мэдээлэл: Өөрөөр заагаагүй бол хувь хүмүүс арилжааны бус зорилгоор (Сүмийн дуудлага зэрэг) хувийн хэрэгцэндээ Лиахона гаас материал хувиран авч, ашиглаж болно. Энэ эрх ямар ч үед өөрчлөгдөхгүй. Хэрэв зураг чимэглэлийн тухайд ямар нэг хязгаарлалт тогтоосон бол үзүүлэнгийн материалыг хуулбарлаж болохгүй. Зохиогчийн эрхийн талаар асуух зүйл байвал дараах хаягаар хандана уу. Intellectual Property Office, 50 E. North Temple St., FL 13, Salt Lake City, UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн sor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada: June 2019 Vol. 20, No. 3. LIAHONA (USPS 311-480) Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year (January, April, June, July, October, and December) by The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is \$5.00 per year; Canada, \$6.50 plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required for change of address. Include address label from a recent issue; old and new address must be included. Send USA and Canadian subscriptions to Salt Lake Distribution Center at address below. Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders (American Express, Discover, MasterCard, Visa) may be taken by phone or at store.lds.org. (Canada Post Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all USA to CFS (see DMM 507.1.5.2). NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368, Salt Lake City, UT 84126-0368, USA.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Та Gospel Library аппликэйшн болон comefollowme.lds.org вэбсайт дээр дараах зүйлсийг хийж болно.

- Сэтгүүлийн энэ дугаарыг ол.
- Зөвхөн цахим хувилбараар гарах агуулгыг унш.
- Өмнөх дугааруудыг хай.
- Өөрийнхөө түүх, санал зөвлөмжийг илгээ.
- Сэтгүүл захиал эсвэл бусдад захиалж өгч, бэлэглэ.
- Цахим хэрэгслийн тусламжтайгаар суралцахаа сайжруул.
- Таалагдсан нийтлэл, бичлэгээ хуваалц.
- Нийтлэлүүдийг татаж ав эсвэл эсвэл.
- Дуртай нийтлэлүүдээ сонс.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Асуулт, санал зөвлөмжөө liahona@ldschurch.org хаяг руу э-мэйлээр илгээнэ үү.

Итгэлийг тань хүчирхэгжүүлсэн түүхийг liahona.lds.org вэбсайтад илгээ эсвэл доорх хаягаар шуудангаар ирүүлнэ үү.

Liahona, flr. 23

50 E. North Temple Street

Salt Lake City, UT, 84150-0023, USA

“ЭЦГИЙН ДУУДЛАГА БОЛ МӨНХИЙНХ БӨГӨӨД ҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ ХЭЗЭЭ Ч ӨӨРЧЛӨГДӨХГҮЙ.”

Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson (2014), 194

ЭЦЭГ БАЙХ ТАЛААРХ
БИДНИЙ ДУРТАЙ
СУРГААЛУУДЫН ЗАРИМ
ХЭСГИЙГ ЭНД ОРУУЛЛАА.

Хэрэв танд багахан урам зориг хэрэгтэй бол эдгээр захиасын аль нэгийг хараарай. Үүнд:

- Лук 15:20–24
- Д. Тодд Кристоффэрсон, “Эцэг хүн,” 2016 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 78–82.
- L. Tom Perry, “Fatherhood, an Eternal Calling,” *Liahona*, May 2004, 69–72.
- “The Sacred Callings of Fathers and Mothers,” chapter 15 in *Teachings of Presidents of the Church: Ezra Taft Benson* (2014), 191–196.
- “Love at Home,” chapter 14 in *Teachings of Presidents of the Church: Harold B. Lee* (2000).

Родриго Квинтанилла

Чили, Валпарайсо



Родриго Квинтанилла барилгын осолд орсны улмаас явж чадахаа больж, гагнуурчнаар ажиллах байтугай өөр олон зүйлийг хийх боломжгүй болжээ. Тийм ч гэсэн тэр Тэнгэрлэг Эцэгийнхээ өөрт нь болон түүний гэр бүлд зориулсан төлөвлөгөөнд найдаж, итгэлтэйгээр урагшлахаар шийджээ.

ГЭРЭЛ ЗУРАГЧИН ЛЭСЛИЙ НИЛССОН

Ямар нэгэн маш муу зүйл тохиолдоход бид дараах хоёр арга замын аль нэгийг дагаж болно. Бид Бурханд уурлан, Сүмээ орхиж, холбоогоо тасалж болно. Эсвэл бид өвдөг сөгдөн, залбирч, үргэлжлүүлэн өсөж хөгжиж болно.

Би итгэлээ алдаагүй төдийгүй “Надад яагаад ийм зүйл тохиолдож байгаа юм бэ?” гэж өөрөөсөө асуугаагүй. Би тэр замаар явахаас татгалзсан.

Сорилт бэрхшээл ирэхэд Тэнгэр дэх Эцэг маань уг сорилтыг даван гарах арга замыг бидэнд өгдөг гэдгийг би мэднэ. Эдгэрэх явцад надад Ариун Сүнсний нөхөрлөл маш чухал байсан. Би мэргэжлээ өөрчлөх хэрэгтэй байсан ба Сүнсний удирдамж гуйн залбирдаг байлаа. Бурхан ч надад хариу өгсөн.

Би ослоос эсвэл ямар нэгэн үйл явдлаас болж амьдрал нь өөрчлөгдөн зовж зүдэрсэн хүмүүст хандан, “Хүнд хэцүү зүйл болж болох ч Сүмдээ үлд” гэж хэлмээр байна. Сайн мэдээтэй үлд. Амьдрал сайн мэдээгүйгээр улам хүнд хэцүү болно. Та чадлынхаа хэрээр хичээл зүтгэл гарга, харин үлдсэнийг нь Тэнгэрлэг Эцэг хийнэ.



ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Өмнөд Африкийн Либюлецв Гофри Мокгатл хэрхэн Бурханд итгэлтэй байж мөн хөгжлийн бэрхшээлтэй байсан ч урагшлан явсныг [Ids.org/go/6196](https://ids.org/go/6196) хаягаар орж, олж мэднэ үү.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой Сүмийн эх сурвалжуудыг [Ids.org/go/9184](https://ids.org/go/9184) хаягаар орж үзнэ үү.

Та итгэлийн өөр хөргийг [Ids.org/go/18](https://ids.org/go/18) вэбсайтаас үзээрэй.



Тохинууллын зарчмууд

ТОХИНУУЛАХ ГЭДЭГ НЬ АВРАГЧИЙН АДИЛААР БУСДЫГ ХАРАХЫГ ХЭЛНЭ

Есүс ихэнх цагаа бусдаас өөр хүмүүстэй өнгөрөөдөг байсан бөгөөд тэдний бурханлаг чадавхыг олж хардаг байв.

Аврагчийн адил тохинуулахаар хичээж чармайх үедээ бид өөрсдөөсөө өөр хэн нэгэнд тохинуулах дуудлагыг хүлээн авч болно. Энэ нь бидэнд сурч, өсөж хөгжих боломжийг олгодог.

Соёл, боловсрол, арьс өнгө, санхүү, нас, өмнөх эсвэл одоогийн зан авир болон өөр бас бус ялгаа нь хэн гэдгийг нь мэдэхгүй мөртлөө хүмүүсийг

шүүмжлэхэд амар хялбар болгодог. Ийнхүү урьдчилж шүүх нь Аврагчийн бидэнд сэрэмжлүүлсэн ялгаварлан гадуурхахын үндэс суурь болдог (1 Самуел 16:7; Иохан 7:24-ийг үзнэ үү).

Бид бусдын ялгааг харалгүйгээр Аврагчтай адил харж чадах уу? Бид бусдыг байгаагаар нь хүлээн авч, хэн болж чадахаар нь хайрлаж сурах болов уу?



Ширтэн харж, хайрлах

Библид мөнх амьдралыг хэрхэн олж авах талаар асуусан баян залуу эрийн тухай хүн бүрийн мэддэг нэгэн түүхийг өгүүлдэг. “Есүс түүнийг ширтэн харж, хайрлан—Чамд нэг л юм дутаж байна. Явж, өөрийн гэсэн бүхнээ зарж ядууст өг. Тэгвэл чи тэнгэрт эрдэнэстэй болно. Тэгээд ирж, Намайг дага гэлээ” (Марк 10:21).

Далын ахлагч С.Марк Палмэрыг энэ судрын хэсгийг хэдэн жилийн өмнө судалж байхад энэ түүхийн өөр нэгэн хэсэг анхаарлыг нь татжээ.

“Есүс түүнийг ширтэн харж, хайрла[в].”

Эдгээр үгийг сонсох үед надад Их Эзэн яриагаа азнаад, энэ залуу эрийг *ширтэн харж байгаа* тод томруун дүр зураг харагдсан юм. *Ширтэн харах* гэдэг нь түүний бодгалийн гүн рүү нэвт харан, түүний сайн сайхан чадвар, чадавхыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ хамгийн агуу хэрэгцээг нь олж харсан гэсэн утгатай.

Дараа нь Есүс *түүнийг хайрласан* гэсэн энгийн үгс энд бий. Би Есүс энэ сайн залууг ихэд хайрлаж, энэрсэн бөгөөд ийнхүү хайрласан *учраас* мөн энэхүү хайраа *тээн* түүнээс илүү ихийг хийхийг шаардсан гэдгийг мэдэрсэн юм. Хэдийгээр энэ залуу байгаа бүхнээ зараад, ядууст өг гэсэн санаанд багтамгүй бэрх хүсэлтийг хүлээн авсан ч ийм хайрыг мэдрэхэд ямархуу байх бол гэж би төсөөлөн бодож билээ.

[Би өөрөөсөө] ‘Би номлогчдод Бурханы хайрыг болон өөрчлөгдөх хүслийг өөрийн биеэр мэдрүүлэхийн тулд Христийнхтэй адил хайраар хэрхэн дүүргэгдэж болох вэ?’ гэж асуусан юм. Би хэрхэн [эргэн тойрныхныгоо] Их Эзэн энэ залуу эрийг ширтэн харсны адил *ширтэн харж*, юу хийж эсвэл юу хийхгүй байгаагаар нь биш, харин үнэхээр хэн болох мөн хэн болж чадах талаас нь харж чадах вэ? Би хэрхэн Аврагчтай илүү адилхан болж болох вэ?”¹

Бусдыг харж сурах нь

Бусдыг Аврагчтай адил харж сурах нь үнэт шагналуудыг авчирдаг. Энэхүү зорилго дээр ажиллах үед бидэнд тусалж болох хэдэн санааг өгье.

ТЭДНИЙГ ИЛҮҮ САЙН МЭДЭЖ АВ

Хүмүүсийг өнгөцхөн биш, илүү сайн таньж мэд. Ойр дотно харилцаатай болоход цаг зав, чин сэтгэлийн хүчин чармайлт гаргах шаардлагатай гэдгийг бүү март. (Тусламж авах бол 2018 оны 8-р сарын Тохинууллын зарчмуудын “Дотно харилцаа тогтоох нь” өгүүлийг үзнэ үү.)

ӨӨРИЙГӨӨ ЦЭГНЭ

Өөрийнхөө санаатай болон санаандгүй шүүмжлэлд анхаар. Бусдын талаар гаргаж байгаа таамаглалаа тэмдэглэж, яагаад тэдний талаар ийнхүү бодож байгаагаа ойлгохыг хичээ.

ШҮҮМЖЛЭХЭЭС ЗАЙЛСХИЙ

Нөхцөл байдал хувь хүний үнэ цэнийг тодорхойлдоггүй гэдгийг сана. Тэдний оронд өөрийгөө тавьж, тэдэнтэй адил нөхцөлд байсан бол хүмүүс таны талаар юу гэж бодоосой гэж хүсэх байснаа бодож үз. Хүний сонголт, зан авирыг дотоод үнэ цэн, бурханлаг чадавхаас нь салган авч үзэх нь тэднийг Аврагчтай адил харахад бидэнд тусална.

ТЭДНИЙГ ХАЙРЛАХЫН ТӨЛӨӨ ЗАЛБИР

Тэднийг нэрээр нь дуудаж мөн тэдэнтэй жинхэнээсээ нөхөрлөж, тэвчээртэй байхын төлөө байнга залбир. Үйлчлэлийнхээ талаар залбирч, бод. Таны хийж байгаа зүйл, тэдний жинхэнэ хэрэгцээ шаардлагатай нийцэж байна уу?



Есүс баян, ядуу, захирагч, энгийн ард гээд амьдралын янз бүрийн хүрээний хүмүүстэй цагаа хамт өнгөрүүлдэг байсан. Тэрээр хүмүүс Өөрийг нь болон ядуу, дорд байдлыг нь гаднаас нь өнгөц харж дүгнэсэн буруу дүгнэлтийн хохирогч үргэлж болдог байсан. “Биднийг татахуйц дүр төрх түүнд алга байв. . . . Тэр хүмүүст жигшигдэж, орхигдсон . . . хүн ажээ” (Исаиа 53:2–3).

ҮЙЛДЭХЭД УРИХ

Та хэнийг өөрөөр харах хэрэгтэй вэ? Та тэднийг өөрөөр харахын тулд юу хийх вэ?

ТУРШЛАГАА ХУВААЛЦАНА УУ

Та бусдад эсвэл бусад хүн танд тохинуулж байсан туршлагаа-саа бидэнд илгээгээрэй. Та liahona.lds.org вэбсайт руу ороод, “Submit an Article or Feedback” дээр дарна уу.

Христтэй адил харах нь

Нэг эгч хөршөө Христийн мэлмийгээр харж сурсан талаараа доорх түүхийг хуваалцсан юм.

“Жулиа (нэрийг нь өөрчлөв) манай хажууд амьдардаг байсан ба ямар ч найзгүй юм шиг надад санагддаг байв. Тэр үргэлж бухимдаж, уурласан харагддаг байлаа. Тэгсэн ч гэсэн би түүнтэй найзлахаар шийдэв. Би зүгээр нэг энгийн найз биш, жинхэнэ найз болохоор шийдлээ. Түүнтэй таарах болгондоо үг солилцож, хийж байгаа бүх зүйлийг нь сонирхож байгаагаа харуулдаг байв. Аажмаар би түүнтэй найзын харилцаа холбоотой болж, дотроо маш их баярлаж байлаа.

Би нэг өдөр Жулиа дээр очиж, сүмдээ очихгүй байгаа учрыг нь асуухаар шийдэв.

Ойр хавьд түүний ямар ч гэр бүл, хамаатан садан байхгүй болохыг би олж мэдлээ. Ганц ах нь хол амьдардаг байсан ба жилд ганцхан удаа түүнтэй утсаар ярьдаг байв. Гэр бүлийнхээ талаар мөн Сүмийн талаар ямар их хорсон, уурлаж, бухимдаж байгаагаа урсган ярихыг сонсож байх үедээ энэ эгчийг өрөвдөн, хайрлах сэтгэл надад хүчтэй мэдрэгдсэн юм. Би түүний шаналал, цөхрөлийг мэдэрч, амьдрал нь ямар ганцаардмал байсныг ойлгосон. Миний араас хэн нэгэн ‘Би ч бас түүнд хайртай. Түүнийг хайрлаж, хүндэл’ гэсэн дуу намуухан шивнэх шиг болов.

Би чимээгүй сууж, ярьж дуустал нь сонссон ба түүнийг хайрлах, өрөвдөх сэтгэл төрж байлаа. Энэ эгч хайр гэж юу болохыг хэзээ ч мэдэрч байгаагүй байв. Гэнэт би түүнийг илүү гүн гүнзгий ойлгосон юм. Би түүнийг гэрт нь айлчлах боломж олгосонд талархаж мөн тэврэн,



хайрлаж бас хүндэтгэж байгаагаа илэрхийлээд явж билээ. Энэ айлчлалаар тэр надад ямар их нөлөөлснөө хэзээ ч мэдэхгүй биз ээ. Тэнгэрлэг Эцэг миний нүдийг нээж, бусдыг илүү өрөвч нимгэн сэтгэлээр хайрлаж чадна гэдгийг надад заасан юм. Би түүний найз байхын зэрэгцээ гэр бүл нь болох шийдвэр гаргасан.

Хэн нэгний амьдралд уригдан орох нь ариун нандин зүйл билээ. Бид залбирал, тэвчээр, Сүнсний тусламжаар дамжуулан үүнийг Христтэй илүү адилаар хийж сурах болно. ■

ЭШЛЭЛ

1. С.Марк Палмэр, “Есүс түүнийг ширтэн харж, хайрлав,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 105.

ИЛҮҮ ИХИЙГ ОЛЖ МЭД

Илүү нөхөрсөг байх талаар илүү ихийг олж мэднэ үү:

- “We Can Do Better: Welcoming Others into the Fold” in the September 2017 *Liahona*-г уншина уу.
- Сүмийн удирдагчид эдгээр зарчмыг хэрхэн тайлбарласныг lds.org/go/61911-оос үзнэ үү.





Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
Ахлагч
Нийл Л.Андэрсэн

Илүү ариун арга замаар ТОХИНУУЛАХ НЬ

Та Бурханыг бүхий л зүрх сэтгэлээрээ хайрлаж,
Түүний мутарт зэмсэг болохыг хүсэн залбирвал Их
Эзэн Өөрийн онцгой охид, хөвгүүдийг таны замд
тавина гэдгийг би амлаж байна.

Тhe *Narcissism Epidemic* гэх ном нь орчин үеийн Америкийн соёлыг харуулсан хэтрүүлэн дөвийлгөсөн жишээнүүдээр эхэлдэг. “Телевизийн нэгэн реалити шоун дээр 16 насны төрсөн өдрийн үдэшлэгээ төлөвлөж буй нэгэн охин улаан хивсэн дээр цэргийн хамтлагийг даган, сүр жавхлантай орж ирэхийн тулд гол замыг хаалгахыг хүсэж байлаа. *My Beautiful Mommy* гэдэг номд сүүлийн үед нэрд гарсан ‘Ээжийн өөрчлөлт’-д орохоор гоо сайхны мэс засал хийлгэх гэж буй ээжүүдийн бяцхан хүүхдүүдэд гоо сайхны мэс засал гэж юу болохыг тайлбарладаг. Таныг орой үдшийн цагаар гадагшаа гарахад дагаж, зургийг тань авах хуурамч папарац хөлсөлж авахын зэрэгцээ гэртээ харих замдаа зургуудыг тань нүүрний хуудсан дээр тавьсан, алдартай хүмүүсийн тухай нийтэлдэг нэртэй сэтгүүлийн хуурамч хувийг хүртэл авах боломжтой болжээ. Нэгэн нэртэй дуун дээр ‘Дэлхий намайг тойрон хүрээлэх ёстой гэдэгт би итгэдэг!’ хэмээн ямар ч ёжилсон шинжгүй тунхагласан байдаг! . . . Эцэг эх нь *This Little Piggy Went to Prada*¹ нэртэй дууны номоос орчин үеийн бүүвэйн дууны үгийг уншиж байх зуур нялх үрс нь ‘Супер загвар’ гэсэн хатгамалтай энгэрэвч зүүж, ‘Bling (Блинг)’ хөхөл хөхдөг болжээ.”

Есүс Христийн шавийн хувьд, бид өөрсдийн амьдралыг өөрсдөдөө л зориулах ёстой гэсэн ойлголтыг эрс эсэргүүцдэг. Харин бид

“Та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог;

Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог.



... Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ” (Матай 20:26–28) хэмээн айлдсан Аврагчийг дагадаг.

Бид Түүний хэлсэн дараах үгсийг нандигнан хайрладаг.

“Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун” (Иохан 13:34; мөн Иохан 15:12-ыг үзнэ үү).

“Хургануудыг минь тэжээ. . . Хоньдыг минь хариул” (Иохан 21:15, 16).

“Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:32).

“Сул доройчуудад тусал, доош унжсан гарнуудыг өргөгтүн, мөн сул дорой өвдөгнүүдийг хүчирхэг болгогтун” (Сургаал ба Гэрээ 81:5).

Их Эзэний Сүмийн гишүүдийн дунд хийгдэх ёстой Христийнхтэй адил тохинууллын жишээнүүдийг дурдъя.

Бригам Янгийн Их Сургуулийн нэг оюутан саяхан “Надад үнэхээр хүнд үе тулгараад байв. Нэг өдөр надад их хэцүү байсан тул бүр уйлах шахаад байлаа. Би

цааш үргэлжлүүлэх хүч чадлыг гуйн, чимээгүйхэн залбирсан. Яг тэр мөчид өрөөний маань найз надад хайртайгаа илэрхийлсэн мессеж илгээсэн юм. Тэр судраас эш татаж, гэрчлэлээ хуваалцсан байв. Энэ нь цөхөрч туйлдсан тэр мөчид надад маш их хүч чадал, тайтгарал, найдварыг өгсөн” гэж бичжээ.

Одоо та нарын нэг нэгэндээ тохинуулдаг гайхамшигтай арга замыг хүчирхэгжүүлнэ байх гэж найдаж байгаа хэдэн зүйлийг хуваалцъя. Миний эхний санаа бол: Та нар хоёр дахь зарлигийг хэрэгжүүлэхийнхээ өмнө эхний зарлигийг санаарай. Нэгэн залуу Аврагч дээр ирээд, “Багш аа, хуулийн аль тушаал нь агуу вэ? гэв.

Тэр түүнд, Чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла.

Энэ бол агуу нь бөгөөд анхны тушаал мөн.

Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла гэсэнтэй адил юм” (Матай 22:36–39) хэмээн заажээ.

Хөршөө хайрлах, бусдыг халамжлах, бусдад тохинуулах зэргийг илүү ариун арга замд авчрах чадвар тань эхний зарлигийг хэр сайн дагаж байгаагаас шалтгаална.

Тохинууллын өөр нэг хэлбэр

Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрладаг, Есүс Христэд болон сэргээгдсэн сайн мэдээнд итгэх итгэл бат тогтсон, үндэслэлтэй, тууштай, гуйвшгүй (Ефес 3:17; Колоссай 1:23; 1 Нифай 2:10; Мозая 5:15; Алма 1:25; 3 Нифай 6:14-ийг үзнэ үү) мөн зарлигуудыг яг таг дагадаг хүнээс ирдэг тохинуулал онцгой хийгээд бурханлаг бэлэг юм.

Би та нарын аль хэдийн мэдэх хэдэн нөхцөлийг дуулгая. Дэлхий даяар залуу үеийнхэн итгэл үнэмшлээ, нэн ялангуяа шашин шүтлэгтэй нь холбоотой итгэл үнэмшлээ алдсаар байна. Намайг 1975 онд БЯИС-ийг төгсөх үед шашин шүтлэгтэй залуучуудын тоо (18-аас 24 насныхан) 90-ээд хувьтай байсан. Харин одоо 66 хувьтай болсон байна. “Залуучуудын бүхэл бүтэн гуравны нэг хувь ямар нэгэн зохион байгуулагдсан шашин шүтлэгтэй хамааралгүй амьдарч байна.”²

2001 онд шашин судлаач эрдэмтэн Роберт С.Фүллэр *Spiritual, But Not Religious*³ нэртэй ном бичсэн. Албан ёсны шашны байгууллагад хамааралгүй хувийн сүнс-лэг байдлыг эрэлхийлэх чиг хандлага хорин жилийн өмнө түлхүү байсан ч өнөөдөр ийм байхаа больжээ. Өнөө үед Нэгдсэн Улсын залуучуудын залбирах нь багасаж, Бурханд болон Библид мөн зарлигуудад итгэх итгэл буурчээ.⁴ Дэлхийн чиг хандлага бид бүхэнд, бүр

сонгогдсон хүмүүст хүртэл нөлөөлөх боломжгүй гэж бодох нь туйлын болчимгүй явдал болоод байна.

Бусдын бие, сэтгэл санаанд анхаарал халамж тавихад аминч бус, өр зөөлөн зүрх сэтгэлтэй байх шаардлагатай. Энэ анхаарал халамж бол сайн мэдээний нэгэн чухал хэсэг юм. Үүнийг Сүмд болон Сүмээс бусад газарт сайн хүмүүс болон итгэгчид, үл итгэгчдийн аль аль нь хийдэг. Дэлхий даяар олон гайхалтай, сайхан сэтгэлтэй хүмүүс байдаг ба бид тэднээс суралцах ёстой.

Гэвч зөвхөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хөрвөгдсөн гишүүн арай өөр тохинууллыг үзүүлдэг. Аврагчийн дагалдагчдын хувьд бидэнд найзынхаа итгэлийг сулрахаас сэргийлэн туслах, өрөөний найздаа Мормоны Номыг өдөр бүр унших нь үнэхээр гайхамшгуудыг авчирдгийг сануулах, тойргийнхоо гишүүнд жишгүүд нь зөвхөн дүрэм журам биш, харин биднийг Бурханд ойртуулж, бидэнд аз жаргал авчирдаг арга зам гэдгийг харуулах замаар тохинуулал хийх боломж бий.

Сайхан сэтгэлтэй хүн хэн нэгэнд дугуйгаа янзлахад нь тусалж, хөршөө эмчид аваачиж үзүүлэн, сэтгэлээр унасан хүнтэй өдрийн хоол хамт идэж эсвэл инээмсэглэн мэндчилснээр тухайн өдөр сэтгэлийг нь сэргээж чаддаг. Гэвч эхний зарлигийг дагагч нь үйлчлэлийн эдгээр чухал үйлдэл дээрээ зарлигуудыг сайн сахиж байгаа хүнийг урамшуулах, замаасаа хальтарч байгаа эсвэл нэгэн удаа аялж байсан

зам дээрээ эргэж гарахад нь тусламж хэрэгтэй хэн нэгний итгэлийг хүчирхэгжүүлэх ухаалаг зөвлөгөө өгөх гэх мэт үйлчлэлийг аяндаа нэмдэг.

Би та нарыг бие биедээ сүнслэг байдлаар тохинуулах хүчин чармайлтаа хүчирхэгжүүлэхийг уриалж байна. Сүнслэг байдлын хувьд тохинуулахыг жигнэмэг хийх, сагс тоглох зэргээс эхлүүлж болно. Эцэст нь энэ илүү ариун арга замаар тохинуулахад өөрийн сэтгэл зүрх, итгэлийг нээх, найзаасаа олж харсан эерэг өсөлт хөгжлийг нь магтаж урамшуулах мөн шавь байх жишигтэй нийцэхгүй зүйлийг харж, мэдрэхдээ санаа зовоож байгаагаа илэрхийлэхийг шаарддаг.

Зөвхөн өөрөө зөв шударга байгаад зогсохгүй, илүү ариун арга замаар тохинуулан, ялангуяа бусдын итгэлийг хүчирхэгжүүлж, сүнслэг байдлын хувьд зоригтой байцгаая. Танд санаа сэдэл төрүүлэх зорилготой дараах нөхцөлийг авч үзнэ үү. Үүнд:

- Найз тань ухаалаг утсан дээрээ тоглоом тоглоход маш их цаг зарцуулдаг хэрнээ сайн мэдээний сэдэвтэй холбоотой ярианд бараг оролцдоггүй болохыг та анзаарав.
- Танай тойргийн нэг гишүүн порнографын асуудалтай юм шиг танд санагджээ.
- Найзууд тань зохисгүй гэж үзэхээр зургуудыг авч, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тавихад олон цаг зарцуулж байна.
- Мормоны Номын тухай ярих дуртай байсан нэг хүн одоо энэ талаар огт дурдахаа больсныг та анзаарав.
- Ариун сүм явах дуртай байсан гэр бүлийн тань нэг гишүүн одоо явахаа бүр больжээ.
- Бошиглогчийн зөвлөгөөний талаар итгэлтэй ярьдаг байсан найз тань одоо түүнийг шүүмжлэх болсныг та анзаарав.
- Таны мэдэх эргэж ирсэн номлогч ариун сүмийн гэрээнүүдийг тусгасан хувцсандаа хайхрамжгүй ханддаг болжээ.



- Тойргийн тань гишүүн ням гарагт Сүмээс өөр газар явах шалтаг олдог болсныг та анзаарав.
- Найз тань жижиг сажиг зүйлс дээр шударга бус хандаж эхэлснийг та мэдрэв.
- Номлолынхоо дараа нүдэндээ галтай байсан ч одоо бүүдийсэн хүнийг та мэднэ.
- Та ариун нандин зүйлсийг доог тохуу болгон ярьдаг нэг найзтай.
- Болзооноосоо болж сэтгэлээр унасан найз тань “Бурхан надад хайргүй” гэж боддог болжээ.
- Зохистой байхаа больж, наманчлалаа хойшлуулж байгаа нь найзын тань итгэлд нөлөөлж байгааг та анзаарав.

Та эдгээр эсвэл эдгээртэй адил нөхцөл байдлыг төсөөлөн бодож чадах уу? Таны санаанд тодорхой нэрс орж ирж байна уу? Төлөөлөгч Паул “Бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь муу сүнслэг хүчний эсрэг билээ” (Ефес 6:12) хэмээсэн. Дэлхий дэх хамгийн агуу хэрэгцээнүүдийн нэг бол Тэнгэрлэг Эцэгт болон Түүний Хүү Есүс Христэд улам бүр итгэж, зарлигуудыг нь дагах илүү их хүсэлтэй байх явдал юм.

Нэг нэгээр нь тохинуулах

Хэрэв бид Аврагчийн загварыг дагах юм бол бидний ихэнх тохинуулал нэг хүнээс нөгөө хүнд хийгдэх болно. Худаг дээрх самари эмэгтэйд хандан Аврагч:

“Энэ уснаас уух хүн бүр дахин цангана.

Харин Миний өгөх уснаас уух хэн ч хэзээ ч цангахгүй гэхэд

эмэгтэй Түүнд, Эзэн, тэр усаа надад өгөөч. Тэгвэл би цангахгүй. . . .

[гээд эмэгтэй—Христ гэгч Мессиа ирэхийг би мэднэ.

Тэр ирэхдээ бүх зүйлийг бидэнд мэдүүлнэ гэв.

Есүс түүнд—Тэр чинь чамтай ярьж буй Би байгаа юм гэж айлдав” (Иохан 4:13–15, 25–26-г үзнэ үү).

Есүс Өөрийн бурханлаг байдлыг тунхаглахдаа ч гэсэн нэг хүнд тохинуулж байсан.

Хагарсан дугуйг нөхөхөөс ялгаатай нь ганцхан удаа тохинуулал хийснээр сүнслэг асуудлыг шийдэх нь ховор. Итгэлийг сэргээхэд цаг хугацаа, яриа хөөрөө, урам зориг өгөх туршлага хэрэгтэй. Энэ нь усны хоолойноос нэг удаа олгойдон гардаггүй, харин тэнгэрээс буух шүүдэр адил ирдэг. Та хэн нэгэнд Бурханд эргэн ирж,



Аврагчид болон Түүний Цагаатгалд дахин найддаг болоход нь туслахдаа ахин дахин тохинуулах ёстой.

Их Эзэний арга замаар тохинуулахын тулд бидэнд Ариун Сүнсний тусламж хэрэгтэй. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганаар энэ сэдвээр хүчтэй үг хэлсэн. Тэр “Гэвч ирэх өдрүүдэд Ариун Сүнсний заан чиглүүлж, удирдаж, тайтгаруулах, байнга хамт байх нөлөөгүйгээр сүнслэгээр оршин тогтнох боломжгүй байх болно”⁵ гээд,

“Би таныг хувийн илчлэлт хүлээн авах одоогийн сүнслэг ур чадвараа нэмэгдүүлэхэд урьж байна”⁶ хэмээн нэмж хэлсэн юм. Тэр бидэнд залбирч, сонсож, бодол санаагаа бичиж тэмдэглэн, үйлдэхийг зөвлөсөн.

Бид үүнийг илүү ариун арга замаар тохинуулахдаа хэрхэн хэрэгжүүлж болох вэ? Бүгдээрээ залбирч, сонсож, бодол санаагаа бичиж тэмдэглэн, чадах хүмүүстээ үйлдэл хийн тохинуулаарай.

Бусдын итгэлийг хөгжүүлэх боломжийн төлөө залбир. Та туслах хүн бүрээ танихгүй байж болно. Есүс Найн дахь бэлэвсэн эмэгтэйд тохинуулахынхаа өмнө, уг хот руу орохоор явж байсан билээ. Гэвч Тэр түүнийг хараад, ихэд өрөвдөн, хүүг нь үхлээс босгосон. Харин Түүний тохинуулал эмэгтэйн амьдралыг өөрчилсөн юм (Лук 7:11–15-ыг үзнэ үү).

Тохинуулах боломж хүлээн авахын төлөө залбирч, сонсож, бодол санаагаа бичиж тэмдэглэн, өөрийн зам дээр хүмүүсийг авчрах үйлдэл хийхэд бэлэн бай.

“Баруун тал уруу би харж ажиглалаа. Намайг тоох хэн ч алга. Надад хоргодох газар ч үлдсэнгүй. Сэтгэлийг минь эрэлхийлэгч нэг ч үгүй” (Дуулал 142:4) гэсэн Дуулал номын бичсэн хүний хашхиран хэлсэн үг миний сэтгэлийг үргэлж өвтгөдөг. Ийм мэдрэмж төрж байгаа хүмүүст тусалцаа.

Сүнсэнд зориулан цаг гарга

Бид Ариун Сүнсний тусламжийг хүлээн авахын тулд оюун ухаан, зүрх сэтгэлээ бэлдэх ёстой. Өнөө үед бид цахим хэрэгслээ ашиглахдаа сахилга баттай байж, хязгаартай ашигладаг байх хэрэгтэй болоод байна. Адам Алтэр *Irresistible (Няцаагүй)* хэмээх номондоо техник технологи, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн донтуулагч нөлөөний тухай ярьсан. Тэрээр Инстаграмын үүсгэн байгуулагч инженерүүдийн нэг болох Грэг Хочмутын хэлсэн үгээс эш татан, “Дарах хаштагууд гарч ирсээр л байна. Харин дараа нь энэ нь бие организм шиг өөрийн гэсэн амьдралтай болж, үүнд хүмүүс хэт донтож эхэлдэг”⁷ гэж хэлжээ.

Ноён Алтэр цааш нь “Инстаграм нь олон нийтийн мэдээллийн бусад хэрэгсэлтэй адил ёроолгүй нүх юм. Фэйсбүк мэдээллийг эцэс төгсгөлгүй өгдөг бол Нетфликст цуврал киноны дараагийн анги автоматаар гарч ирж, харин Тиндер хэрэглэгчид илүү сайн сонголтыг хайхад урамшуулдаг. ‘Загварын ёс зүй судлаач’ Тристан Харрисын хэлснээр, асуудал нь хүмүүст өөрийгөө захирах чадвар дутагдаж байгаад биш, харин дэлгэцийн нөгөө талд өөрийгөө хянах чадлыг тань нураахаар мянга мянган хүн ажиллаж байгаад оршиж байгаа юм”⁸ гэжээ.

Тэр мөн “Фэйсбүк, Инстаграм зэрэгт лайк дарах нь World of Warcraft mission тоглоомд оролцон, ялалт байгуулж шагнуулах эсвэл таны нэг жиргээг Твиттер дээрх олон хэрэглэгчтэй хуваалцахтай яг адилхан байдлаар

[баруун тархины мэдрэлийн] дохиоллын системд нөлөөлдөг. Техник хэрэгсэл, тоглоом, харьцах программ зэргийг шинэчлэн сайжруулдаг хүмүүс хийдэг ажилдаа гаршсан байдаг. Тэд аль нь ажиллаж, харин аль нь ажиллахгүй байгааг буюу аль дэвсгэр өнгө, үсгийн фонт, аудио дууны гаралт хүмүүсийн оролцоог нэмэгдүүлж, бухимдлыг багасгаж байгааг мэдэхийн тулд олон сая хэрэглэгч дээр мянга мянган туршилт явуулж байдаг. Тухайн программ хувьсан хөгжсөнөөр өмнөхөөсөө илүү сэтгэл татам, бүхий л талаараа өвч бүрэн зэвсэглэсэн хувилбар болж хувирдаг байна. 2004 онд Фэйсбүк зугаатай байсан бол [өнөөдөр] донтуулагч болоод байна”⁹ гэжээ.

Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгахын тулд бид Түүнд цаг зав, орон зай гаргаж өгөх ёстой. Ухаалаг утсаа хойш тавьж сурцгаая. Цахим хэрэгслээ зориуд ашиглахгүй байхаар цагаа төлөвлө.

2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган дээр Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын гүйцэтгэх ерөнхийлөгч М.Рассэлл Баллард: “Дэндүү олон хүн онлайнд бараг л амьдрах шахаж, ухаалаг төхөөрөмжөө өдөр шөнөгүй нүүрэндээ нааж, чихэндээ чихэвч зүүн, Сүнсний намуухан, зөөлөн дуу хоолойг хааж байна. Хэрэв бид цаг зав гарган, чихэвчээ холдуулахгүй л бол “Тэмцэлдэхээ больж, Бурхан гэдгийг минь мэд” [Дуулал 46:10] хэмээсэн Түүний дуу хоолойг сонсох боломжоо алдаж магадгүй. Бид Их Эзэний сүнсээр өдөөгдсөн шинэ үеийн техник технологийг ашиглах нь буруу биш ч тэдгээрийг ухаалаг ашиглах ёстой”¹⁰ хэмээн хэлсэн.



Бие биенээ хүчирхэгжүүл

Намайг БЯИС-д бакалавраар сурч байхад мөнхийн зүйлс дээр хэмжихийн аргагүй их нөлөө үзүүлсэн миний эхнэр Кэйтигээс гадна номлолын өмнө болон дараа нэг байранд хамт амьдарч байсан хоёр залуу сүнслэг үндэс сууринд маань асар их нөлөөлсөн юм. Нэг нь одоо БЯИС-д зохион байгуулалтын хэв шинжийн профессороор ажилладаг Рэйд Робисон байв. Би түүнтэй номлолд байхдаа танилцсан бөгөөд номлолынхоо дараа хамт нэг байранд амьдардаг байсан юм. Рэйдийн зарлигуудыг ёсчлон дагадаг, бошиглогчийг хайрладаг, Аврагчийн талаар гуйвшгүй гэрчлэлтэй зэрэг нь намайг болон эргэн тойрныхноо хүчирхэгжүүлдэг байсан.



Тэр 45 жилийн турш надад үлгэрлэсээр ирсэн.

Нэг байранд амьдарч байсан өөр нэг найзыг минь Тэррэл Бөрд гэдэг бөгөөд одоо АНУ-ын Ютагийн Сэйнт Жоржид амьдардаг. Би Тэррэлтэй АНУ-ын Айдахогийн Покателлогийн ахлах сургуульд хамт сурч байхдаа танилцсан юм. Бид сагсан бөмбөг хамт тоглодог байсан ч сүнслэг байдлын хувьд төлөвшсөн байсныг нь би олж харан, найзлах болсон билээ. Тэр өөрт төрсөн сүнслэг ойлголтыг мөн уншиж, судалсан амьдралын зарчмуудынхаа талаар нээлттэй хуваалцдаг байв. Би ийм зүйлийг 17 настай хүүхдээс сонсож байгаадаа гайхдаг байсан. Бид БЯИС-д нэг байранд орохоор шийдсэн юм.

Энэ үед бидэнд компьютер, бичгийн машин гэх мэт зүйл байдаггүй байв. Тэррэл өөртөө чухал санагдсан судар болон зан чанар төлөвшүүлдэг эшлэлүүдийг бичиж аваад, дараа нь дуртай үедээ эргэж харахын тулд жижиг хайрцганд хийж хадгалдаг байв. Түүний хувьд мянга гаруй судар, эшлэл цуглуулж, ихэнхийг нь цээжээр мэддэг байх нь гайхалтай зүйл биш байлаа. Хэдийгээр би өглөө бүр 4-өөс 7 цагийн хооронд номын санд цэвэрлэгээ хийдэг, хичээл ихтэй завгүй байсан ч Тэррэлийг харснаар өөрийн гэсэн эшлэлийн хайрцагтай болж билээ.

50-иад жилийн өмнө цээжилсэн ч одоо ч санаанд минь тодхон үлдсэн нэг эшлэлийг би дурдъя.

*Оюун ухаан бол хэвэнд оруулж, бүтээн цогцлоогч гол хүч.
Хүн бол оюун ухаан бөгөөд тэрээр
Бодол гэгч хэрэгслээр хүссэнээ урласнаар
Мянга мянган баяр баясгалан, хор хөнөөлийг авчирдаг.
Тэр нууцхан боддог ч энэ нь биелдэг...
Хүрээлэн буй орчин бол түүний бодлын толь юм.¹¹*

Мэдээж би бас дараах хүчтэй судрыг одоо ч санадаг:
“Амилал ба амь бол Би байгаа юм. Надад итгэдэг нь үхэвч амилна.
Надад амьдрагч хийгээд итгэгч бүхэн хэзээ ч үхэхгүй” (Иохан 11:25–26).

БЯИС-д шинэхэн оюутан байхад амьдралын маань туршид надад нөлөөлсөн судрын болон мэргэн ухааны үгсийг оюун ухаандаа нөөшлөн авахад Тэррэл надад тусалсан. Би өөрийн найз Рэйд Робисон, Тэррэл Бөрд нарт амьдралын маань чухал үед сүнслэг байдлын хувьд намайг хайрлан халамжилж байсанд талархаж явдаг.

Манай хөрш Томас Л.Кэйний бичсэн шүлгээс би та нартай хуваалцъя.

*Бусдад тусалж,
Үнэнээсээ халамжилдаг,
Сул доройг тосон авч,
Тэдний төлөө залбирдаг хүмүүсийн төлөө Бурхан Тандаа талархъя.
Зүрх сэтгэлийг мэдрэн,*



*Үгсийг нь сонсдог ба
Зөөлөн харц, тэврэлт
Бүх дэлхийгээс ч илүү чухал гэдгийг мэддэг хүмүүсийн төлөө Бурхан
Тандаа талархъя.
Унжсан гарыг өргөн,
Сүльдсан өвдгийг хүчирхэгжүүлдэг,
Бусдад үл таниулдаг тохинуулаараа
Бодгалийг сэргээдэг хүмүүсийн төлөө Бурхан Тандаа талархъя.¹²*

Эрхэм хүндэт найз нөхөд, шавь нар аа, би Аврагч амьд хэмээх баттай гэрчлэлээ та нарт үлдээж байна. Тэр амилсан. Тэр энэ ариун ажлыг удирдан явуулдаг. Ерөнхийлөгч Нэлсон бол дэлхий дээрх Түүний тослогдсон бошиглогч билээ. Дэлхий дээрх бидний энэ цаг хугацаа мөнхийн чухал ач холбогдолтой.

Та нар Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж, Түүний мутарт зэмсэг болохын төлөө залбирч, хүмүүст тохинуулж, илчлэлт хүлээн авах чадавхаа хөгжүүлэн, Ариун Сүнсний нөлөөнд итгэх юм бол Их Эзэн Өөрийн онцгой охид, хөвгүүдийг таны зам дээр тавих бөгөөд та нар тэдний тохинууллын тэнгэр элчүүд болж, амьдралыг нь мөнхөд адислах болно гэдгийг би амлаж байна. Та илүү ариун нандин арга замаар тохинуулах болно.

Та нарыг мөнх бус амьдралынхаа хамгийн чухал энэхүү замаар үргэлжлүүлэн явахад энэ бүхэн таны хувьд чухал байгаасай хэмээн би залбирч байна. Би Аврагчийг мөн Түүний хувьд та нар мөнхөд үнэ цэнтэй байна гэдгийг, тэрчлэн Тэрээр дахин ирж, Өөрийн охид, хөвгүүд болон шавийн хувьд биднийг тэврэн авна гэдгийг баттай гэрчилж байна. ■

2018 оны 4-р сарын 10-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “A Holier Approach to Ministering (Илүү ариун арга замаар тохинуулах хандлага)” үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. Jean M. Twenge and W. Keith Campbell, *The Narcissism Epidemic: Living in the Age of Entitlement* (2009), 1.
2. Jean M. Twenge, *iGen: Why Today’s Super-Connected Kids Are Growing Up Less Rebellious, More Tolerant, Less Happy—and Completely Unprepared for Adulthood* (2017), 121; мөн 5.1, 121-р хүснэгтийг үзнэ үү.
3. Robert C. Fuller, *Spiritual, But Not Religious: Understanding Unchurched America* (2001)-ийг үзнэ үү.
4. Jean M. Twenge, *iGen*, 119–142-ыг үзнэ үү.
5. Рассэлл М.Нэлсон, “Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт,” *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 119.
6. Рассэлл М.Нэлсон, “Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт,” 120.
7. Greg Hochmuth, in Adam Alter, *Irresistible: The Rise of Addictive Technology and the Business of Keeping Us Hooked* (2017), 3; see also Greg Hochmuth, in Natasha Singer, “Can’t Put Down Your Device? That’s by Design,” *The New York Times*, Dec. 5, 2015, nytimes.com.
8. Adam Alter, *Irresistible*, 3; мөн Tristan Harris, in Natasha Singer, “Can’t Put Down Your Device? That’s by Design”-ийг үзнэ үү.
9. Adam Alter, *Irresistible*, 5.
10. М.Рассэлл Баллард, “Бурханы үнэ цэнтэй бэлгүүд,” *2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 7.
11. James Allen, *As a Man Thinketh* (1902), frontispiece.
12. Thomas L. Kay, “Saints,” in *The Road I’ve Taken* (2016), 16; see also “Saints,” music by Rachel Bastian, *New Era*, Sept. 1999, 51.



Бусдад Их Эзэний эдгээлтийг ХҮЛЭЭН авахад туслах нь

Мэррилий Браун Бояк

Би нэгэн ням гарагт “Үнэнээр, үнэнээр, би та нарт хэлнэ, энэ бол миний сайн мэдээ; мөн миний сүмд хийх ёстой зүйлүүдээ та нар мэднэ; *учир нь миний хийснийг та нар харсан, бүр түүнийг та нар хийх болно*” (3 Нифай 27:21; тодотгол нэмэгдсэн) гэх судрыг уншаад, “Христ дэлхий дээр ямар ажил хийсэн юм бол?” гэж бодож билээ. Надад хамгийн түрүүнд үйлчлэх, эдгээх гэсэн хоёр зүйл санаанд орж ирсэн. Би үйлчилж чадна, харин хэрхэн эдгээх билээ? Мэдээж, би бусдыг эдгээж чадахгүй эсвэл чадах ч байсан юм болов уу?

Би саяхан хүнд хэлбэрийн харшлын хариу урвалаас болж мэс засалд ороод, эдгэрэх шатандаа орсон байсан юм. Дараа нь би эдгэрэх явцад маань тусалсан хүмүүсийн тухай бодсон. Тэдний нэрийн жагсаалт урт байв. Хэрэв тэд намайг эдгээж чадсан юм бол би бас бусдыг эдгээж чадахгүй гэж үү?

Бид бүгдээрээ эдгээх урлагт суралцаж чадна.¹ Бидний эргэн тойронд бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын хувьд өвдөн, зовж шаналж байгаа хүмүүс олон бий.

Өвчтэй хүмүүсийг эргэх нь

Мозая 4:26-д “Та нар хүн бүр байгаагийнхаа хэрээр ядуустай хөрөнгөө хуваалцаасай хэмээнэ би, өлссөнийг хооллох, нүцгэнийг хувцаслах, өвчтэйд очиж мөн сүнсийг нь мөн биеийг нь ч аль алиныг нь, хүссэнийх нь дагуу тэднийг асрах зэрэг болой” хэмээн цэдэглэсэн байдаг.

Бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын хувьд өвдөхөд хүн маш их ганцаарддаг. Хүмүүс эдгэрэх гэж олон цагийг унтлагынхаа эсвэл эмнэлгийн өрөөнд ганцаар өнгөрүүлдэг ба сэтгэл санааны хувьд хямрахад ч амархан болдог. Харанхуйлах үед нь санаа тавьдаг найз нөхөд, гэр бүлийн гишүүд айлчлан ирэх нь тэдний амьдралд гэрэл гэгээ авчирдаг.

Бидний өвчтэй хүмүүсийг *хэрхэн* эргэж тойрдог байдал мөн л чухал зүйл юм. Эдгэрэх явцад нь хүмүүс хэрхэн тусалсан талаар хэдэн эмэгтэйгээс асуухад тэд ийн хариулсан. АНУ-ын Аризонад амьдардаг Жуди “Хүнд хэцүү цагт сонсох хүнтэй байх, сонсоод шүүхгүй байх нь хамгийн сайн тусламж болдог. Тэвчээртэйгээр, чин сэтгэлээсээ, хайраар сонсох нь эдгэх гэж хичээж буй хүмүүст хамгийн үнэ цэнтэй дэмжлэг үзүүлдэг.

Бид бие махбод, сэтгэл санаа, сүнслэг байдлын хувьд өвдөн, зовж шаналж буй хүмүүст Их Эзэний эдгээх адислалыг авчирч тусалснаар эдгээх урлагт суралцдаг.

АНУ-ын Калифорнид амьдардаг Линдаг найз нь эргэж ирсэн явдал өөрт нь хэчнээн их тусалсан талаар тэр хуваалцахдаа “Миний амьдралд онцгой үүрэг гүйцэтгэсэн, ялангуяа чин сэтгэлээсээ сонсож, Сүнсийн гайхалтай зөвлөгөөг дамжуулан өгч байсан хүмүүсийг би огтхон ч мартдаггүй. Гучин настай байхдаа бага

насны таван хүүхэдтэйгээ бэлэвсрэн үлдсэнийхээ дараа би сайн найз Кареньхаа ачаар Тэнгэрлэг Эцэгийн болон Аврагчийн хайрыг илүү гүн гүнзгий мэдэрсэн. Түүний ‘сонсдог чих’ үргэлж онгорхой, нээлттэй байдаг байсан. Бурханы охидын хувьд бид хоорондоо гайхалтай харилцаа холбоотой гэдгийг тэр надад байнга сануулдаг байсан тул би хэзээ ч ганцаардаж байгаагүй” гэжээ.

Ялангуяа тохинуулагч ах, эгч нар энэ эдгээх урлагийг эзэмшиж чадна. Зовж шаналсан хүмүүсийн хэрэгцээг ойлгох нь чухал. Заримдаа тэд маш их ядарсан байдаг тул богинохон айлчлал хийх нь тохиромжтой байдаг. Харин заримдаа тэд ганцаардаж, уйдсан байдаг тул илүү удаан хамт байхаар айлчлах нь хэрэгтэй байж болно. Бас тэдний ааш занд нийцүүлэх нь чухал байж болох юм. Зарим нь их ярьж, дэмжлэг тусалцаа хүсдэг байхад, зарим нь нам гүм, чимээгүй байхыг хүсдэг. Бид эхлээд тэдний хэрэгцээ шаардлагыг тодорхойлсныхоо дараа олж мэдсэн зүйлийнхээ дагуу тусламж үзүүлэх хэрэгтэй.

Нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх нь

Алма Мормоны Номон дээрх итгэгчдээс “Бурханы хороонд орж, мөн нэг нэгнийхээ ачааг хөнгөн байж болохын тулд мөн түүний хүмүүс гэж нэрлэгдэх хүсэлтэй байж, үүрэлцэхэд бэлэн” (Мозая 18:8) байгаа эсэхийг асуухдаа Аврагчийн үлгэр жишээг дагана хэмээн өгсөн бидний амлалтыг хамгийн уран цэцэн үгээр дүрслэн хэлсэн.



БИД ИХ ЭЗЭНИЙ МУТАР БИЛЭЭ

“Бусдад хэрхэн төгс
үйлчлэхийг Христ
л хамгийн сайн
мэддэг. Аврагч тус-

ламжийн гараа сунгахад Түүний гарт
хүрсэн хүмүүс урам зориг орж, илүү
хүчирхэгжин, улмаар зөвт хүмүүс
болон хувирдаг.

Хэрэв бид түүний гар юм бол
Түүний хийх байсан зүйлсийг хийх
ёстой биш гэж үү?”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч
Дийтр Ф.Угдорф, “Та нар миний гар,” 2010
оны 4-р сарын Ерөнхий чуулган, 83.

Бидний хүн нэг бүр ямар нэгэн ачаа үүрч
явдаг. Харин сэтгэцийн өвчнөөс эсвэл сүнс-
лэг саад бэрхшээлээс болж өвдөж зовох үед
үүнийгээ үүрч явахад хамгийн хэцүү байдаг.
Эдгээх урлагийн нэг чадвар бол бусдыг зовж
шаналах үед ачаанаас нь үүрэлцэх явдал юм.

АНУ-ын Юта мужид амьдардаг Шаннон
хөршүүд нь түүнд хэрхэн тусалсан талаар
“Бид хүүгээ оршуулсан өдөр оршуулгын
газраас ирэхэд хөршүүд маань бидний эзгүйд
цугларан, хашаанд маань цэцэг суулгасан
байхыг олж харсан. Тэд үзэсгэлэнт бут сөөг,
мод, цэцэгс, тэр байтугай шинэ ширэг хүртэл
тарьсан байв. Төсөөлөхийн аргагүй гуниг
зовлонд автсан үед тэд бидэнд хайр, дэмжлэг
тусалцаагаа бодитоор харуулсан явдал бид-
ний эдгэрэх явцыг эхлүүлсэн юм. Жил бүр
үзэсгэлэнт цэцэрлэг минь хайр болон амьд-
рал мөнх гэдгийг бидэнд сануулдаг. Энэ нь
бидний хувьд мартагдашгүй ариун нандин,
чухал утга учир бүхий туршлага болсон юм”
гэж хуваалцав.

Хөхний хорт хавдартай гэж оношлогдох
үедээ би Халамжийн нийгэмлэгийн ерөнхий-
лөгчөөр үйлчилж байсан ба хотынхоо зөвлө-
лийн дахин сонгуульд өрсөлдөж байв. Нөхөр
маань ажилгүй болж, бид энэ үед өөр олон
хүнд сорилттой тулгарсан юм. Зөвлөхүүд
маань “нэг нэгнийхээ ачааг үүрэлцэх” гэсэн
үгийг ажил хэрэг болгон, миний үүрч байсан

ачаануудыг хуваарилж туслав. Бишоп миний зарим үүргийг өөрөө
хариуцаж авсан юм. Нөхөр минь хоол хийх, гэрийн ажлаа амжуу-
лах гээд олон үүргийг гүйцэтгэх болов. Миний ачааг авахын оронд
эдгээх урлагийг эзэмшсэн олон олон хүнд хуваарилж өгснийг харах
нь намайг үнэхээр даруусгасан.

Тайтгаруулах нь

Алма бас Христийн дагалдагчид “гашуудах тэдний хамт гашуу-
даж . . . мөн тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулахад бэл[эн]”
(Мозая 18:9) хэмээн заасан.

Тайтгаруулахад бусдын зовлонг ойлгодог чанар, нинжин сэтгэл,
анхааралтай байх, халамж, хайр, энэрэл зэрэг багтдаг. Энэ нь өвдөж,
зовсон хүмүүст зовлонгоо даван гарахад нь туслахаар тэднийг хай-
рын мутраар өлгийдөн авахыг хэлнэ.

Луанн (нэрийг нь өөрчлөв) сүнсэлэг болон ёс суртахууны асуу-
далтай тулгарсан ба өөрийн туршлагын талаар ярихдаа тайтга-
руулсан хүмүүсийнхээ талаар “Тэд намайг одоо байгаагаар минь
бус, харин илүү агуу, ухаалаг, сайхан сэтгэлтэй болох чадавхыг
минь олж харсан юм. Би заримдаа өмнө нь хэн байснаа эргэн
санахдаа мунхаг байдал, өөрийн хийсэн буруу үйлдэл, нүгэлт зам
зэргээсээ болж ичиж, газар доогуур орчихмоор санагддаг. Гэвч
ичгүүр, гутамшгийг үргэлж ач ивээл, нигүүлсэл, өршөөл, хайр
гэгч эдгээгч гавар дагалдаж байдаг. Миний эргэн тойронд ийм

“Тэд миний эргэн той-
ронд Аврагч, Эдгээгч
Эзэн над дээр ажиллаж
болох аюулгүй орчныг
бүрдүүлж байсан.”

хүмүүс байгааг харах үед
тэр мэдрэмж алга болдог
юм. Тэд бас намайг эдгэ-
рэхэд тусалж байсныг би
одоо олж хардаг. Магадгүй,
тэд миний эргэн тойронд
Аврагч, Эдгээгч Эзэн над
дээр ажиллаж болох ач
ивээлийн бүрхүүл болон

аюулгүй орчныг бүрдүүлж байсан гэж хэлэхэд илүүдэхгүй биз.
Тэрээр намайг өөрчилсөн. Мөн миний зүрх сэтгэлийг өөрчилсөн
юм” гэж хуваалцажээ.

Өвчтөнийг тайтгаруулахын чухал хэсэг бол тэднийг Эдгээгч
Эзэн рүү хандуулах явдал юм. Ютад амьдардаг Сабрина: “Бурханыг
хайж олоход эсвэл Түүнд эргэн очиход тусалдаг хүмүүсийн эдгээх
хүчээс өөр сайн зүйл гэж үгүй. Энэ нь таны аль хэдийн мэддэг
зүйлийг буюу шаардлагатайгаас илүү ихээр өөртөө хатуурхаж, бүх



зүйлийг өөрөө хийх гэж хичээн, Бурханд бүрэн дүүрэн найдахгүй байгааг тань сануулж байж болно.

Өвчтөнийг тайтгаруулж, тэдэнд туслахын тулд Сүнсэнд мэдрэмтгий байх хэрэгтэй. Нэг хэсэг би хэдэн сарын турш шөнөдөө хоёр, гуравхан цаг дугхийн, сайн унтаж чадахаа больсон байсан. Би сэтгэлийн түгшүүрт автаж, ядарч туйлдсанаасаа болон ихэд зовж, олон эмч дээр очсон ч үр дүн гарахгүй байв. Эцэст нь найз минь намайг хожмын үеийн гэгээнтэн эмч рүү явуулж, тэр шууд зөв онош тавьсан юм. Харин дараа нь түүний хэлсэн үг намайг гайхшируулсан. Эмч: “Мэррилий, хамгийн чухал зүйл бол чи зовлонгоо Бурханд шилжүүлэн өгөх хэрэгтэй” гэж хэлсэн. Тэр дараа нь намайг өдөр бүр “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл” номоос уншсан зүйл дээрээ хэсэг зуур бясалган бодох талаар урамшуулав.

Ийнхүү бясалгал хийх гэж хэд хэдэн удаа оролдоод бүтэлгүйтсэн ч би эдгэрэхийг үнэхээр хүсэж байлаа. Маргааш нь би “Бид Түүний зүйрлэшгүй амьдрал болон агуу их цагаатгах золиослолын хязгааргүй ач тусын бодит үнэнийг гэрчилдэг”² хэмээх хүчирхэг үгсийг дотроо бясалган бодов. Агуу Эдгээгчийнхээ талаарх гэрчлэлийн тухай тунгаан бодож эхлэхэд би баяр хөөрийг мэдэрч, бодгаль минь тайтгарч, амар амгалан болсныг мэдсэн.

Анхаарал халамж тавих нь

Бид Есүсийн эдгээгч үйл хэргийн үлгэр жишээг дагахын тулд судраас суралцах явцдаа, Тэрээр эргэн тойрныхоо хүмүүст анхаарал халамж тавьдаг байсан хэмээх нэг зүйлийг ахин дахин хийдэг байсныг олж харах боломжтой.

Христ хүмүүсийг анзаардаг байсан. Тэрээр соёлын хорио цээрийг үл хамааран самари эмэгтэйтэй ярьж, цаг гарган хүүхдүүдийг адисалж, татвар хураагч болон нүгэлтнүүдтэй хооллож, уяман өвчтэй, орон гэргүй хүмүүст тохинуулж байв. Тэр хүн бүрд анхаарал тавьдаг байсан.

Христийн эдгээх урлагт суралцахаар хичээж буй дагалдагчдын хувьд бид хүмүүсийг Христийн мэлмийгээр хардаг болж эхлэх хэрэгтэй. Бид хүмүүстэй мэндлэх, инээмсэглэх, тэдний өдөр ямар байгааг асуухад цаг гаргах ёстой. Бидний гаргасан хүчин чармайлт эргэн тойронд маань байх ганцаардсан, сэтгэлээр унаж, өвчин туссан, сул дорой эсвэл зовж шаналсан хүмүүст эдгээгч гавар нь болох эсэхийг бид хэзээ ч хэлж мэдэхгүй. Хайрын энгийн үйлдэл ч гэсэн хүчтэй нөлөө үзүүлэх чадалтай.

Христийн ажлыг хийж, бусдыг эдгээх ажилд оролцсоноор бидэнд агуу адислалууд урсан ирэх болно. Христийн тунхагласнаар “Та нар эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь, тэр байтугай хамгийн дордод нь тийнхүү хандсан бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40). Бидний хүн нэг бүрийг эдгээсэн, бидний мэдэж байгаагаас ч олон удаа Өөрийн хайрын мутраар тэврэн авсан, Цагаатгалынхаа эдгээгч гаврыг бидэнд өгсөн Түүнд бид өөрсдийн ах дүүсийг эдгээн туслахын тулд өчүүхэн гэлтгүй хүчин чармайлтаа өргөл болгож чадна. Энэ бол жинхэнэ эдгээх урлаг билээ. ■

Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. “Lord, I Would Follow Thee,” *Hymns*, д. 220-ыг үзнэ үү.
2. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, хавтасны дотор талд.

Цэцэгс ба санхүүгийн хувьд баталгаатай болсон нь

Мичэл Волл

Их Эзэн миний чадавхыг өсгөн нэмэгдүүлж, чадваруудыг дээшлүүлж, өөрийн минь чадлаар хүрч чадахгүй өндөрлөгт намайг хүргэсэн.

Коллеж төгсөөгүйдээ би үргэлж сэтгэл дундуур явдаг байв. Нөхөрт маань ямар нэг зүйл тохиолдвол гэр бүлээ санхүүгийн хувьд тэтгэж чадахгүй гэдгээ би мэддэг байлаа.

Гэтэл нэгэн аймшигтай зүйл болсон юм. Би цочирдмоор, зүрх эмтрэм утасны дуудлага хүлээн авав.

Осолд орсон нөхөр минь “911 рүү утасд! Би тракторт дарагдчихлаа!” гэж хашхирлаа.

Би тусламж дуудсаныхаа дараа АНУ-ын Арканзасын Пий Ридж дэх эдлэн газартаа хайрган зам дээр яваа түргэн тусламжийн машинуудыг гүйцэж түүрүүлэн, түүний цэвэрлэж байсан газарт рекорд тогтоох хугацаанд амжиж ирсэн юм. Барри амьд байсан ч бүтэн эргэсэн тракторын хөдөлгүүрийн доор дарагдсан байв.

Онцгой байдлын ажилчид гидравлик аврах машиныг ашиглан, тракторыг дээш өргөн, Барриг чөлөөлж гаргалаа. Дизель түлшинд норсон түүний хоёр хөл хэд хэдэн газраар хугарсан харагдав. Түүнийг гэмтлийн төв рүү яаралтай авчран, тэнд хөлийнх нь рентген зургийг авахуулахаас өмнө санваарын адислал өгсөн юм.



Ямар ч яс хугаараагүй байсанд бид гайхсан ч Барригийн нэг хөл ар талаараа дизель түлшинд гүн түлэгдсэн байлаа. Дарагдсанаас болж үүссэн бяцрал гэмтэл бөөрийг нь хордуулсан байв. Түүний амь нас дээсэн дөрөөн дээр байлаа.

Барри хүнд байдалтай таван өдрийг эмнэлэгт өнгөрүүлсний дараа түүний хордлогын түвшин буурч эхлэв. Дараагийн хэдэн сарыг боолт солих, арьс нөхүүлэн суулгах, мэс засал хийлгэх, өндөр даралтат хүчил төрөгчийн эмчилгээнд орох зэргээр өнгөрүүлсэн юм. Барри биеэ хангалттай сайжирсны дараа гэрээсээ борлуулалтын ажлаа дахин хийж эхлэв.

“Хэн ч намайг ажилд авахгүй”

Энэ үйл явдал намайг нойрноос минь сэргээсэн юм. Би Барри байхгүй бол юу хийж болох вэ гэж дараагийн хэдэн жил бодох зуураа сайн дурын ажил хийн, семинаруудад оролцож, хэд хэдэн хагас цагийн ажилд анкет бөглөж үзэв. Гэвч надад зах зээлд тохирсон ур чадвар байгаагүй тул хэн ч намайг ажилд авахгүй байлаа.

Бид хэдэн малаа бэлчээрт гаргадаг фермдээ түшиглэн амьдардаг байсан тул би фермийн чиглэлээр амьжиргаагаа олохоор судалгаа хийж эхлэв. Нэг өдөр надад цэцгийн талаар санаа орж ирэх нь тэр. Цэцгийн аж ахуйг судлаад, оролдож үзэхээр би шийдлээ. Би цэцэг тариалагчдын чуулганд явж, бэлчээрээс ургамал тариалах газраа бэлтгэв. Дараа нь би 2016 оны 11-р сард бие даах чадвар хөгжүүлэх үйлчлэлийн төвийн Хэрхэн хувийн бизнес эхлүүлж, хөгжүүлэх ангид бүртгүүлсэн юм.

Өөрийн гэсэн цэцгийн дэлгүүр

Арван хоёр долоо хоногийн курс хичээл надад хэрэгтэй байсан яг тэр зүйл мөн байв. Надад бизнесийн үндсэн төлөвлөгөө бас олон сайхан санаа байсан ч зохион байгуулалт дутагдаж байлаа. Өмнө нь бодож байгаагүй санаанууд ангид байхад орж ирдэг байсан. Би ч тэдгээрийг нэг нэгээр нь хэрэгжүүлсэн юм. Эхний жилдээ цэцгээ ургуулан, зарж эхлэхэд ангид мэдэж авсан санал зөвлөгөө, зарчмууд маш их хэрэг болсон.

- Би бага хүүтэй бизнесийн зээл авсан.
- Би зах зээлийнхээ хүрээг фермерийн зах зээл, цэцгийн дэлгүүрүүд зэргээр тэлсэн.
- Би үйлчилгээгээ өргөтгөх зорилгоор аж ахуй дээрээ хэд хэдэн үйл ажиллагаа зохион байгуулсан.

2017 оны сүүлээр, тариалж эхэлснээс хойш нэг жилийн дараа, цэцгийн дэлгүүрүүдээр явж зарахад хэт их цаг зарцуулж байгаагаа би ойлгосон юм. “Яагаад өөрийн гэсэн цэцгийн дэлгүүр нээж болохгүй гэж?” гэж би өөрөөсөө асуув. Орон нутгийн цэцгийн дэлгүүр үүдээ барьж, барилга нь хоосрон хаягдсан байв. Нөхөр бид хоёр дэлгүүрийг худалдан авч, засаж янзлан, хажуугаар нь уран зураг, орон нутгийн гар урлалын зүйл бас зардаг цэцгийн дэлгүүр нээлээ. Үүнээс гадна, би ургамлын түрээсийн болон ногоон ургамлын дотоод засал чимэглэлийн дизайны бизнестэй болов.

Би цэцгээ дэлгүүртээ болон кофе шоп, хувцасны дэлгүүр, орон нутгийн онгоцны буудлын мухлагуудад зардаг. Би өдөр бүр өөрт хэрэгтэй ургацаа л хураан авдаг юм.

Их Эзэн анхаарал халамж тавьдаг

Их Эзэн миний бизнест анхаарал халамж тавьдаг гэсэн гэрчлэл надад бий. Тэр надад санхүүгийн хувьд хөл дээрээ зогсож мөн боломжтой цагаараа ирж ажиллах сонирхолтой хэдэн эмэгтэйд болон хичээлийнхээ хажуугаар ажиллаж гэсэн оюутнуудад зориулан ажлын байр бий болгоход тусалсан. Охидын маань нэг нь цэцгийн аж ахуйгаа зохицуулж, хөвгүүдийн маань хоёр нь ногоон байгууламж барихад туслах гэх мэтээр фермийн ихэнх ажлыг хариуцан хийдэг. Харин Барри оройн цагаар болон амралтын өдрүүдэд хүнд зүйлс өргөж, зөөхөд тусалдаг.

Бид бүгдээрээ бие биенээ дэмжиж, хамтарч ажилладаг. Үүнд гар бие оролцсон бүх хүн адислагдсан. Хэдийгээр надад зав тийм их гараад байдаггүй ч гэр бүл, Сүмийн дуудлага, тохинууллын ажил үүрэг, сайн дурын ажил хийхэд би үргэлж цаг зав гардаг.

Үр, булцуу суулгахаас эхлээд цэцгээ үйлчлүүлэгчдийн гар дээр тавих хүртлээ ажиллах нь надад асар их зүйлийг хийж чадсан гэсэн гайхалтай мэдрэмжийг өгдөг. Их Эзэн миний чадавхыг өсгөж, өөрийн чадлаар хэзээ ч хүрч чадахгүй байсан өндөрлөгт намайг хүргэсэн гэдэгт би огтхон ч эргэлздэггүй. ■

Зохиогч нь АНУ-ын Арканзаст амьдардаг.

Марта, Мариа хоёр

Камилла Фронк Олсон

Бригам Янгийн Их Сургуулийн эртний судар судлалын чөлөөндөө гарсан профессор

Бидний ямар арга замаар үйлчлэхээр сонгодгоос үл хамааран Христийг бүх зүрх сэтгэл, оюун ухаанаараа хүлээн авч, дагах нь нэн чухал юм.

Иерусалимд Аврагчийн хэн гэдэгт олон хүн эргэлзэж байх үед Есүс “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал тэр нь энэ сургаалыг мэднэ” (Иохан 7:17) хэмээн заасан. Хэрэв бид сургаалыг өнгөцхөн судлахаас илүүтэй Есүс Христ гэж хэн болохыг олж мэдэн, Түүний шавь болохыг хүсвэл итгэлээ үйлдэл болгох ёстой. Марта, Мариа хоёрын түүх бид өөрсдийн амьдралд нэгээс олон арга замаар Аврагчид үйлчлэх боломжтой гэдгийг харуулдаг.

Энэ номлолынхоо дараахан Есүс болон Түүний зарим шавь Бетандахь Мартагийн гэрт сайн мэдээг заахаар очдог. Марта дүү Мариагаа Есүсийн хөлд суун, үгийг нь сонсож байх үед найрсаг гэрийн эзэгтэйн хувьд зочдыг хоол ундаар дайлж, тав тухтай байлгах үүргийг хариуцаж байсан байж болох юм. (Лук 10:38–42-ыг үзнэ үү.) Эгч, дүү хоёрын Багшид үйлчилсэн хоёр өөр арга зам нь шавь гэдгээ өөр өөр байдлаар илэрхийлж буй хүмүүсийг хүндлэх хэрэгтэй гэдгийг бидэнд заадаг. Мөн энэ түүхэн дэх Есүсийн сургаал эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил

хэрхэн үйлчлэхээ болон шавь гэдгээ харуулах арга замаа өөрсдөө сонгох эрхтэй гэдгийг харуулдаг.

Өгөх замаар үйлчлэх

Лук Марта, Мариа хоёрыг танилцуулахынхаа өмнөхөн сайн самари хүний сургаалт зүйрлэлийг бичсэн байдаг. Уг түүхэнд тусламж хэрэгтэй хүмүүсийг хооллож ундлан, орон байраар хангаж, харж хандсанаар бусдад нигүүлсэнгүй хандахыг Аврагч бидэнд заасан (Лук 10:30–37-г үзнэ үү). Марта итгэлээ үйлдэл болгон, “үйлчлэх ажилдаа” (Лук 10:40) хичээл зүтгэл гаргаснаар уг зарчмыг хүлээн авч, өөрийнхөө ойлгосноор дагаж байгааг харуулдаг.

Есүс хамгийн агуу нь бусдадаа тохинуулдаг хэмээх Өөрийн сургаалыг харуулахын тулд (Матай 20:26–28; Лук 22:26–27) амьдралаа үйлчлэлд зориулсан. Харин Марта Түүнд үйлчлэх хүслээрээ хариу барьсан. Марта, Мариа хоёрын түүх үйлчлэх, суралцах гэсэн хоёр арга замаар жинхэнэ итгэлээ болон шавь гэдгээ харуулсан хоёр эмэгтэйн талаар өгүүлдэг. Марта үйлчлэлээр дамжуулан Христийг хайрладгаа үзүүлсэнтэй адил бид ч

гэсэн Аврагчаа хайрлах хайр болон Түүний сайн мэдээнээс суралцаж, дагах хүсэл эрмэлзэл дээр төвлөрсөн үйлчлэлийг эргэн тойрныхондоо үзүүлж чадна.

Бид үйлчилж байхдаа, үйлчлэх олон арга зам байдаг бөгөөд өөр арга замаар үйлчилж байгаа хүмүүсийг шүүх ёсгүй гэдгийг санадаг байх хэрэгтэй. Марта “түүрт[сэндээ]” (Лук 10:40) уурлаж, Аврагчийн айлчлах болсон сайн үйл хэрэгт заналхийлжээ.

Хэдийгээр Марта зочломтгой, хариуцлагатай байсан ч завгүй байгаадаа хэт ач холбогдол өгч, бухимдсан байна. Тэр Есүст “Эээн, дүү минь үйлчлэх ажилд намайг ганцаар орхисныг Та анзаарахгүй байна уу? Надад тусал гэж түүнд хэлээч” (Лук 10:40) хэмээн гомдолложээ. Түүний дургуйцэл ганцаархнаа үйлчилж байна гэсэн бодлоос нь үүдэн гарсан байв. Тэр тухайн үед бусдын үзүүлж байсан үйлчлэлийн өөр бусад хэлбэрийг, тухайлбал Мариагийн болон Аврагчийн үйлчлэлийг олж харахгүй байв. Марта өгөх зарчмыг харуулсан ч гэлээ, түүний хандлага Сүнстэй нийцэхгүй байсан юм. Өнөө



Бид Марта, Мариа хоёрын жишээг өөрсдийн амьдралд хэрэгжүүлж, ямар арга замаар үйлчлэх нь хамгийн тохиромжтой болохыг мэдэхийн тулд Сүнсний удирдамжийг хүсэн гуйж болно.

үед бид өөрсдийн амьдралд үйлдлээрээ *мөн* хандлагаараа бусдыг хайрлах хайраа харуулж чадна.

Хүлээн авах замаар үйлчлэх

Есүс “Марта, Марта, чи мөн ч олон зүйлд санаа тавьж үйлээ үзэх юм даа” (Лук 10:41) хэмээн Мартагийн хичээл зүтгэл гарган үйлчилснийг хүлээн зөвшөөрч, үүнээсээ болж бухимдаж байгааг нь хэлжээ. Аврагчийн үг Мартагийн зочилж дайлах замаар үзүүлсэн үйлчлэлийг үнэлээгүй зүйл биш бөгөөд харин Мариагийн сонсож, суралцах замаар үйлчлэх сонголтыг хүлээн зөвшөөрснийг илтгэсэн юм. Түүнийг дагах хүсэлтэй бүх хүний хувьд Мариагийн үйлдэл ямар арга замаар үйлчлэхээ бусдаас үл хамааран сонгох нь илүү чухал болохыг бидэнд харуулдаг.

Мариа Аврагчийн үгийг хүлээн авснаар өөртөө үйлчлүүлэх боломжийг Түүнд олгосон. Бид Сүнсээр суралцаж, өсөж хөгжихийн тулд Аврагчийн хөлд суух замаар Түүнд хайраа харуулж болно гэдгийг Мариагийн жишээ харуулдаг.

Ганцхан л юм хэрэгтэй

“Ганцхан л юм хэрэгтэй” (Лук 10:42) гэдгийг хүлээн зөвшөөрөх нь Мартагийн зөрчилдөөний хариулт байв. Энгийн байдлын гүн гүнзгий нөлөөлөх хүчийн талаар энд өгүүлсэн ч *энгийн* гэдэг нь бидний хүн нэг бүрийн хувьд өөр өөр утгатай байж болно. “Хэрэгтэй” байхын жишгийг үр дүнгээр биш, харин үйлдлээр хэмждэг. Үйлчлэхээр сонгосон арга замаас үл хамааран хамгийн чухал зүйл юу вэ гэвэл Христийг бүх зүрх

сэтгэл, оюун ухаанаараа хүлээн авч, дагах явдал юм.

Заримдаа “Мартагийн арга замаар” үйлчлэх нь зөв, харин заримдаа “Мариагийн харуулсан” байдлаар эсвэл бүр энэ хоёрын аль алинд нь орохгүй өөр арга замаар үйлчлэх нь ч хамгийн тохиромжтой байж болно. Бид Марта, Мариа хоёрын жишээг өөрсдийн амьдралд хэрэгжүүлж, ямар арга замаар үйлчлэх нь хамгийн тохиромжтой болохыг мэдэхийн тулд Сүнсний удирдамжийг хүсэн гуйж болно.

Өөрсдийн сонгосон арга замаар үйлчлэх үедээ Түүнийг дагана гэсэн итгэл үнэмшил маань юу юунаас чухал гэдгийг санаж, өөрсдийн хандлагад анхаарлаа хандуулцгаая. Бид Аврагчийн хөлд өөрсдийгөө үргэлж байлгах болтугай. ■



Тэргүүлэх
бишопын зөвлөлийн
нэгдүгээр зөвлөх
Бишоп
Дийн М.Дэйвийс

Тэнгэрээс удирдуулсан шавь байх нь

Хэрэв та бидний хайрт Аврагчийн жинхэнэ шавь байхыг эрэлхийлбэл тэнгэрийн Бурхан Их Эзэн замыг тань зааж чиглүүлэх болно.

Би залуудаа хариултуудыг нь олж мэдэхийг хүсдэг байсан хоёр асуултаа энд тавимаар байна. Нэгдүгээрт, хэрэв та амьдралаа Бурханы үйлчлэлд зориулбал Тэр таны алхмыг удирдан чиглүүлж, Өөрийн зөв шударга зорилгод таныг ашиглах болов уу? Хоёрдугаарт, хэрэв та Аврагчийг даган, шавийн замаар алхахыг сонгох юм бол Их Эзэн Өөрийн зорилгыг биелүүлэхийн тулд ашиглахдаа таныг харж хандан, удирдан чиглүүлж, адисалж, баяр баясгалан болон сэтгэл ханамжийн сүнсээр дүүргэх болов уу?

Хайрт ах, эгч нар аа, хэрэв та зүрх сэтгэлээ Аврагчид өгч, Түүний зарлигласан зам дээр итгэлтэйгээр, нинжин сэтгэлээр алхахыг хичээвэл Их Эзэн таны төсөөлж ч байгаагүй арга замаар таныг ашиглана гэдгийг би мэднэ.

“Би онцгой хүн биш л дээ. Би байдаг л нэг жирийн хүн. Би тийм ч ухаалаг, уран үгтэй, сайхан хувцасласан эсвэл сайхан ааш зантай хүн биш. Бурхан намайг яаж ашиглах юм бэ?” гэж та хэлж болох юм.

Цаг хугацааны эхлэлээс бидний Тэнгэрлэг Эцэг энгийн хүмүүст хандаж, Өөрийн зорилгод тэднийг ашигладаг байв. Төлөөлөгч Паул эртний коринтчуудад хандан бичихдээ та нарт ч бас хандсан.

“Бурхан цэцдийг ичээхийн тулд ертөнцийн мунхгийг сонгож, хүчтэйг ичээхийн тулд ертөнцийн мөхсийг сонгожээ.

Байгсдыг хүчингүй болгохын тулд энэ ертөнцийн дордсыг мөн гологдогсдыг буюу юу ч бишийг Бурхан сонгосон ажээ.

Ингэх нь Бурханы өмнө ямар ч махбодыг сайрхуулахгүйн тулд болой” (1 Коринт 1:27–29).

Аврагчийг Сүмээ дэлхий дээр сэргээх болоход Тэр яагаад бага сургуулийн боловсролтой эгэл даруу хүүг сонгосон гэж та бодож байна вэ?

Бурхан яагаад тариачин Гидеонд тоо томшгүй олон дайсантай тулалдах гурван зуухан эрийг үлдтэл цэргүүдийг гэр рүү нь явуул гэж хэлсэн гэж та бодож байна вэ? (Шүүгчид 7:1–25-ыг үзнэ үү).

Аврагч яагаад загасчныг ахлах төлөөлөгчөө болгон, явсныхаа дараа Сүмээ удирдуулахаар сонгосон гэж та бодож байна вэ? (Матай 16:18-ыг үзнэ үү).

Нэгд, “Учир нь, Бурхан мөхөс нэгэнтэй адил хүний гаднах төрхийг хардаггүй. ЭЗЭН зүрхийг нь хардаг” (1 Самуел 16:7).

Хоёрт, учир нь Бурхан хамгийн энгийн шаврыг авч, урлагийн бүтээл хийх чадвартай. Үнэндээ, “Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ?” (Ром 8:31).

Гуравт, Бурхан хэнийг ч сайрхан мөн “Би үүнийг өөрийн хүчээр хийсэн” гэж хэлүүлэхгүйн тулд сул дорой хүмүүсийг сонгодог.

Даруухан загасчин Петрийг итгэгчдийн жижиг бүлэг





дагуулан, тэднийг хүчирхэг Сүм болгон өсгөн бойжуулах үед хүмүүс Бурханд дуу хоолойгоо өргөн, талархсан.

Олон мянган хүнтэй их цэргийг 300 хүнтэй бүлэг бут цохиход хүмүүс Бурханыг магтан алдаршуулсан.

Зах хязгаарын нэгэн хүү газар тариалангаа орхин, Библиэс хойш бичигдсэн хамгийн сүнслэг, амьдралыг өөрчлөх хүчтэй эх бичвэрийг орчуулахад хүмүүс хүний оюун ухааныг бус, харин Бурханы хүчийг магтан алдаршуулсан.

Та Тэнгэрлэг Эцэгийн хувьд хүчтэй, оюунлаг эсвэл уран цэцэн ярьдаг байх шаардлагагүй. Тэрээр Өөрт нь зүрх сэтгэлээ хандуулж мөн Өөрт нь үйлчлэн, эргэн тойрныхондоо өр нимгэн өрөвч сэтгэлээр тусламжийн гараа сунган, хүндлэл үзүүлээсэй хэмээн та нараас хүсдэг.

Ариун Сүнсний тохинуулал

Миний та нарт онцлон дурдах гэсэн хоёр дахь зүйл бол хэрэв та Бурханыг үнэнээсээ, хүчтэйгээр дагах юм бол Тэрээр таныг төсөөлөхийн аргагүй арга замаар адислах болно.

2006 онд ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) болон Тэргүүн Зөвлөл Эль Сальвадорын Сан-Сальвадорт ариун сүм барих хэрэгтэй гэсэн шийдвэр гаргасан. Бид хэд хэдэн барилга байгууламж явж үзсэний дотор хотын хуучны төв хэсгийн бүхэл бүтэн гудам орсон байв. Биднийг машинаараа нэг газраас нөгөө газар луу явах үед ямар ч мэдрэмж төрөхгүй байлаа.

Хамгийн сүүлд бид хотын баруун хэсэгт шинээр байгуулагдаж байгаа дүүргийн хажуугаар өнгөрөв. Тэр хэсэгт очиж, нэлээн хэдэн гудмаар алхах үед надад ямар нэгэн зүйл мэдрэгдэв. Хэрмээр хүрээлэгдсэн нэгэн байгууламж миний анхаарлыг ихэд татаж байлаа. Эзэдтэй нь холбогдоход үл хөдлөх хөрөнгөө зарахгүй гэсэн хариу тэднээс авсан тул би гэртээ харив.

Гэвч бошиглогч ариун сүм Сан-Сальвадорт баригдана гэсэн учраас би өөр үл хөдлөх хөрөнгө харахаар эргэж гарлаа. Тэр хэрэмтэй үл хөдлөх хөрөнгө миний санаанаас салахгүй байсан тул би дахин холбоо барив. Тэд үл хөдлөх хөрөнгөө зарахгүй гэдгээ дахин хэллээ.

Бид гэртээ эргэж ирсэн ч тэнд л ариун сүм баригдах ёстой гэсэн бодол салахгүй байв. Би тэр гэр бүлтэй холбогдож, ядаж уулзах боломж олгохыг тэднээс хүслээ. Тэднийг уулзахыг зөвшөөрөхөд би Сүмийн үл хөдлөх хөрөнгө хариуцсан албаны ажилтан, өөрийн найз Роберт Фокстой хамт Сан-Сальвадор руу дахин явав. Тэр өглөө бид шинэ өдрийг эхлүүлэхийнхээ өмнө өрөөндөө өвдөг сөгдөн залбирч, Их Эзэнээс тусламж гуйсан юм.

Машинтайгаа хаалгаар орж, гэр рүү нь чиглэн явахад яг л ариун нандин цэцэрлэг рүү орж байгаа мэт санагдсан. Тэнд мод, цэцэгс байсан ба гаднын үл тасрах дуу чимээ хаалганы босгоноос цааш сонсдохгүй байв. Ноён Мигиэл Дьюнас өөрийн ах болон хоёр хүүтэйгээ хамт биднийг угтан авлаа. Тэд бидэнтэй мэндчилж, өвөг дээдсийнхээ уужим, цэлгэр гэрт дагуулан оров.

Бид энд Сүмийн ерөнхийлөгчийнхөө даалгавраар явж байгаа бөгөөд тэр энд ариун сүм барьж, энэ улсын болон Сүмийн гишүүдийг адислахыг хүсэж байгааг хэллээ. Би өөр ариун сүмийн зургууд үзүүлэв. Тэдний үл хөдлөх хөрөнгө буюу өвөг дээдсийнх нь орон гэр хамгийн тохиромжтой газар гэж бодож байгаагаа би тэдэнд хэлсэн юм.

Тэднийг дахин таггалзахад бид гайхсангүй. Бид ядаж үзээд алдах хэрэгтэй байлаа. Тиймээс бид бараг нэг цагийн турш шууд худалдан авалт хийх, өөр үл хөдлөх хөрөнгөөр солих гэх мэт бодож болох бүхий л аргыг хэрэглэн, тэднийг ятгах гэж оролдов. Гэвч тэд санаагаа өөрчлөөгүй бөгөөд бидний тавьсан санал болгоноос таггалзлаа.

Бид ч чадах бүхнээ хийсэн байв. Бид бэлтгэлтэй байсан, бас чадлынхаа хэрээр хичээсэн. Гэвч энэ бүхэн хангалтгүй байв.

Би зүрх сэтгэлдээ “Аав аа, бидэнд юу хэлж эсвэл хийхийг мэдэхэд туслаач” хэмээн хурдан гэгч залбирлаа.

Эцэст нь бидний аялал үр дүнгүй байсан нь тодорхой болов. Тэдний бодлыг юу ч өөрчлөхгүй мэт санагдсан юм. Харин биднийг явахаар бэлтгэж эхлэхэд нэг зүйл болов. Эзэний Сүнс өрөөнд орж ирсэн ба бараг барьж болмоор мэдэгдэж байлаа. Өрөөнд байсан хүн бүр үүнийг мэдэрсэн юм. Энэ миний амьдралдаа мэдэрч байсан хамгийн хүчтэй сүнслэг туршлагуудын нэг байлаа.

Сүмийн гишүүн байгаагүй Мигиэл Дьюнас уйлж эхлэв. Ноён Дьюнас ах руугаа хараад, “Хэрэв бид өвөг дээдсийнхээ гэрийг зарж болохгүй юм бол гудамжны эсрэг талд байгаа хамгийн сайн үл хөдлөх хөрөнгөө зарж болохгүй гэж үү?” гэж асуулаа.

Ах нь зөвшөөрөхөд бид нөгөө үл хөдлөх хөрөнгийнх нь талаар ярилцав. Тэд өвөг дээдсийнх нь гэрийн хажуугаар өнгөрдөг гол замын дагуу хэдэн зуун акр газар эзэмшдэг байсан ба тэр газар голоороо бага зэрэг товойж байсан нь замаар явж байгаа машин бүрд ариун сүмийг харах боломжийг олгож байлаа.

Тэд энэ газраа Их Эзэний ариун сүмд зориулан санал болгосон юм. Энэ үнэхээр гайхамшиг байв. Энэ мөчөөс эхлэн өрнөсөн үйл явцыг Их Эзэн адисалж байсан. 2011 оны 8-р сарын 21-нд тухайн үед Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөхөөр үйлчилж байсан ерөнхийлөгч Хэнри Б.Айринг ариун сүмийг Их Эзэний үйлчлэлд зориулан онцгойлон адисалсан билээ.

Үзэсгэлэнт ариун сүм Сан-Сальвадорын толгодыг чимж байгаа нь Фокс ах бид хоёрын хэлсэн эсвэл хийсэн

зүйлийн үр дүнд биш гэдгийг би гэрчилж байна. Ариун сүм бидний Хүчит Бурханы Ариун Сүнсний хүчирхэг тохинууллын ачаар өнөөдөр тэнд сүндэрлэж байгаа.

Бидний нигүүлсэнгүй Эцэг

Хэрэв Их Эзэн ариун сүм барих газрыг авахад санаа тавьж, Өөрийн Сүнсийг илгээсэн юм бол Тэрээр таны зүрх сэтгэлийг бэлдэж, хийх алхмуудыг тань удирдан чиглүүлэхээр Өөрийн Сүнсийг илгээхгүй гэж үү?

Та хэсэг газартай зүйрлэшгүй үнэ цэнтэй билээ. Та бол Мөнхийн Эцэгийнхээ хайртай хүүхэд мөн. Та бол дэлхий ертөнцийн Бурханы үр хүүхэд шүү дээ!

Тэр таныг бодохгүй гэж үү? Тэр таны төсөөлж чадахаас ч илүү алдар суу бүхий арга замаар таныг ашиглаж мөн адислахгүй гэж үү?

Хэрэв бид “бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ[н], [өөрийн] ойлголтод түшиглэ[лгүй],” өөрийн бүх замаар “Түүнийг таньж мэд[вэл] Тэр [бидний] замыг шулуун болгоно” (Сургаалт үгс 3:5–6) хэмээн судар бидэнд хэлдэг.

Хаан Бенжамин миний та нарт үлдээхийг хүсэж буй захиасыг ийн нүдийг нь олж, хураангуйлан хэлсэн байдаг. Тэрээр “Мөн үүнээс гадна, Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай хэмээн хүснэ би. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд, биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд тэнгэрт хүлээн авагдах болно” (Мозая 2:41) хэмээн хэлсэн.

Би энэ үнэнийг магтан дуулж, гэрчлэн, дуу хоолойгоо өргөж байна. Би өөрийн болон олон хүний амьдралд Бурханы амласан адислалууд ахин дахин биелж байхыг харснаа гэрчилж байна.

Хэрэв та нар зүрх сэтгэлээ Тэнгэр дэх Эцэгтээ хандуулан, өдөр бүр Есүс Христийг илүү төгс хайрлан, дагахыг хичээж, эргэн тойрныхоо зовж шаналж буй хүмүүсийн ачаанаас энэрэнгүй, сайхан сэтгэлээр үүрэлцэж, гарыг нь дээш өргөн, хайрт Аврагчийнхаа жинхэнэ дагалдагч болохыг эрэлхийлэх юм бол тэнгэрийн Эзэн Бурхан замыг тань удирдан чиглүүлэх болно гэдгийг би амлаж байна. Тэрээр та нарыг Өөрийн агуу зорилгын төлөө ашиглах болно. Тэр бас та нарыг таны төсөөлж ч байгаагүй арга замаар адислах болно. ■

2015 оны 11-р сарын 3-нд Бригам Янгийн Их Сургуулийн онцгой цугларалт дээр хэлсэн “God Will Use You, God Will Bless You” үгээс авав.

Зүрх сэтгэлээ бас найз нөхдөө өөрчилсөн нь

Би өсвөр насандаа ихээхэн тэрслүү зантай байсан ба өсөж хүмүүжсэнээсээ эсрэг үйлддэг байв. Би 13 настайгаасаа согтууруулах ундаа хэрэглэж эхэлсэн бөгөөд ахлах сургуулиа төгсөх жил гэхэд долоо хоног бүр уудаг болсон байлаа.

Би эцэг эхтэйгээ маргалдахгүйн тулд сүмд үе үе очдог байсан ч ариун ёслолын цуглаан дээр унтаж, Няма гаргийн ангиас өмнө далайн эрэг рүү явдаг байв. Эцэг эх маань надад сэтгэл дундуур байсан гэж хэлэхэд ч зөөлдөнө. Тэдний сайшаалтай тал нь гэвэл, тэд намайг сайн мэдээний дагуу амьдрахад урамшуулахын зэрэгцээ миний сонгох эрхийг хүндэтгэдэг байсан. Гэсэн ч надад Сүмд идэвхтэй үлдэх бодол байхгүй байсан ба ирээдүйд номлол хийнэ гэдгээ олж харахгүй байв.

Би ахлах сургуулиа төгсөөд, орон нутгийн коллежид элсэн орсон ч тэрсэлсэн хэвээр байлаа. Харин нэг орой би ирээдүйнхээ талаар бодон буйдан дээр хэвтэж байснаа санаж

байна. Би ямар охинтой гэрлэх бол? Их Эзэнээс нүүр буруулсан юм чинь буцаж очих замаа олох болов уу? Эдгээр шийдвэр чухал байсан ч би өөрчлөгдөх хүсэлгүй байв.

Удалгүй би найзынхаа арын хашаанд согтууруулах ундаа, дүрэлзсэн түүдэг галтай үдэшлэгт оролцсон. Найзуудтайгаа хэсэг маазарсныхаа дараа би тэндээс түр гарч, нүдээ анилаа.

Харин нүдээ нээгээд, яг юу болж байгааг тодорхой харсан юм. Би найзуудынхаа мунхаг үйлдлийг харахаас гадна өөрийгөө энэ бүлэгт байгаагаар харахгүй байв. Би тэндээс явсан бөгөөд ууж, үдэшлэгт явж байхаа болихоор шийдсэн юм. Үүний тулд би найз нөхдийнхөө хүрээллийг өөрчлөх хэрэгтэй байсан бөгөөд энэ нь тийм ч амархан даваа байсангүй. Гэвч би үүнийг хийж чадсан!

Эдгээр шийдвэр миний амьдралыг орвонгоор нь өөрчилсөн. Би эцэст нь номлолд үйлчлэн, олон дуудлагат ажил хийсэн юм. Хамгийн


чухал нь би ариун сүмд гайхалтай эмэгтэйтэй гэрлэсэн. Энэ нь миний амьдралын хамгийн сайн сайхан адислалуудыг авчирсан юм.

Би саяхан Алмагийн болон Мозаягийн хөвгүүдийн хөрвөлтийн тухай (Мозая 27-г үзнэ үү) мөн тэд Алмагийн аавын итгэлтэй залбирлын үр дүнд хэрхэн зүрх сэтгэлийн хүчирхэг өөрчлөлтийг мэдэрсэн тухай (Алма 5:12–14-ийг үзнэ үү) уншлаа. Харин дараа нь би эцэг эхийнхээ талаар бодоод, үдэшлэг дээр надад ухаарал авчирсан тэрхүү үйл явдал тэдний залбирлын шууд үр дүн байсныг 30 гаруй жилийн дараа л ухааран ойлгосон юм.

Одоо би асуудалтай байгаа хүүхдийн эцгийн хувьд өөрийгөө Алмагийн эцэг болон өөрийн эцэг эхийн оронд байгааг мэддэг. Гэвч би судрыг өөртэйгөө адилтгаснаар хэзээ нэгэн цагт миний хүүхэд зүрх сэтгэлийн өөрчлөлтийг мэдэрнэ гэдэгт итгэж мөн найддаг. ■

Нэрийг нууцлав, АНУ, Калифорни

Үдэшлэгийн үеэр би найзуудынхаа мунхаг үйлдлийг харахаас гадна өөрийгөө энэ бүлэгт байгаагаар харахгүй байв.



Миний номлолын мөрөөдөл эцэст нь биелсэн

Би олон жилийн турш бүрэн цагийн номлолд үйлчлэхийг мөрөөддөг байсан. Гэвч би их сургуулиа төгсөж, гэртээ ирэхдээ гэр бүлийнхэнд маань миний тусламж ямар их хэрэгтэй байгааг харж билээ. Аавын эрүүл мэнд муудаж, гэр бүлд маань санхүүгийн тусламж хэрэгтэй болсон байв. Би айлын дөрвөн хүүхдийн томын хувьд гэртээ үлдэж, туслах хэрэгтэй гэж бодсон юм. Тэнгэрлэг Эцэг ч намайг давгүй сайн ажлаар адисалсан. Миний цалин тийм өндөр байгаагүй ч хэрэгцээгээ хангахад хангалттай хүрдэг байв.

Надаас бүрэн цагийн номлолд үйлчлэх талаар асуух болгонд би үйлчилнэ л гэдэг байлаа. Намайг ингэж хариулах тоолонд ээж над руу баяр, гуниг хосолсон харцаар хардаг байв. Хэрэв намайг явъя гэвэл гэр бүлийн орлогоо алдана гэж санаа зовсон ч ээж минь үүнийгээ дотроо хадгалан, яв гэж хэлнэ гэдгийг би мэдэж байсан.

Хэдэн жилийн дараа зохистой санваартан ах надаас ариун сүмд гэрлэхийг гуйлаа. Би ч зөвшөөрч, дараа нь бид хоёр охин, нэг хүү гээд гурван хүүхдээр адислагдсан юм. Бидний хамгийн баяр баясгалантай мөчүүдийн нэг бол хүү маань номлолд үйлчлэхээр явсан явдал байлаа. Тайтгарал, амар амгалангийн



О хиньхоо номлолын түүхийг уншиж байхдаа би номлогчийн сүнсээр дүүрдэг байлаа. Би номлолын ажил хийх боломжийн төлөө залбирдаг байсан ба найздаа мессеж илгээх сүнсний өдөөлтийг мэдэрсэн юм.

сүнс манай гэрийг дүүргэсэн юм.

Номлолд үйлчлэх хүслийн маань нэг хэсэг нь ч гэсэн биелсэн мэт надад санагдаж байлаа.

Том охин маань бас номлолд үйлчлэхийг хүсэж байна гэж хэлэх үед би хэчнээн баярласан гээч. Охин маань номлолын талбараасаа долоо хоног бүр ажлынхаа түүхийг над руу явуулдаг байв. Түүний гэрчлэл намайг сүнсээр өдөөж, номлогчийн сүнсээр дүүргэдэг байлаа. Би өдөр бүр номлолын ажил хийх боломжийн төлөө залбирдаг байв.

Нэг өдөр би нэг найзаасаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дээрх хувийн мессежээрээ номлогчидтой уулзах сонирхолтой байгаа эсэхийг асуухад тэр “Уулзъя” гэж хэллээ. Би LDS.org дээрх онлайн туслалцаа хүсэх маягтыг бөглөсөн ба удалгүй номлогчид түүнд зааж эхэлсэн юм. Гурван сарын дараа тэр Сүмд нэгдэж, хүүхдүүд нь хэдхэн сарын дараа түүнийг даган сүмд нэгдэв. Сүнс намайг удирдан чиглүүлэх үед би өөр найзуудаа ч гэсэн номлогчдыг сонсоход урьсан. Охиныгоо гэртээ эргэж ирэхэд надад ч бас 18 сарын номлолын үйлчлэл хийгээд ирсэн мэт мэдрэмж төрж билээ.

Тэнгэрлэг Эцэг миний зүрх сэтгэлийн хүслийг мөн надад болон гэр бүлд маань юу хамгийн хэрэгтэй байсныг мэдэж байсан. Тэр миний сэтгэл зүрхэнд он удаан жил хадглагдаж байсан номлогчоор үйлчлэх хүслийг маань биелүүлсэнд би талархдаг. ■

Жийн Даниел Дэрой, Канад, Онтарио



Бидний ариун сүм рүү хийсэн 30 жилийн аялал

Дүүгээ Швейцар руу явахаас өмнө, энэ аялал түүнийг Аврагчид болон Түүний сүмд ойртуулах болно гэдгийг Сүнс миний зүрх сэтгэлд шивнэсэн юм.

Намайг баптисм хүртсэнээс хойш хэдхэн сарын дараа миний дүү Освалдо өөр сүмд нэгдэж, цуглаануудад нь идэвхтэй оролцох болсон юм. Харин би Освалдог миний мэддэг үнэнийг мэдээсэй гэж хүсэж байлаа. Ялангуяа би түүнийг бошиглогчдын үгстэй холбохыг хүссэн.

Би сар бүр *Лиэхона* сэтгүүлээ аваад, Освалдотой хуваалцдаг байв. Сэтгүүл дээрх зарим сэдэв түүнийг сүмийнхээ цуглаанд бэлдэхэд нь тусална гэж би хэлсэн юм. Түүнийг миний саналыг хүлээж авахад нь би баярласан. Олон жил өнгөрсөн ч дүү маань Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хүлээж авахгүй байгаад би харамсдаг байлаа.

Нэг өглөө Освалдо гэрийнхэндээ Эквадорт байдаг гэрээ орхин, Швейцар руу аялах болсноо дуулгав. Тэр явах өдрөө надаас адислал авч билээ. Энэ аялал Освалдог Аврагчид болон Түүний Сүмд ойртуулах болно гэдгийг Сүнс миний зүрх сэтгэлд шивнэсэн тул миний хувьд сэтгэл хөдөлгөсөн мөч байв.

Швейцарт Освалдо номлогчидтой уулзаж, эцэст нь тэр тэднийг гэртээ урьсан юм. Цаг хугацаа өнгөрөхөд тэр тэдэнтэй ойр дотно харилцаатай болов. Гэхдээ хэрэв номлогчдыг

баптисмын талаар ярьж эхэлбэл тэднийг цаашид хүлээн авахгүй гэж тэр надад хэлж билээ. Баптисм хүртсэн гэх э-мэйлийг түүнээс хүлээн аваад, би ямар их гайхаж, баярласныг төсөөл дөө. Би 1981 онд Сүмд нэгдсэн. Освалдо харин хорин жилийн дараа, 2001 оны 5-р сард баптисм хүртсэн юм. 2002 оны 7-р сард тэр хувийн хишгээ хүртэж, эхнэртэйгээ 2003 оны 2-р сард лацдан холбуулсан.

Освалдо Эквадорт эргэж ирээд, ариун ёслолын цуглаан дээр гэрчлэлээ хуваалцав. Тэр нүдэндээ нулимс цийлэгнүүлэн, “Ах маань бошиглогчдын үгсийг надтай хуваалцдаг байсан. Тэрхүү үгс намайг өмнө нь явдаг байсан сүмийн цуглаанд маань бэлдэхэд надад сүнсээр өдөөдөг байсан ба олон хүнийг сэнхрүүлсэн. Бошиглогчдын үгс миний амьдралыг өөрчилсөн билээ. Тэдгээрээр дамжуулан би Есүс Христийн сайн мэдээ дэлхий дээр дахин бүрэн байдлаараа, хүч ба эрх мэдэлтэйгээр ирснийг мэдсэн” гэж хуваалцав.

2011 оны 2-р сард Освалдо бид хоёр Эквадорын Гуаяакул ариун сүмд эцэг эхтэйгээ лацдан холбуулсан юм. Бошиглогчдын үгс бидний гэр бүлийг мөнхөд адисалсан. ■
Франциско В.Фиерро, Перу, Лима

Аллагад өртөгсөд ба миний гэрчлэл

Номлогчдыг Иосеф Смитийн тухай болон Мормоны Номын талаар заах үед би эргэлзэж билээ. Иосеф Смит “бошиглогч” хэмээх нэр зүүсэн олон хүнтэй адил эд баялаг, алдар хүнд эсвэл баатар болох зорилгоор дэлхийд хуурамч ном авчирсан байх гэсэн бодол надад анх төрсөн юм.

Мормоны Номыг уншъя гэсэн бодол ч надад төрөөгүй. Харин цаг хугацаа өнгөрч, номлогчдын нөхөрсөг зан, сайн мэдээг гэх хүсэл тэмүүлэл захиасыг нь сонирхоод үзье гэсэн хүслийг төрүүлсэн юм.

Би номлогчдын өгсөн Мормоны Номын шүлгийг уншиж байхдаа Бурханаас Христэд итгэлтэй байж, чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр Мормоны Ном үнэн эсэхийг асуу хэмээх Моронайн урилгыг олов (Моронай 10:4–5-ыг үзнэ үү). “Мормоны Номыг хуурамч гэдгийг мэдсээр байж, Бурханаас чин сэтгэл, үнэн хүсэлтэйгээр уг номын үнэн эсэхийг асуу гэж хэн урих билээ дээ” гэж би бодож билээ.

Дараа нь нэг өдөр Иосеф Смит болон түүний ах Хайрум хоёр гэрчлэлийнхээ төлөө хөнөөгдсөнийг номлогчид тайлбарлав. Тэд худал хуурмагийг нь мэдсээр байж үүнийхээ төлөө амиа өгөхгүй байсан шүү дээ гэсэн бодол гэнэт надад төрж билээ. Тэр мөчид шатаж буй гал мэт дулаан мэдрэмж намайг нөмөрсөн юм. Энэ бол Иосеф Смит жинхэнэ бошиглогч гэдгийг Ариун Сүнс зүрх сэтгэлд минь баталсан гэрчлэл байв. Би энэ гэрчлэлийг хүлээн авснаар баптисм хүртэж, гишүүнээр батлуулсан.

25 жилийн дараа Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Жэффри Р.Холландын үгийг уншиж байхдаа би энэ үйл явдлыг санаж билээ. Ахлагч Холланд энэ үгэндээ Иосеф, Хайрум хоёр амь насаа алдсан тэр ноцтой мөчид худлаа гэдгийг нь мэдэж байсан номынхоо төлөө өөрсдийн амьдрал, нэр төр, мөнхийн авралаар дэнчин тавьж, Бурханыг

доромжлох байсан болов уу? хэмээн асуусан юм.

“Тэд тэгэхгүй байсан!” гээд ахлагч Холланд цааш нь, “Тэд Мормоны Номын мөнхийн үнэн болон бурханлаг эх сурвалжийг үгүйсгэснээс амиа алдсан нь дээр гэж үзсэн”¹ хэмээн хэлсэн.

Ахлагч Холландын үгс миний хувьд маш утга учиртай байсан төдийгүй бошиглогч Иосеф Смитийн тухай болон Мормоны Номын хүчийн талаарх гэрчлэлийг минь хүчирхэгжүүлсэн билээ.

Би бошиглогч Иосеф Смитэд талархдаг. Тэр Мормоны Номыг урагш авчирсан бөгөөд Есүс Христийн гэрч болохын тулд амь насаа өөрийн хүслээр өгсөн. Мормоны Номоор дамжуулан би Бурхан байдгийг мөн Түүний намайг гэх хайрын талаар мэдэж авсан. ■

Сунжу Ким Муир, АНУ, Мэриланд эшлэл

1. Жэффри Р.Холланд, “Бодгалийн аюулгүй байдал,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 100.

Иосеф Смит, түүний ах Хайрум хоёрын хөнөөгдсөнийг олж мэдсэн тэр үед тэд худал хуурмаг гэдгийг нь мэдсээр байж, үүнийхээ төлөө хэзээ ч амиа өгөхгүй байх байсныг Сүнс надад баталсан юм.



Бид Христээр төгс байхад итгэдэг

Есүс Уулан дээрх номлолынхоо үеэр төгс байх хүндхэн зарлигийг бидэнд өгсөн (Матай 5:48-ыг үзнэ үү). Бүгдээрээ алдаа гаргах байтал Бурхан хэрхэн биднээс энэ зарлигийг дагаасай хэмээн хүсдэг байна аа? Бурханы биднээс хүсэн хүлээдэг зүйлсийн талаар зөв ойлголттой болсноор бид бошиглогч Моронайн “Христээр төгс” (Моронай 10:32–33-ыг үзнэ үү) болж болно гэсэн үг ямар утгатай болохыг мэдэж болно.

Төгс байх гэдэг нь ямар утгатай вэ?

“Төгс гэсэн грек үг нь ‘бүрэн, гүйцэд, бүрэн дүүрэн хөгжсөн’ (Матай 5:48, зүүлт тайлбар *b*) гэсэн утгаар орчуулагдаж болно. Аврагчийн болон Тэнгэр дэх Эцэгийн бидэнд үзүүлсэн ариун журам, зан чанараар төгс болгогдохын тулд—Тэр биднийг бүрэн, гүйцэд, бүрэн дүүрэн хөгжсөн байхыг хүсдэг.”¹

“Аврагчийн биднийг хүрээсэй гэж хүсдэг төгс төгөлдөр байдал ямар ч алдаа гаргахгүй байхаас илүү чухал зүйл юм. Энэ нь Их Эзэний Эцэгтээ хандан өргөсөн агуу залбиралдаа илэрхийлснээр мөнхийн хүлээлт буюу бид төгс болж, тэдэнтэй хамт мөнхөд амьдрах явдал юм.”²

“Тиймээс Есүс энэ сэдвээрх номлолоо бидний алдаа дутагдлыг зэмлэх хатуу үг болгох гээгүй гэдэгт би итгэдэг. Үгүй ээ. Түүнийг Бурхан Мөнхийн Эцэг гэж хэн болохыг мөн мөнх амьдралд бидний гүйцэлдүүлж чадах зүйлийг онцлох зорилготой байсан гэдэгт би итгэдэг.”³ ■

ЭШЛЭЛҮҮД

1. Гэррит В.Гонг, “Христээр төгөлдөржих нь,” *Лиахона*, 2014 оны 7-р сар, 45.
2. Russell M. Nelson, “Perfection Pending,” *Ensign*, Nov. 1995, 86.
3. Жэффри Р.Холланд, “Тиймээс та нар эцэст нь төгс бай,” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 28.



“Аврагчийн үнэгүй өгдөг цагаатгагч хайрыг ойлгосноор

төгс төгөлдөр байдал гэж юу болох талаар бид өөрсдөдөө оногдуулсан, буруу бөгөөд бодит бус хүлээлтээс чөлөөлж чадна.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Гэррит В.Гонг, “Христээр төгөлдөржих нь,” *Лиахона*, 2014 оны 7-р сар, 42.

Бурхан юу хүсэн хүлээдэг вэ?

“Бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар хайрла” (Моронай 10:32).

Алдаа гаргах үедээ Есүс Христэд итгэн наманчил.

Бурхантай байгуулсан гэрээгээ эсвэл амлалтаа сахь.

Амьдралынхаа турш зарлигуудыг сахихыг хамгийн сайнаараа хичээ.

“Та нар төгөлдөржих хүртлээ тэвчээрт үргэлжлүүл” (Сургаал ба Гэрээ 67:13).



Бурхан юу хүсэн хүлээдэггүй вэ?

Одоо төгс бол!


Төгс байх хандлагад дарлуул.

Хэрхэвч алдаа гаргаж болохгүй.

Байнга ажиллаж, тоглож наадах завгүй бай.

Өсөж хөгжихгүй байгаадаа өөрийгөө шүүмжил.

Тэнгэрт хүрэх өөрийн замын “төлөөсийг төлөхийг” хичээ.



Хүүхдүүдтэйгээ хамт өнгөрүүлсэн цаг мөч ба ХОНИН ГҮРВЭЛ, ДЭВХРЭГ ХОЁР

Нэнси Томас

Би хэвлээр явагч амьтан хүү бид хоёрын харилцаанд ариллигүй мөр үлдээнэ гэж хэзээ ч төсөөлж байгаагүй юм.

Миний хүү Даллин хэвлээр явагч амьтдад хайртай байсан ч би тэдгээрт тийм ч дуртай байсангүй. Түүнийг хичээлдээ явсан хойгуур торноосоо гарсан тохиолдолд тоос сорогчийн хоолойд багтчих хэмжээний нэг хэвлээр явагчтай болохыг би түүнд зөвшөөрсөн юм. Бид мэлхийнээс игуана хүртэлх хэдэн амьтнаас хамба хилэн Фазз, Дайан гэдэг хоёр толбот хонин гүрвэлийг сонгов.

Даллиныг долоон настай байхад түүний энэ шинэ найзууд манай гэр бүлд нэгдсэн юм. Хонин гүрвэл тэжээхийн тулд тэднийг долоо хоногт нэг удаа дэвхрэгээр, бүр амьд дэвхрэгээр хооллох хэрэгтэй гэдгийг би таамаглаж байсангүй. Даллин бид хоёр олон жилийн турш сайн “дэвхрэг худалдаж авах ажилд” гардаг байв. Ихэвчлэн оройн цагаар цаг нартай уралдан, амьтны дэлгүүр хаахаас урьтаж очих амаргүй байлаа.

Дайан гуравхан жил амьд байсан ч Фазз олон жил эрүүл, аз жаргалтай амьдарсан юм. Даллин ахлах сургуулиа төгсөхдөө илтгэл тавьж сурах хичээл дээрээ нэг илтгэл тавих даалгавар хүлээн авсан байв. Тэр нөхөр

бид хоёрын санаа бодлыг асууж билээ. Бид толбот хонин гүрвэлийн талаар аль хэдийн сайн мэддэг болсон тул тэдний талаар ярьж, бас илтгэл дээрээ Фаззыг аваачиж очихыг санал болгосон юм. Даллин тэгэхэд Фаззыг үхсэн гэдгийг бидэнд хэлэв.

“Чи тоглож байгаа байлгүй дээ! Тэр хэзээ үхсэн юм бэ?” гэж би итгэлгүйхэн асуув.

Даллин Фазз долоо хоногийн өмнө үхсэн гэдгийг бидэнд дуулгалаа.

“Тэр миний өрөөнд байгаа, гэхдээ санаа зовох хэрэггүй ээ. Түүнээс өмхий үнэртэхгүй. Би түүнийг давхар уутанд хийсэн” гэж тэр хэлэв.

Тэр бидний гайхсан харцыг хараад, “Би нэг туршилт хийж байгаа юм. Түүний яаж ялзрахыг би харах гэсэн юм” гэж тайлбарлалаа.

Даллины туршилт түүний ялзарч байгааг харахаас илүү чухал зүйл болж хувирсан юм. Тэр Фаззыг хоёр долоо хоногийн турш хөлдөөгчид тавьж, ялзрах үйл явцыг зогсоосныхоо дараа дахин гэсгээж, ялзруулж байлаа.

Жилийн дараа Даллиныг номлолд байх хойгуур би хөлдөөгчөө цэвэрлэж байгаад, давхар уутанд

хийсэн Фаззыг хөлдөөгчийн хойд хэсгээс оллоо. Би Даллинд илгээмж явуулахаар бэлтгэж байсан тул нэг жижигхэн туршилт явуулбал хөгжилтэй байна байх гэж бодов. Би Фаззыг хар цагаан буурцган хээтэй гоёмсог цаасаар ороож, хайрцганд эвтэйхэн хийж, “Чиний илгээмжин дотор гэнэтийн бэлэг байгаа шүү” гэж бичээд, Даллины илгээмжин дотор нямбай хийлээ. Дараа нь би түүний хариултыг тэсэн ядан хүлээв.

“Би хонин гүрвэлээ авснаасаа хойш түүний талаар бодлоо. Үнэндээ яг ч тэр хонин гүрвэлийн талаар биш, харин долоо хоног бүр дэвхрэг авах, бас өөр ажил амжуулахаар явж байх хооронд машин дотор явж байхдаа сонсож явсан таны хэлсэн санаа оноо, ярьсан түүх, гэрчлэлүүдийг би дурсан санасан юм. Энэ нь тантай хамт явж, ярилцах (би их ярьдаггүй байсан ч сонсдог байсан шүү) сайхан шалтаг болдог байсан” гэж бичсэн байв.

Дэвхрэг худалдаж авах нь шүү. Хэн мэдэх билээ дээ? Эцэг эхийн хувьд бид үр хүүхдэдээ нөлөөлөх цагаа тэр болгон төлөвлөөд байдаггүй. Энэ нь явцын дунд аяндаа л болдог зүйл. Энэ нь хүүхдүүдээ орой



унтуулахаар оронд нь оруулах, хамтдаа цанаар гулгах эсвэл машинаараа ажил амжуулж байх үед болж болно. Бид хүүхдүүдтэйгээ хамт байх цаг гаргах ёстой.

Аврагч хүүхдүүдэд цаг зав гаргахын агуу үлгэр жишээг үзүүлдэг байсан. Христ нифайчуудад өдөржин заасныхаа дараа хүмүүст хандан, бяцхан үрсээ Өөрт нь авчрахыг зарлигласан. Тэр бяцхан үрсийн дунд өвдөг сөгдөн, залбирсан юм. Залбирсныхаа дараа Тэр уйлж, дараа

нь “тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав” (3 Нифай 17:21).

Тэр хүүхдүүд Есүс өөрсдийг нь хайрладгийг мэдэж байсан. Тэрээр тэдэнд зориулан, цаг зав гаргахад бэлэн байсан ба тэднийг сонсож, тэдний төлөө залбирч, тэднийг адисалсан. Үүнийг гэрчилсэн хүмүүс асар их хүчээр дүүргэгдсэн байсан тул “Эцэгт хандан Есүсийн ярьсныг бид харж мөн сонссон шиг тийм агуу хийгээд

гайхамшигт зүйлүүд урьд нь нүдэнд хэзээ ч үзэгдээгүй, бас чихэнд хэзээ ч сонсогдоогүй бөлгөө” (3 Нифай 17:16) хэмээн цэдэглэсэн байдаг.

Есүс Христийн эдгээр хүүхдэд үзүүлсэн нөлөө олон үе дамжин үлдсэн. Бид хүүхдүүддээ анхаарал хандуулж, цаг зав гаргах юм бол дэвхрэг худалдаж авахаар явж байсан ч бай, бидний үзүүлсэн нөлөө олон үеийн турш үлдэж болох юм. ■

Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Мэйнд амьдардаг.

ЭЦЭГ ЭХИЙНХ НЬ АЛЬ НЭГ НЬ ЭСВЭЛ АЛЬ АЛЬ НЬ СҮМД ЯВАХГҮЙ БАЙХАД

Кармел Ньюл

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон хайраар дүүрэн гэр оронд өсөж торнисон ба эцэг эхээ хайрлан хүндэлдэг байжээ. Гэвч хүүхэд насандаа тэр эцэг эхгүйгээр ганцаараа сүмд явдаг байсан ба гэр бүлийнхэнтэйгээ ариун сүмд лацдан холбуулахыг ихэд хүсдэг байв.¹ Гэвч ямар ч хүүхэд гэрээний зам дээр ганцаараа алхах ёсгүй. Гэр бүлийнхнээсээ сайн мэдээний дэмжлэг туслалцаа хүлээн авдаггүй хүүхдүүдийн хувьд гэр бүлийн болон тойргийн гишүүдийн хайр, халамж гэр оронд нь сайн мэдээний дэмжлэг байхгүй орон зайг нөхөж болно. Орон гэрт болон сүмд сайн мэдээний сургаалыг хүчтэй заах мөн сайн сайхан туршлага суулгах нь хүүхэд бүрд Тэнгэрлэг Эцэгийн хайрыг мэдрэхэд тусална.

Ханьтайгаа хамт сүмд явдаггүй эцэг эхчүүдэд хандан хэлэхэд

1. **Сайн мэдээний дагуу амьдарснаар ирдэг адислалуудыг хуваалц.** Сайн мэдээний дагуу амьдрах нь амар амгаланг авчирч, ачааг тань хөнгөлдгийг олж харахад хүүхдүүддээ тусал. Сүмд явахыг хүсдэггүй аав, ээжийг нь муулалгүйгээр, сүмд явахыг сонгосон шалтгаанаа тайлбарла. Баптисмын гэрээгээ сахих нь хэрхэн танд тайтгарал, удирдамж өгдөг талаар бодол санаагаа хуваалц.
2. **Эерэг хандлагыг хөгжүүл.** Гэр бүлээсээ сайн сайхныг олж харахад нь хүүхдүүддээ тусал. Мөн



Хүүхдүүдтэй гэр оронд нь болон сүмд болж буй сайн сайхан үйл явдлуудын талаар ярилцах нь Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг мэдрэхэд тэдэнд тусална.

- та Сүмийн багш, удирдагч, тойргийн гишүүдээсээ сайн талыг нь олж харахад тэдэнд тусалж болно. Хүүхдүүдийнхээ сүм дээр сурсан зүйлүүдийн талаар ярилц. Бусдын сул тал дээр эсвэл эелдэг бус хэлсэн үгэн дээр анхаарлаа бүү хандуул. Харин оронд нь эерэг зүйл ярьж, бусдаас суралцах хүсэлтэй байгаагаа харуул.
3. **Сөрөг мэдрэмж дээрээ ажилла.** Хүүхдүүдэд айдас, ганцаардал,

урам хугарал, уур уцаар зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг ойлгоход нь тусал. Дараа нь та зураг зурах, тоглох, ярилцах гэх мэт арга замаар сэтгэл хөдлөлөө барьж сурахад нь тэдэнд тусалж чадна. Шаардлагатай бол та мэргэжлийн хүний тусламжийг эрэлхийлж болно. Шархалсан сэтгэлийг эдгээх нь хүн бүрд сүнсэлг мэдрэмжийг түлхүү хүлээн авч, Сүмд байхдаа илүү сайн

туршлага олж авахад тусалдаг.

4. Шаардлагатай бол тусламж хүс.

Хэрэв танд тусламж хэрэгтэй бол хэн нэгний тусламж санал болгохыг бүү хүлээ. Заримдаа Сүмийн удирдагчид болон тойргийн гишүүд хэрэгцээ шаардлагыг тань анзаарч харахгүй эсвэл таныг уриагүй байхад тусламж үзүүлэх эсэхдээ эргэлздэг байж болно. Хэрэв хүүхдэд адислал хэрэгтэй бол хэн тусалж болох талаар залбирч, дараа нь асуу. Мөн та хэнд тусалж чадахаа бодож үз.

Бүх насанд хүрэгчид хандан хэлэхэд

1. Эцэг эхийн аль нэггүйгээр эсвэл аль алингүйгээр Сүмд ирдэг хүүхдүүдэд анхаарал халамж тавьж, тэднийг хайрла. Тэдний нэрийг цээжилж, тэдэнтэй халуун дотно, сайхан сэтгэлээр мэндэлж бай. Тэдний нөхцөл байдлыг шүүлгүй, эцэг эхийг нь яагаад ирээгүй болохыг тэднээс бүү асуу. Хүүхдүүд Сүмийн гишүүдийн чин сэтгэлийн хайрыг мэдэрснээр биеэ чөлөөтэй авч явахад суралцан, Сүнснийг мэдрэх боломж нь ихэснэ.
2. Тусгай хэрэгцээ шаардлагад мэдрэмтгий бай. Хүүхдийг эцэг эхийн аль нэггүйгээр эсвэл аль алингүйгээр Сүмд ирэх үед ямар нэгэн тодорхой сургаал, үйл ажиллагаа тэдэнд хэрхэн нөлөөлж болох талаар анхаар. Санваарын адислалуудын талаарх хичээл дээр хүн бүр эдгээр адислалыг хүртэх боломжтой гэдгийг заа. Хэрэв үйл ажиллагаанд эцэг эхчүүд оролцох шаардлагатай бол бүх эцэг эхийг хамруул. Аавуудын болон ээжүүдийн өдөр зэрэг онцгой өдрийг эмзэг хүлээн

авч болзошгүй хүүхдүүдийг бодолцож үзээрэй.

3. Тэдэнд гэр бүлээ хайрлаж, хүчирхэгжүүлэхэд тусал. Гэр бүл Бурханаас томилогдсон гэдгийг хүүхдүүдэд заа.² Тэднийг гэрийнхнийхээ сайн сайхан байдалд талархдаг байхад урамшуул. Гэр бүлийн түүхийн ажил хүүхдүүдэд гэр бүл нь тэднийг төрөхөөс өмнө үүссэн гэдгийг ойлгоход тусалж чадна. Гэр бүлийн түүхийн ажлыг хийх нь тэднийг “гэр бүлдээ илүү ойртон дотносож мөн баяр баясгалантай”³ болгон адисалж болно.
4. Үнэн сургаалыг тэдэнд заа. Сонгох эрх нь авралын төлөвлөгөөний үндсэн сургаал бөгөөд хүүхдүүд эцэг эхийнхээ сонголт, гэм нүглийн төлөө хариуцлага хүлээхгүй (Мосе 6:54-ийг үзнэ үү). Эцэг эхийнх нь асуудал хүүхдүүдийнх нь буруу эсвэл хүүхдүүдийнх нь үүрэх хариуцлага биш юм. Үүнийг мэдэх нь өөрчилж чадахгүй зүйлсдээ санаа бага зовж, гэр бүлийнхээ өдөр тутам хүлээн авдаг олон адислалдаа талархалтай байхад тусална.

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг: “Тэнгэрлэг Эцэг маань гэр бүлийнхнийгээ бүрэн цуглуулж, адислахыг тэсэн ядан хүлээж байгаа. Энэ төлөвлөгөө хүүхэд бүрд урилгыг нь хүлээн авах эсвэл татгалзах боломжийг олгодог. Харин гэр бүл уг төлөвлөгөөний төвд байдаг”⁴ хэмээн заасан. ■
Зохиогч нь АНУ-ын Ютад амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Рассэлл М.Нэлсон, “Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт,” 2018 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 115-ыг үзнэ үү.
2. “The Family: A Proclamation to the World,” *Liahona*, May 2017, 145-ыг үзнэ үү.
3. Quentin L. Cook, “The Joy of Family History Work,” *Liahona*, Feb. 2016, 27.
4. Хэнри Б.Айринг, “Бурханы гэр бүлийг цуглуулах нь,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 3.

ХҮҮХДҮҮДЭД ЗОРИУЛАВ

Найз сэтгүүл дээр:

- Ерөнхийлөгч Нэлсоны хүүхэд насны дурсамж: “Эцэг эхдээ талархдаг байх нь” (2019 оны 6-р сар, Н2 хуудас)
- “Шинэ бүлэг” (2019 оны 6-р сар, Н4 хуудас)
- “Стивэний тэмдэглэсэн хамгийн анхны ирээдүйн аавуудын өдөр” (*Лиахона*, 2015 оны 6-р сар, 72-р хуудас)

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

Лиахона дээр:

- “Амьдрал бол марафон” (2019 оны 4-р сар, 54-р хуудас)



Төгс төлөвлөгөө

Таны төлөвлөгөө хэзээ хамгийн сүүлд бүтэлгүйтсэн бэ? Өнгөрсөн долоо хоногт уу? Минийх ч бас адил. Бидний төлөвлөгөө хэчнээн төгс байсан ч **амьдрал төлөвлөж байснаас өөрөөр эргэх нь** мөнх бус амьдралын жам бололтой. Би хоёр хүүхдийнхээ хооронд дөрвөн удаа зулбана гэж огтхон ч бодож байсангүй. Гэвч яг ийм зүйл надад тохиолдсон юм. Залбиран байж гаргасан төлөвлөгөө маань бодож байснаас эсрэгээр эргэн гайхшируулж эсвэл огт бүтэхгүй байвал **бид яах ёстой вэ?** Энэ дугаарт янз бүрийн нөхцөлд амьдардаг залуучууд гэр бүлийнх нь төлөвлөгөө санаснаар нь болохгүй байх үед дээрх асуултын талаар олж авсан хариултаа хуваалцана.

Нөхөр бид хоёрын хувьд зулбалт бидний төлөвлөгөөг нурааж, зүрх сэтгэлийг маань эмтэлсэн юм (44-р хуудсыг үзнэ үү). Катрин, түүний нөхөр хоёрын хувьд нийгмийн үзэл санаанаас Их Эзэний дуу хоолойг ялгаж салгаснаар зам дээрх саадаа авч хаясан байна (48-р хуудсыг үзнэ үү).

Зөвхөн цахим хувилбараар гарах нийтлэлүүдэд Кристина эх хүн болоход төрж байсан айдас, эргэлзээгээ хуваалцаж, харин Брайн цэргийн томилолт нь эхнэрийнхээ хамт гаргасан гэр

бүлийн төлөвлөгөөг нь нураах шахсан талаар яриу. Ганц бие залуу хүний хувьд Кэти эцэг эх болох бидний мөнхийн мөн чанарын талаарх ойлголтоо хуваалцав.

Та үр хүүхэдтэй болж гэр орноо адислагдахыг хүлээх, анх төлөвлөж байснаасаа олон хүүхэдтэй болох эсвэл зүгээр л гэрлэхийг хүсэж байгаа эсэхээсээ үл хамааран **Тэнгэрлэг Эцэгт төгс төлөвлөгөө бий** бөгөөд Тэрээр биднийг өөрсдийн хүслийг Түүний таалалд нийцүүлэхээр хичээх үед үргэлж хувь хүн рүү чиглэсэн, зөвхөн танд зориулсан арга замаар удирдан, дэмждэг гэдэг нь тодорхой.

Үр дүн ямар байхаас үл хамааран, зүгээр л **ЭНЭ дэлхийд үр хүүхдүүд авчрах гэсэн хүсэл эрмэлзэлтэй байх нь** Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөний талаар илүү гүн гүнзгий ойлголттой болгон адисална. Та бидний түүхийг уншсанаар, гэр бүлээ өсгөх аян замынхаа хаана явж байгаа гэдгээс үл хамааран, Ариун Сүнс замд тань тус болох ойлголт, хариултаа олоход таныг удирдан залах болтугай хэмээн би чин сэтгэлээсээ итгэн найдаж байна.

Уншлагын сайхан цаг!

Marionne van Bracht

ХАМГИЙН САЙН ЗӨВЛӨГӨӨ . . .

Залуучууд хүүхэдтэй болох талаар хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөөгөө хуваалцав.

“Биднийг анх гэрлэх үед нэгэн гайхалтай сайхан багш энэ бол эхнэр, нөхөр, Их Эзэн гурвын хооронд гаргадаг шийдвэр юм гэж хэлсэн. Хүмүүс үүнийг эхнэр, нөхөр хоёр л хоорондоо шийддэг хэмээн Их Эзэнийг оролцуулдаггүй гэж тэр бидэнд сэрэмжлүүлсэн юм. Их Эзэнийг шийдвэртээ оролцуулах нь төсөөлөхийн аргагүй ихээр биднийг адисалсан.

—**Бонни Корник, АНУ, Айдахо**

“Хүүхэдтэй болох төгс цагийг бүү хүлээ, тэгвэл та мөнхөд хүлээх болно.”

—**Анни Холл, Австрали, Квинсленд**

“Бусдын юу хэлэхэд бүү санаа зов! Энэ бол та болон таны хань мөн Тэнгэрлэг Эцэг та гурвын гаргах шийдвэр юм.”

—**Кулани Волтэрс, Шинэ Зеланд, Оакланд**

Саад бэрхшээлийг даван туулах талаар хүлээн авсан хамгийн сайн зөвлөгөө тань юу байсан бэ? Хариултаа liahona.lds.org вэбсайтаар 2019 оны 6-р сарын 30-ны дотор бидэнд ирүүлнэ үү.

ТҮҮХЭЭ ХУВААЛЦ

Танд хуваалцах гайхалтай сайхан түүх байна уу? Эсвэл та аль нэгэн сэдвээр бичсэн нийтлэлийг уншмаар байна уу? Хэрэв тийм бол бид таны үгийг сонсохыг хүсэж байна! Та өөрийн нийтлэл болон санал, сэтгэгдлийг liahona.lds.org руу илгээнэ үү.

ЗАЛУУ НИЙТЛЭГЧДИЙН ТУХАЙ


Марианн вон Брач гэр бүлийн цаг, дуу хөгжим, нарны гэрэл зэрэгт дуртай. Тэрээр нар үргэлж гийгээд байдаггүй АНУ-ын Мичиганы уугуул иргэний хувьд Христийн гэрэл зузаан үүлтэй байсан ч ямар ч өдрийг гэрэлтүүлж чадна гэдгийг мэддэг.



Катрин Рамирэз Дэ Пинэда нь Никарагуагийн Манагуа хотынх бөгөөд 18 настайдаа Сүмд нэгдсэн. Тэр англи хэлийг хоёрдогч хэлийн хувьд хэрхэн заах талаар суралцсан ба бага сургуулийн багшаар ажилладаг. Тэр нөхөртэйгөө Гватемала хотын Гватемала ариун сүмд лацдан холбуулсан ба гурван сайхан хүүхэдтэй.




Кэйти Сью Эмблий дэлхий сайхан хүмүүсээр дүүрэн бөгөөд тэдний түүхийг хуваалцах ёстой гэж боддог. Тэр #сайнсайхныг хуваалц гэсэн зорилготой сэтгүүлч болон испани хэлний мэргэжлээр суралцсан.



Брайн Моррилл эхнэр, хоёр охинтойгоо хамт АНУ-ын Виржиниа дахь Норфолк тэнгисийн цэргийн баазад амьдардаг. Тэр дэслэгч бөгөөд E-2 Hawkeye онгоцон дээр тэнгисийн цэргийн нислэгийн офицероор ажилладаг.



Кристина Кросланд саяхан Бригам Янгийн Их Сургуулийг төгссөн. Тэр чөлөөт цагаараа ном уншиж, ирээдүйн мөрөөдлийн номын сандаа зориулан ном цуглуулдаг. Тэр нөхөр, бяцхан охиныхоо хамт АНУ-ын Техас дахь шинэ гэртээ сайхан амьдарч байна.



ЭНЭ ХЭСЭГТ

44 Амьдралын улаан гэрэл дээр хүлээн зогсох нь
Марианн вон Брач

48 Хүүхэдтэй болсноор адислагдсан нь
Катрин Рамирэз Дэ Пинэда



ЗӨВХӨН ЦАХИМ ХУВИЛБАРААР

Эцэг эх байх нь бидний мөнхийн мөн чанар
Кэйти Сью Эмблий

Тэнгисийн цэрэг хүний болон манай гэр бүлийн хэрэгцээ
Брайн Моррилл

Хүүхэдтэй болох айдсаа даван гарсан нь
Кристина Кросланд

Эдгээр болон өөр нийтлэлийг доорх эх сурвалжаас олно уу.
Тухайлбал:

- Liahona.lds.org
- **YA Weekly** (Gospel Library аппликэйшн дээрх “the Young Adults” хэсэгт буй)
- [Facebook.com/liahona](https://www.facebook.com/liahona)

Амьдралын улаан гэрэл дээр зогсож хүлээх нь

Хэд хэдэн удаа
зулбасан явдал миний
амьдралд дараалан
ассан улаан гэрэл мэт
санагдаж байсан ч Их
Эзэнд хандсанаар,
хүүхдээ алдах бүрд
амар амгалан, аливааг
өөр өнцгөөс харах
боломж, өсөлт
хөгжил дагалдан
ирж байгааг би олж
мэдсэн юм.





Марианн вон Брач

Би улаан гэрэл рүү сэтгэл түгшин ширтэн суухдаа жолооны хүрдээ чанга атгасан байлаа. Эцэст нь ногоон гэрэл асахад би хурдалсан ч дахиад л эцэс төгсгөлгүй мэт үргэлжлэх бас нэгэн улаан гэрэл дээр зогсож хүлээх болов. Би номлогч эгч нартай хамт 5 минутын өмнө эхэлсэн байх ёстой хичээлд очихын тулд дахиад 10 минут явах хэрэгтэй байлаа. Би илүү ухаалаг ээж байсан бол гэрээсээ гарахдаа бараг гурав хүрч байгаа охин маань 15 минутын турш намайг орооно гэдгийг тооцоолох ёстой байсан ч тооцоолоогүй. Тийм ээ, би хоцорсон ч гэсэн амьдрал үргэлжилсээр байх тул сайн зүйл хийх гэж хичээж байгаа надад зориулан ядаж *зарим* гэрлэн дохиог ажиллуулж болохгүй байсан гэж үү? Би дараагийн гэрлэн дохион дээр цухалдан хүлээж байхдаа бухимдал маань уур болж байгааг мэдэрч байв. “Би сайн зүйл хийхээр хамгийн сайнаараа хичээж байна! Надад хэрэгтэй тусламж хаана байна вэ?” гэж би бодов.

Хорин сарын өмнө, улаан гэрэл асах үед дутагдаж байсан амгалан тайван байдлыг бүрдүүлсэн нэгэн газарт би бас үүнтэй төстэй нөхцөлд яг ингэж асууж байсансан.

Нью-Йоркийн Палмира дахь Ариун ойн цоорхойн эргэн тойронд модны бор мөчрүүд дээр навчис дөнгөж нахиалж байлаа. Газрын энд тэнд дөнгөж ногоорч буй бутлаг ургамлууд амьдрал авчирч байгаа мэт санагдаж байв. Ямар ч автомашин, замын хөдөлгөөн, чанга дуу чимээ сонсогдохгүй, зөвхөн сэвшээ салхи, хүүхдийн тэрэг, миний хөлийн чимээ л сонсогдож байлаа. Амар амгалан байсан ч оюун бодлыг минь асуулт, тодорхойгүй байдал шаналгаж байв. Миний нөхөр Ланс бид хоёр сүүлд хийлгэсэн хэт авиан болон цусны шинжилгээний хариуг сонсохоор эмчийнхээ утасдахыг хүлээн, хүндхэн 72 цагийг өнгөрүүлэв. Би хариулт хүлээж, тайтгарахыг хүсэж байв.

Тайтгарал хүлээн авсан нь

“Их Эзэн өөрийн Сүнсээр тэдэнд зочилж, мөн тэдэнд: Тайтгарагтун хэмээв. Мөн тэд тайтгарцгаав” (Алма 17:10).

Би Нью-Йоркийн Палмира ариун сүмийн гаднах өвлийг тэсэж гарсан цэцгүүдийг харан зогсож байв. Миний оюун ухаанд “Хэрэв энэ жирэмслэлт бүтэлгүйтвэл яана аа? Тэгвэл яах вэ?” гэсэн бодол орж ирэх нь тэр. Их Эзэн хаврын сэвшээ салхи мэт зөөлхнөөр оюун санаанд минь хүсэн хүлээж байсан тайтгарлыг өгөн яриулав. Надад эмчийн хэл дуулгахыг хүлээх шаардлагагүй болж билээ. Би энэ жирэмслэлт бүтэлгүйтнэ гэдгийг мэдсэн хэдий ч энэ бяцхан бодгаль Тэнгэрлэг Эцэгийн төгс, хайраар дүүрэн мутарт байгааг гэнэт ойлгосон юм. Өмнө нь мэдэрч байсан цөхрөл амар амгалангаар солигдож, дараагийн хэдэн долоо хоног, сарын турш намайг дэмжин, тайвшруулж байв.

Ногоон гэрлийг хүлээх нь

“Надад амар амгалан хэрэгтэй үед Их Эзэн над дээр олон арга замаар Тайвшруулагчтай хамт ирж байсанд би талархаж явдаг. Гэхдээ Тэнгэр дэх Эцэг маань бидний тав тухтай байдлаас илүүтэй дээш чиглэсэн өсөлт хөгжилд санаа тавьдаг.”¹ —Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Палмирад очсоноос хойш хэдэн өдрийн дараа хүндрэл үүсэж, би зулбав. Хэдийгээр амар амгалан мэдрэмж намайг дэмжсээр байсан ч хүүхдээ алдсаныхаа дараа би бие махбод, сэтгэл санааны хувьд ядарч туйлдан, дараа нь учрах зүйлсэд бэлтгэлгүй байсан юм. Би эхлээд лабораторийн шинжилгээний хариуг хүлээж байсан ба уг хариугаар энэ нь ховор тохиолддог, хэсэгчилсэн молийн жирэмслэлт байсныг тогтоов. Дараа нь хорт хавдрын илэрц байхгүйг баттай мэдэхийн тулд цусны шинжилгээг хэдэн долоо хоног, сүүлдээ бүр хэдэн сар хүлээж билээ. Олон сар хүлээсэн ч энэ цаг үед Их Эзэний мутар биднийг тайтгаруулж, тайвшруулж байсныг Ланс бид хоёр тодхон харж байсан. Хэсэгчилсэн молийн жирэмслэлтэд удаан хугацааны гаж нөлөө үзүүлээгүй тул эмч биднийг зургаан сарын дараа дахин жирэмсэлж болно гэв. Би амьдралынхаа зам дээр эргэн гарсан төдийгүй арай гэж улаан гэрэл ногоон болж солигдов.

Гэтэл ердөө гуравхан сарын дотор, хэд хэдэн цусны шинжилгээний дараа, Христийн мэндэлсний баяраас долоохон хоногийн өмнө би дахин зулбасан юм. Дахин гурван сар өнгөрч, жирэмсний тестээр эерэг хариу гарахад итгэл найдвараа алдсан байсан төдийгүй долоо хоногийн дараа зулбах үед дахин нэг улаан гэрэл асах нь тэр.

Итгэлээрээ соригдсон нь

“Хүчирхэг итгэлтэй байсан ч, олон уул нүүхгүй байж болно. . . . Бүх саад бэрхшээл алга болж, бүх өвчин эмгэг байдаггүй байсан бол Эцэгийн төлөвлөгөөний үндсэн зорилго нуран унах байсан.”² —Ахлагч Давид А.Бэднар

Би дахин жирэмсэлсэн ба дараагийн Христийн мэндэлсний баярын үеэр төрөх байлаа. Энэ жирэмслэлт бүтнэ гэсэн бодол надад төрсөн юм. Бид эхний хэт авиан үзлэгээр зүрх нь цохилж байхыг харсан ба гэрийнхэн маань бидний төлөө залбирч байгааг мэдэж байв. Нэг өдөр биднийг ариун сүмийн хувийн хишгийн ёслолд сууж байтал надад “Хэрэв энэ

жирэмслэлт бүтэлгүйтвэл миний итгэл хэвээр байх болов уу? Мэдээж, тийм. Энэ удаа би Их Эзэний хүсэл юу ч байсан хүлээж авахад бэлэн байгаа учраас би дахин зулбахгүй” гэсэн бодол орж ирэв.

Эерэг хандлагаас маань үл хамааран хэдэн долоо хоногийн дараа надад өмнөх шинж тэмдгүүд илэрч, би хэт авиан үзлэгт орж, нөгөө л танил зовлонтой үйл явц эхнээсээ эхэлсэн юм. Итгэл минь миний найдаж байсан шиг бат бөх байж чадсангүй. Өмнөх зулбасан тохиолдлуудад надад сэтгэлийн дэм болж байсан хариуцууд хангалттай санагдахаа болив. Ийнхүү би сэтгэлийн хямралд оров. Дотор өмрөх шиг болж, хоосон оргиж, бүр хууртаж мэхлүүлсэн мэт санагдаж байлаа. Их Эзэнийг нөхөр бид хоёроос гадна охин маань хүлээж байв. Тэр эрэгтэй, эмэгтэй хамаагүй, дүүтэй болохыг хэчнээн их хүсэж байгаагаа бидэнд байнга хэлж байсан. Бидний зүрх түүний өмнөөс ч бас эмтэрч байсан юм. Би Их Эзэнд сэтгэлээ уудлан залбирч байхдаа Тэнгэрлэг Эцэг миний зовлон шаналал, нөхцөл байдлыг маш сайн мэдэж байгаа бөгөөд надад хайртай гэсэн тов тодорхой гэрчлэлийг дахин хүлээн авав. Хэдийгээр миний нөхцөл байдал өөрчлөгдөөгүй ч энэ сайхан хэрнээ энгийн туршлага үүрч байсан ачааг минь гайхалтай гэгч хөнгөлөн, өдөр тутмын амьдралынхаа явцад дасан зохицох, тэр ч бүү хэл аз жаргалыг мэдрэх чадварыг надад өгсөн юм. Ирээдүйд юу ч тохиолдсон бай, би дажгүй байх болно.

Хэдэн сарын дараа генетикийн шинжилгээгээр ямар нэгэн хариу илрээгүйд бид амьдралд тохиолдож буй эдгээр саад бэрхшээлийн зорилгын талаар дахин гайхах болов. Би өөрийн хүслийг хойш тавьж, Их Эзэний таалалд нийцүүлэхээр чадах бүхнээ хийж байсан ч хүнд хэцүү үед “Би эндээс ямар сургамж авах ёстой юм бол? Би сайн зүйл хийхээр хичээж байна! Надад хэрэгтэй тусламж хаана байна вэ?” хэмээн зүрх сэтгэлдээ хашхирдаг байлаа.

Хандлагаа өөрчилсөн нь

“Хүнд хэцүү зүйлс ямагт байсаар ирсэн! Бид бүгдэд сорилт бэрхшээл тохиолддог. Хувьсагч нь хүнд хэцүү зүйлсэд үзүүлдэг бидний хариу үйлдэл юм.”³ —Ахлагч Стэнли Ж.Эллис

Дөрөв дэх зулбалтаас хойш найман сар, номлогч эгч нартай уулзахаар бухимдан,





жолоо барьж явсан тэр өдрөөс хойш хэдхэн долоо хоногийн дараа хариулт минь ирэх үед би гэртээ харих замдаа улаан гэрлийг тайван хүлээж байлаа. Би машинууд миний хажууд зогсож мөн хажуугаар урсан өнгөрөхийг хараад, амьдралаа мөнхийн төлөв байдлаас харж чадсан юм. Аялж байх үедээ тэнгэрлэг гэрт маань эргүүлэн аваачих зам дээр үлдэх явдал хамгийн чухал нь юм гэдгийг би гэнэт ухааран ойлгож билээ. Хэдэн “улаан гэрэл” дээр хүлээх вэ гэдэг нь миний очих газрыг өөрчлөхгүй. Харин үүнд би хэрхэн хандах вэ гэдэг нь үүнийг өөрчилнө.

Би амьдралынхаа бодит болон хийсвэр улаан гэрэл болгоныг нандигнан хайрлаж эхэлсэн. Би улаан гэрэл бүрийг дэмий цаг алдсан зүйл гэж харахын оронд тэвчээртэй байж, үүнийг зөвхөн хүлээж байж л олж авах өөр өнцгөөс харж сурах боломж хэмээн харах болсон юм. Янз бүрийн чиглэлд явах замын хөдөлгөөний бүх улаан гэрэл ногоон гэрэлтэй холбогдсон байдаг шиг амьдралын маань улаан гэрэл бүр яг миний төлөвлөж байснаар биш ч гэлээ өсөж хөгжихөөр төлөвлөж байснаас маань өөрөөр өсөж хөгжих арга замыг нээж өгсөн юм. Урам хугалсан зүйл дээр төвлөрөхийн оронд гэнэтийн үйл явдлуудын олгодог өсөж хөгжих боломжуудад би баярлах болсон.

Аврагч дээр анхаарлаа төвлөрүүлэх нь

“Бид итгэлээ юун дээр тавих вэ?” гэсэн чухал асуултыг эргэцүүлэн бодох хэрэгтэй. Итгэл маань зүгээр л өвдөлт, шаналлаас илааршихыг хүсэхэд чиглэж байна уу эсвэл Бурхан Эцэг, Түүний ариун төлөвлөгөө, Христ болох Есүст мөн Түүний Цагаатгалд бат бөх төвлөрч байна уу?”⁴ —Ахлагч Доналд Л.Холлстром

Эхний зулбалтаас хойш урт удаан хоёр жил өнгөрсний дараа би эгдүүтэй, хөөрхөн хүү төрүүлсэн юм. Гэр бүлийг маань тэрхүү баярт мөчид хүргэсэн цаг хугацаанд Есүс Христ миний амьдралаас бүх зовлон шаналлыг зайлуулахын тулд өмнөөс минь зовж шаналаагүй гэдгийг би ойлгосон. Харин Тэр тулгарч буй сорилт бэрхшээлээр маань дамжуулан надад хүчирхэгжих, өсөж хөгжих боломж олгохын тулд зовж шаналсан юм. Хэдийгээр хүүхдээ алдсан гунигт мөч, олон сарын хүлээлтийг эргэн санахад одоо ч гэсэн хэцүү байдаг ч эдгээр нь миний амьдралын нандин мөчүүд болсон. Би энэ л ариун нандин цаг мөчид Аврагч миний зовлон шаналлыг хувь хүний минь хувьд хэрхэн мэддэг болохыг ойлгосон. Тэр хувь хүний хувьд тулгарсан уй гашууг мэддэг хүний адил надад тусалж, намайг халамжилсан билээ. Хэдийгээр амьдралд тулгарах сорилт бэрхшээл өсөж хөгжих бидний төлөвлөгөөнд саад болж байгаа мэт санагдаж болох ч Их Эзэн биднийг Түүгээр хайрлуулж, хайрынх нь тухай олж мэдэн, илүү дээд түвшинд хүргэх зорилгоор саад бэрхшээлийг ашигладаг. ■

Зохиогч нь АНУ-ын Техаст амьдардаг.

ЭШЛЭЛҮҮД

1. Хэнри Б.Айринг, “Амар амгалангаа Би та нарт үлдээнэ,” *2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган*, 134.
2. David A. Bednar, “Accepting the Lord’s Will and Timing,” *Liahona*, Aug. 2016, 22.
3. Стэнли Ж.Эллис, “Бид Түүнд итгэдэг үү? Хүнд хэцүү зүйлс тустай байдаг,” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган*.
4. Доналд Л.Холлстром, “Гайхамшгуудын өдөр байхаа больсон гэж үү?” *2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган*, 86.

Хүмүүс биднийг хүүхэд төрүүлэх болгонд яагаад төрүүлж байгааг гайхан асуудаг байсан ч бид үр удмаараа дамжуулан Тэнгэрлэг Эцэгийн хайрыг илүү сайн ойлгож, тэнгэрлэг чадавхаа хөгжүүлэх боломжтой болдог.

Үр хүүхэдтэй болсноор адислагдсан нь

Катрин Рамирэз Дэ Пинэда

Энэ танай отгон хүүхэд үү? Намайг таваас доош насны хоёр хүүхэдтэй байж дахин жирэмслэхэд хүмүүс яагаад ч юм бидний хүүхдүүдийн талаар санал бодлоо илэрхийлдэг байлаа. “Энэ танай отгон хүүхэд үү? Та хоёрт дэндүү ойрхон байна гэж бодогдохгүй байна уу? Гурван хүүхэдтэй болж та хоёр яах гэж байгаа юм?” гэх мэт асуултыг би байнга сонсдог байв. Манай улсад ихэнхдээ хүмүүс эдийн засгийн асуудлаас болж ганц, хоёрхон хүүхэдтэй болдог байсныг ойлгож болох ч нөхөр бид хоёр болзож байхдаа хэдэн хүүхэдтэй болох, хэзээ төрүүлэхээ ярилцсан байсныг тэд мэдэхгүй байлаа. Гэр бүл төлөвлөлт бидний хувьд чухал, нухацтай шийдвэр байсан тул бид үүнийг Бурханы удирдамжийг байнга эрэлхийлэн, хамтарч гаргах ёстой байв. Бид эргэн тойрныхноо дуу хоолойг биш, харин

Сүнсийг илүүтэй сонссон бөгөөд үр хүүхдүүдээр адислагдсан юм.

Их Эзэн Абрахамтай гэрээ байгуулахдаа тоо томшгүй үр удамтай болно хэмээн түүнд амласан (Эхлэл 17:5-6; 22:17-г үзнэ үү). Бид судрын энэ хэсгээс Тэнгэрлэг Эцэгийн хувьд үр хүүхэд төрүүлэх нь бидний хүлээн авч болох хамгийн агуу адислалуудын нэг юм гэдгийг ойлгов. Бид үр удмаараа дамжуулан Тэнгэрлэг Эцэгийнхээ хайрыг илүү сайн ойлгож, тэнгэрлэг хийгээд мөнхийн чадавхаа хөгжүүлэх боломжтой болдог. Бид үр хүүхэд төрүүлснээр зөвхөн мөнх бус амьдралын өмнөх дэлхийд байгаа эдгээр сүнсэнд энэ дэлхийд ирэхэд нь туслаад зогсохгүй тэдэнд сайн мэдээг заах эрхтэй болох юм. Амьдралд үр хүүхэдтэй болохоос өөр биднийг мөнх амьдралд бэлтгэж чадах зүйлс цөөхөн гэдэгт би итгэдэг. Бидний гэр бүл Их Эзэний зан чанарыг





хөгжүүлж сурах хамгийн зохимжтой газар юм. Би одоо эх хүн болсноор Тэнгэрлэг Эцэгтээ ойр байх нь ямар чухал болохыг өдөр бүр санадаг. Би удирдамж, хүч, тэвчээр хүсэн байнга залбирахын зэрэгцээ үр хүүхэдтэй болсноор ирдэг олон адислалынхаа төлөө Түүнд талархдаг.

Эцэг эх байхад заримдаа сорилт бэрхшээл тулгардаг ч баяр баясгалантай мөчүүд ч олон байдаг. Том охин маань Хүүхдийн хэсгийн дуу дуулахыг сонсох эсвэл хоёр настай хүү маань гэр бүлийн залбирлын үеэр нүдээ аних гэж хичээж байгааг харах юм уу унтаж байгаа нялх хүүгээ тэврэх бүрд зүрх сэтгэл минь дүрслэхийн аргагүй баяр баяслаар дүүрдэг билээ. Амьдралд хэчнээн их сорилт бэрхшээл тулгарсан байлаа ч хүүхдүүд маань биднийг эцсээ хүртэл тэвчихэд туслан цэнэглэдэг юм. Тэнгэрлэг Эцэг надад

хүүхдүүдийнхээ эх байх боломжийг олгосонд би үнэхээр их талархдаг.

Тэнгэрлэг Эцэг биднийг хайрлагийг би мэднэ. Би жинхэнэ мөнхийн аз жаргалаар дүүрэн энэ амттай сайхан мөчүүдэд мөн сорилт бэрхшээлтэй тулгарахдаа Бурханы хайрыг мэдэрсэн. Тэрээр бидэнд тэнгэрлэг гэртээ эргэж очих замыг үзүүлэхээр Өөрийн Хүү Есүс Христийг илгээсэн юм. Би гэр бүлдээ хайртай бөгөөд гэр бүлүүд мөнхөд хамтдаа байж чадна гэдгийг мэднэ. ■

Зохиогч нь Никарагуагийн Манагуад амьдардаг.

Миний одоо явж байгаа сургуульд

Сүмийн гишүүд цөөхөн байдаг. Сүмийн гишүүн бус хүмүүст эцэстээ Сүмд хүрэх замаа олж харах боломж олгохын тулд жишгийнхээ дагуу амьдрах нь миний хувьд чухал юм. Учир нь энэ бол надаар дамжин сайн мэдээний гэрэл гэрэлтэх цорын ганц арга зам билээ. Одоо биш ч гэсэн хэзээ нэгэн өдөр тэд мөстэй цай болон кофе уудаггүй, хараал хэлж байгаагүй, сүмд явдаг байсан нэг сонин хүү байсныг санаж байна уу гэж байх. Хэзээ нэгэн өдөр миний үлгэр жишээ тэднийг байх ёстой газар руу нь хөтөлж ч магад.

Бусдаас өөр байж, ялгарахад хэцүү байж болно. Харин жишгээ дагахаа болих нь үнэхээр амархан. Гэр бүлийн маань үлгэр дуурайл, залбирал надад өдрийн турш тусалдаг. Залбирах нь жишгээ дагахыг надад сануулдаг.

Зөв зүйл хийж байгаа тэр мөчдөө хэзээ ч бүү эргэлз. Хүмүүс хийдэггүй зүйлийн тань төлөө таныг үргэлж шүүмжилнэ. Та мундаг байхгүй байж болно. Тэр бол тийм ч муу зүйл биш. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр таныг жишгээ сахивал мундаг байна гэж харна. Та эцсийн эцэст одоо хийж байгаа бүх зүйлээ өөрийг тань аз жаргалтай болгоно гэдгийг ойлгох болно. Үнэндээ энэ нь жишгээ сахиснаар ирдэг тэр мөнхийн баяр баясгалан юм. Тиймээс үргэлжлүүлэн, жишгийнхээ дагуу амьдраарай!

Натан О., Филиппин, Манила



ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ

ЭНЭ ХЭСЭГТ



- 52 Амьдралын бэлтгэл:
Биелүүлж чадах бодит
зорилго тавих нь**
Шакэлл Вордлэй
- 54 Авралын төлөвлөгөөг
ойлгосон нь надад амар
амгаланг өгсөн**
Нанси Риголд Ж.Микабани
- 56 Галилын хүмүүс**
Брэанна Колл Хэрбэрт
- 60 Асуулт, хариулт:
Бид сүмд болон семинарт
сууж байхдаа цахим хэрэг-
сэлд анхаарлаа хэрхэн
хандуулахгүй байх вэ?**
- 62 Бидний орон зай**
- 64 Сүүлчийн үг:
“Бүү айгтун, учир нь Би
чамтай хамт байна”**
Ахлагч Дэвид А.Бэднар

Биелүүлж чадах БОДИТ ЗОРИЛГО ТАВИХ НЬ

Та сайжирч, аль нэг чадвараа хөгжүүлж, ямар нэгэн шинэ зүйл сурахыг хүсэж байна уу? Та үүндээ хүрэхийн тулд зарим зорилго тавьсан нь тодорхой.

Шакэлл Вордлэй

Сүмийн сэтгүүлүүд

Бид заримдаа зорилгын урт жагсаалт гаргаж, тэдгээртээ хүрэхийн тул ихээхэн хичээл зүтгэл гаргадаг ч дараа нь зорилгоо мартаж, бууж өгдөг. Танил сонсогдож байна уу? Яагаад бид өөрчлөгдөж, сайжрахыг хүсдэг ч заримдаа тавьсан зорилгодоо тууштай байж чаддаггүй вэ? Үнэндээ, энэ нь бидний зорилго хэр бодитой мөн үүндээ хүрэхийн тулд хөдөлмөрлөхөд хэр зэрэг бэлэн байгаагаас шалтгаалдаг.

Хэрхэн бодит зорилго тавих талаар хэдэн санаа өгье.

- **Олон талаас нь харж тооцоолсон зорилго тавь.** Амьдралынхаа зөвхөн нэг бус, олон талыг хүчирхэгжүүлэхэд анхаар. Аврагч төгс жишээ үзүүлсэн. “Есүс бие болон мэргэн ухаан нь өссөөр байсан бөгөөд Бурханы болон олон түмний тааллыг олжээ” (Лук 2:52). Энэ нь Тэрээр оюун санаа, бие махбод, нийгэм, сүнслэг байдлын хувьд өсөж хөгжиж байсан гэсэн үг. Та ч бас үүнтэй адил зорилго тавьж болно. Таны зорилго өөрийг тань илүү сайн хүн болоход тусалж байгааг мэдэх нь тэдгээр дээр үргэлжлүүлэн ажиллах сэдлийг танд өгнө.
- **Зорилгоо бич.** Бичсэн зорилгоо өдөр бүр харж болох газарт тавь! Өрөөнийхөө самбар, сургуулийнхаа шүүгээ, тэр ч бүү хэл утсан дээр чинь байгаа эсэхээс үл хамааран зорилгоо байнга харж бай. Тавьсан зорилгоо санах тусам үүндээ хүрэхийн тулд үргэлжлүүлэн ажиллах магадлал тань өснө.



ХАМГИЙН ЧУХАЛ ЗОРИЛГО

“[Бурханы] оршихуйд эргэн очиж, гэрээнүүдийг байгуулж мөн сахиснаар ирдэг мөнхийн адислалуудыг хүлээн авах нь бидний тавьж болох хамгийн чухал зорилгууд юм.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард, “Эргэж очоод, хүлээн ав,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган”

- **Тодорхой бай.** Хэрэв та жагсаалтдаа зорилгоо “Шинэ зүйл сурах” гэж оруулсан бол энэ нь үнэндээ бодит ч гэлээ тодорхой зорилго биш юм. Та юу сурахыг хүсэж байна вэ? Шинэ зэмсэг үү? Шинэ жор уу? Магадгүй, шинэ хоббитой болмоор байна уу? Биелүүлэхийг хүсэж байгаа зүйлээ нарийн тодорхойл.
- **Зорилгодоо хүрэхэд цаг зав гарга.** Амьдралд цаг зав гарахгүй үе гардаг тул хичээл сургууль, ажил төрөл, найз нөхөд, гэр бүл гэсээр зорилгоо орхигдуулдаг тал бий. Харин та зорилго дээрээ өдөр бүр, долоо хоног тутам эсвэл хүссэн цагтаа ажиллах тодорхой цаг гаргавал үүн дээрээ тууштай ажиллах магадлал өсдөг.
- **Богино хугацааны зорилго тавь.** Та өөртөө том зорилго тавьж болох ч уг зорилгодоо хүрэх замдаа жижиг алхмуудыг хийсэн байх ёстой. Үндсэндээ, танд төлөвлөгөө хэрэгтэй. Жишээ нь, та энэ жил марафонд гүйхийг хүсэж байгаа. Та 42 км гүйхийн тулд эхлээд бага зайд гүйж эхлэх хэрэгтэй. Долоо хоног бүр хэдэн км гүйх зорилгоо тавьж, зайгаа долоо хоног бүр аажмаар нэм. Зорилгодоо хүрэх төлөвлөгөө гаргавал Бурхан үүндээ хүрэхэд бидэнд туслах болно (Сургаалт үгс 16:9-ийг үзнэ үү).
- **Хэтрүүлэн хийх хэрэггүй.** Хийнэ гэсэн болгоноо санах боломжгүй хэт их зорилго бүү тавь. Нэг удаа 40 зүйлийг зэрэг хийх гэж хичээхийн оронд хоёрхон чухал зорилго тавьж эхлэх юм бол та зорилгодоо хүрэхээр хичээж чармайхдаа бага бухимдаж, илүү их итгэлтэй байх болно. Бид эдгээрийг “мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийх хэрэгтэй, учир нь хүн өөрт нь буй хүчнээс илүү хурдан гүйх шаардлагагүй” (Мозая 4:27). Харин та нэг зорилгодоо хүрсэн тохиолдолд дараа дараагийн зорилгодоо хүрэхэд хялбар болдог! Жижиг зүйл том зүйл рүү хөтөлдгийг санагтун. ■

АВРАЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ойлгосон нь надад амар
амгаланг өгсөн

*Ээжийгээ эдгэршгүй
хорт хавдартай
гэж оношлогдоход
би ирээдүйгээ зөв-
хөн гунигтайгаар
харах болсон юм.
Харин ээж минь
дараа нь авралын
төлөвлөгөөний
талаар гэрчлэлээ
хуваалцсан.*

Нанси Риголд Ж.Микабани

Хэдэн жилийн өмнө, эцэг эхийн маань ойн өдрөөр ээж минь нойр булчирхайн 4-р шатны хорт хавдартай гэж оношлогдож билээ. Компьютер томографын хариу түүний хавдар амь насанд нь аюултай бөгөөд бие нь дордож байгааг харуулж байв. Энэ үед би ээжийгээ удаан амьдрахгүйг мэдсэн юм.

Би үүнд бэлтгэлгүй байв. Ээжгүйгээр миний амьдрал ямар байхыг төсөөлөхөд бүх зүйл харанхуй, дүнсгэр, гунигтай санагдаж байлаа. Ямар ч баяр баясгалан, инээд хөөр мөн намайг тайтгаруулах ээжийн дулаан тэврэлт байхгүй байх болно. Амьдрал огт байхгүй юм шиг санагдав.

Олон сар ч өнгөрч, ээжийн бие улам бүр сульдсаар. Намайг гайхшируулсан нэг зүйл бол тэр сүмдээ явах, гэр бүлээрээ судраас суралцахад өдөр бүр оролцох, гэр бүлийн үдэш дээр хичээл заах, тэр ч бүү хэл бидэнтэй инээлдэж хөхрөлдөх хүсэлтэй байсан юм.

Нэг өдөр би түүнээс "Та Тэнгэрлэг Эцэгтээ эргэлзэж байсан уу? Та яагаад хорт хавдар туссан талаар бодож байсан уу?" гэж асууж билээ. Ээж

инээмсэглэн, авралын төлөвлөгөөний талаар өөрийн гэрчлэлийг хуваалцсан юм. Тэр авралын төлөвлөгөөний өгдөг жинхэнэ аз жаргалыг мэдрэхийн тулд үүнийг сайн ойлгодог болох хэрэгтэй гэв. Хэрэв би хаанаас ирсэн, амьдралын зорилго юу болох, хаашаа явж байгаагаа ойлгодог болох юм бол бид үргэлж хамтдаа байж, үнэндээ бол ээжийгээ алдаагүй гэдгээ ойлгох болно гэж тэр надад хэлсэн. Тэр намайг номлолд бэлдэхэд мөн Есүс Христийн сайн мэдээ, авралын төлөвлөгөөг бусадтай хуваалцсанаар тайтгарал, аз жаргалын адислалуудыг хүлээн авах боломжийг тэдэнд олгоход үргэлжлүүлэн бэлдэхэд урамшуулсан юм.

Ээжийн зөв байсныг би ойлгосон. Хэрэв би гэрээгээ сахиж, Эцэгийн тааллыг гүйцэлдүүлснээр ээжийгээ дараагийн амьдралд харна гэдгээ мэддэг бол яагаад түүнийг энэ дэлхийд алдахаас айх билээ? Би амар амгаланг мэдэрсэн.

Ээж минь удалгүй өнгөрөв. Хэдийгээр ээжийн дурсгалд зориулсан оршуулгын өмнөх үйл ажиллагааны үеэр хэцүү, гунигтай байсан ч бүх зүйл амар амгалан санагдаж, би ээжийнхээ дэргэд байгааг мэдэрч байсан юм.


Эргэн тойрныхон маань ч өөдрөг байгаа мэт санагдаж байв. Би Бурханы тэнгэрлэг төлөвлөгөөг үнэхээр ойлгосноор хүлээн авдаг жинхэнэ адислалыг мэдэрч байгаагаа мэдэж байлаа.

Дараа нь ээжийг оршуулгын газар руу авч явах цаг болоход нэг хүү над дээр ирээд, намайг яагаад уйлахгүй байгааг асууж билээ. Би ээжийнхээ үхлийн талаар өмнө нь юу гэж боддог байснаа мөн ямар их уй гашууг олж харснаа санасан. Би инээмсэглэн, түүний өндрийн түвшинд тааруулан доош суугаад, “Хэрвээ би Бурханы зарлигуудыг үргэлжлүүлэн дагавал ээжийгээ дахин харна гэдгээ мэднэ” гэж түүнд хэлэв. Хүү ч гэсэн над руу инээмсэглэлээ. Тэр ч гэсэн миний мэдэрч байгаа амар амгаланг мэдэрснийг би мэдэж байлаа.

Ээж минь өнгөрсөн ч миний бодож байснаар харанхуй, дүнсгэр, уй гашуу амьдралыг минь нөмрөн авсангүй. Би түүнтэй салах ёс хийн, дараагийн амьдралд уулзацгаая гэж хэлсэн юм. Би түүнийг алдсан ч тайтгарлыг олж авсан. Энэ бол авралын төлөвлөгөөг ойлгосноор хүлээн авсан адислал байв. ■

Зохиогч нь Филиппинд амьдардаг.

Үхлийн дараах амьдралын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл хэн селестиел, терристриел, телестиел хаант улсуудыг өвлөн авах талаар тайлбарласан мөн эдгээр хаант улсын алдар сууг нар, сар, одтой харьцуулсан Сургаал ба Гэрээ 76-г уншина уу.



ГАЛИЛЫН ХҮМҮҮС



Брэанна Колл Хэрбэрт
Сүмийн сэтгүүлүүд

Аврагч дэлхий дээр байхдаа олон хүнд зааж, тохинуулсан. Тэд Есүс Христийн Галилд байхдаа тохинуулсан хүмүүсийн зарим нь байсан юм. Энэ хүмүүст судар дээрх өөрсдийн түүхийг ярих боломж олдвол тэд юу гэж ярих байсан бол? Энд хэд хэдэн санааг дурдав.




ХҮҮХЭД: Би Есүс Христийн болон Түүний төлөөлөгчдийн дэргэд зогсож байсан. Төлөөлөгчид

ямар нэг зүйлийн талаар маргалдаж байсан ба Есүс Христ үүний талаар тэднээс асуусан. Төлөөлөгчид өөрсдийнх нь хэн нь тэнгэрийн хаант улсад хамгийн агуу нэгэн байх талаар маргалдаж байсан учраас бүгд нам гүм болцгоож, хэн нь ч ам нээгээгүй. Дараа нь Аврагч намайг дуудсан. Намайг тэдний дунд орж зогсоход Тэр намайг энгэртээ тэвэрсэн. Тэр тэдэнд бяцхан хүүхэд адил даруу байх хэн боловч тэнгэрийн хаант улсад хамгийн агуу нь байх болно хэмээн хэлсэн. (Марк 9:33–37; Матай 18:1–5-ыг үзнэ үү.)



БЯЦХАН ХҮҮ: Би Есүс Христийн талаар болон Түүний өвчтэй хүмүүст үйлдсэн гайхамш-

гуудын тухай олж сонссон. Тиймээс Түүнийг Тиберт ирэхэд би дагаж байсан хүмүүсийн дунд оров. Бид олуулаа, бараг л 5000 хүн байв. Надад таван арвайн талх, хоёр загас байлаа. Есүс Христ тэдгээрийг авч, адислав. Гайхалтай нь бүх хүн надад байсан тэр хоолоор хооллосон юм. Гэвч үйл явдал үүгээр дуусаагүй. Хүмүүсийг цадсаны дараа шавь нар нь үлдэгдлийг цуглуулахад 12 сагс дүүрсэн гээч. (Иохан 6:5–14-ийг үзнэ үү.)



ЭРЭГТЭЙ ХҮН: Би саа өвчтэй байсан тул хөдөлж ч чадахаа больсон байлаа. Үүнээс гадна

би өөрийн мэдэлгүй салгалан чичирдэг байсан ба аймшигтай байдаг байв. Найзууд маань Есүс Христ нэгэн байшинд зааж байгааг дуулгасан юм. Тэд Түүнийг надад тусалж чадна гэдгийг мэдэж байсан тул намайг Түүн дээр аваачих гэж хичээв. Байшин пиг дүүрэн хүнтэй байсан тул тэд намайг дээврээс доош буулгахаар шийдсэн. Тэд дээврийг хуулж аваад, намайг Есүс Христийн өмнө доош буулгав. Тэр намайг хараад, нүглүүд чинь уучлагдсан гэлээ. Тэр намайг босож, дэвсгэрээ аваад, алх гэв. Намайг босож алхахад хүн бүр гайхаж байлаа! (Марк 2:1-12-ыг үзнэ үү.)



ТҮШМЭЛ: Би тэр үед Кана хотод байсан. Хүү минь Капернаумд үхлийн ирмэг дээр ирсэн байлаа. Есүсийг тэнд байгааг дуулаад, би Түүн дээр очив. Би ирээд, Капернаумд очиж, хүүг минь эдгээж өгөөч хэмээн Түүнээс гуйв. Тэр надад “Яв, чиний хүү амьд байгаа” гэж хэлсэн. Харин намайг Түүнд итгэн, гэртээ ирэхэд боолууд маань угтан авч, хүүг минь амьд байгаа гэж дуулгалаа. Түүнийг чухам аль цагаас сайжирч эхэлснийг асуухад тэд өчигдрийн долоон цагаас сайжирсныг хэлэв. Энэ нь хүүг маань амьд байна гэж Христийн айлдсан цаг яг мөн байлаа! (Иохан 4:46-53-ыг үзнэ үү.)

Түүнийг биеийг тавьсан булшин дээр очсон. Мөн би Амилалтын дараа Түүнийг харсан анхны хүн байсан. Эхлээд би Түүнийг цэцэрлэгч байна гэж бодсон ч намайг нэрээр минь дуудахад Аврагч минь байсныг таньсан юм. (Иохан 20:11-16-г үзнэ үү.)



МАГДАЛЫН МАРИА: Есүс Христ надаас долоон бузар сүнсийг зайлуулсан. Би Түүнийг

олон хот тосгоноор сайн мэдээг тунхаглан явахад дагаж явсан билээ. (Лук 8:1-3-ыг үзнэ үү.) Би Христийг цовдлуулах үед загалмайны дэргэд зогсож байсан (Иохан 19:25-ыг үзнэ үү). Би Түүний биеийг тавьсан булшин дээр очсон. Мөн би Амилалтын дараа Түүнийг харсан анхны хүн байсан. Эхлээд би Түүнийг цэцэрлэгч байна гэж бодсон ч намайг нэрээр минь дуудахад Аврагч минь байсныг таньсан юм. (Иохан 20:11-16-г үзнэ үү.)



САЛОМЕ: Би Зебедеен эхнэр бөгөөд Есүс Христийн хоёр төлөөлөгч Иаков, Иохан хоёрын эх байна.

Түүнийг Галилд байхад би дагаж яван мөн үйлчилж байсан. Би Түүнийг цовдлогдох үед Голгота хэмээх газар байсан. (Марк 15:37–41-ийг үзнэ үү.) Би Түүний биеийг тослохоор булшин дээр нь анхилуун үнэртэн авчирсан боловч намайг ирэхэд Тэр тэнд байсангүй. Оронд нь би урт цагаан нөмрөг нөмөрсөн нэгэн залууг олж харсан юм. Эхлээд би айсан боловч тэр намайг айх хэрэггүй гэв. Тэр Есүс Христийг амилсан бөгөөд энэ талаар төлөөлөгчдөд хэлэх хэрэгтэй гэж надад хэлсэн. (Марк 16:1–8-ыг үзнэ үү.)




СИМОН ПЕТРИЙН ХАДАМ ЭЭЖ: Би өндөр халуураад, өвдсөн байлаа. Есүс Христ үүнийг дуулаад

над дээр ирсэн юм. Түүнийг гараас минь бариад, намайг босгоход халуун гэнэт буурч, бие минь эрс сайжирсан тул би бүр эргэн тойрныхондоо үйлчилсэн гээч. (Марк 1:29–31-ийг үзнэ үү.)



НАЙН ХОТЫН БЭЛЭВСЭН ЭМЭГТЭЙ: Хүү минь дөнгөж нас бараад байв. Би

нөхрөө аль хэдийн алдсан байсан ба маш ихээр гашуудаж байлаа. Хэдийгээр маш олон хүн надтай хамт байсан ч би нулимсаа барьж чадахгүй байв. Миний хүүгийн биеийг хотын хаалганаас гаргах үед нэг хүн над дээр хүрч ирсэн юм. Тэр бол Есүс Христ байв. Тэр намайг ихэд өрөвдөн, “Бүү уйл” гэж хэлсэн. Тэгээд хүүгийн минь дэргэд очиход хүүг маань авч явсан хүмүүс зогссон юм. Есүс Христ миний хүүд бос гэж хэлэхэд тэр боссон! Тэр босож суугаад, ярьж эхэлсэн төдийгүй над дээр ирсэн юм. Тэр амьд байлаа! Бид бүгдээрээ Бурханыг алдаршуулж, бидний дунд агуу бошиглогч байгааг мэдэцгээсэн. (Лук 7:11–17-г үзнэ үү.)



МАРИА: Би Мессиа хэзээ нэгэн цагт ирэх тухай сонссон байв. Гэвч би энэ үйл явдлын нэгэн

хэсэг болно гэж бодож ч байсангүй. Тэнгэр элч намайг Бурханы Хүү болох нэгэн хүүхдийг тээж төрүүлэх бөгөөд Түүнийг Есүс хэмээн нэрлэх болно гэж надад хэлэх үед би Иосефтой сүй тавьсан байлаа. (Лук 1:26–38-ыг үзнэ үү.) Харин Мессиа ирсэн бөгөөд би Түүнийг малын хашаанд төрүүлсэн билээ. Хоньчид болон зурхайчид Түүн дээр ирж, Түүнд бэлэг өгсөн. (Матай 2:1–12; Лук 2:1–20-ийг үзнэ үү.) Иосеф бид хоёр Түүнийг өсгөсөн ч Тэр биднийг үргэлж гайхшируулдаг байв. Нэг удаа Тэр гурав хоног алга болсон ба бид эцэст нь Түүнийг ариун сүм дотроос олсон юм. Мэргэн цэцэн хүмүүс Түүнийг сонсон, Түүнээс асууж байлаа. (Лук 2:40–52-ыг үзнэ үү.)



ФИЛИП: Би Христийн төлөөлөгчдийн нэг нь байна. Тэр биднийг Өөрийн сайн мэдээг

тунхаглуулахаар илгээсэн. Тэр биднийг Израилын алдагдсан хоньдод анхаарлаа хандуул гэв. Тэр мөн бидэнд өвчтөнг эдгээх, уяман өвчтөнг эдгээх, нас барагсдыг босгох, чөтгөрийг зайлуулах хүчийг өгсөн юм. Тэр бидэнд мөнгө төгрөг, хувцас хунар ч авч авах хэрэггүй гэсэн хэдий ч хавчигдан гадуурхагдах болно гэдгийг бидэнд сэрэмжлүүлсэн. Хэдий тийм ч хэрэв бид эцсээ хүртэл тэвчиж чадах юм бол аврагдах болно гэдгээ мэдэж байсан тул Түүнд итгэж байв. (Матай 10:1–10, 17–18, 22–23-ыг үзнэ үү.)



ТАДДАЙ ИУДАС: Би бол Христийн төлөөлөгч. Нэг өдөр Тэр бидэнд урьдын адил зааж


байхдаа бидэнтэй тийм ч удаан хамт байхгүй гэдгээ хэлсэн юм. Хэрэв бид Түүний зарлигуудыг дагаж, Түүнийг хайрлах юм бол Тэрээр бидэн дээр ирж, Өөрийгөө илчлэх болно гэсэн. Тэр мөн заасан зүйлсийг нь бидэнд сануулах Ариун Сүнсийг илгээнэ гэж хэлсэн. (Иохан 14:19–27-г үзнэ үү.) ■

“Бид сүмд болон семинарт сууж байхдаа цахим хэрэгсэлд анхаарлаа хэрхэн хандуулахгүй байх вэ?”

“Ухаалаг гар утас зэрэг авсаархан хэрэгслүүд адислал боловч биднийг ‘намуун, зөөлөн’ дуу хоолойноос холдуулж сатааруулах чадвартай. Эдгээр хэрэгсэл бидний үйлчлэгч байхаас биш эзэн байх ёсгүй. . . .

. . . Ухаалаг утас маань найз нөхөд, гэр бүлтэйгээ, хамгийн чухал нь Бурхантай харилцах харилцаанд саад болж эхэлбэл бид үүнд өөрчлөлт хийх хэрэгтэй.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч М.Рассэлл Баллард “Хөдөлгөөнгүй байж мөн би бол Бурхан гэдгийг мэдэгтүн” (Church Educational System devotional for young adults, May 4, 2014), broadcasts.lds.org.



Нүднээс далд, сэтгэлээсээ хол байлга

Би сүмийн болон өсвөр үеийнхний үйл ажиллагаан дээр цахим хэрэгс-

лээ ашигладаг хандлагатай болохоо анзаарсан юм. Энэ нь бүр зуршил болсон байв. Би утсаа харах тоолонд шууд шүүрч аваад, шинэ мэдэгдэл эсвэл текст мессеж ирсэн эсэхийг шалгадаг болсон байлаа. Үүнийг яаж шийдэх вэ? Утсаа өөрөөсөө нуу. Утас цүнхэнд, сандал доор байвал эсвэл найзтайгаа хамт байх үед нүдэнд л харагдахгүй бол би хэрэглэх гэж уруу татагддаггүй.

Тарин М., 15 настай, АНУ, Флорида



Анхаарал сарниулахаас сэргийлж төхөөрөмжөө бэлтгэ

Та Хүндэтгэлийн өдөр бодол санаа, бие махбодоо бэлддэгийн адил

төхөөрөмжөө бэлтгэ. Хичээлийн үеэр гар утасныхаа дууг хаа. Хэрэв судраа эсвэл тэмдэглэлээ ашиглах шаардлагатай бол бусад аппликэйшнээс болж анхаарлаа сарниулахгүйн тулд Gospel Library-г тусад нь тавь.

Дэлгүймар С., 21 настай Бразил, Сан-Пауло

Тусламж гуйн залбир

Би залбирснаар Сүнсийг эрэлхийлдэг. Энэ нь намайг Хүндэтгэлийн өдөр болон семинарт сууж байхдаа цахим хэрэгслээ ашиглахгүй байхад тусалдаг. Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбирч, Мормоны Номыг унших тоолондоо төхөөрөмжөө ашиглахгүй байх арга замыг хүлээн авдаг.

Дэайр М., 18 настай, Зааны ясан эрэг, Комоз дүүрэг

Хэвлэмэл номууд байгааг бүү март!

Сайн мэдээг судалж байхдаа цахим хэрэгсэл ашиглах нь зөв ч заримдаа хэрэглээг хязгаарлаж чаддаггүй. Анхаарлаа сарниулахгүйн тулд судраа хэвлэмэл байдлаар ашиглахыг хичээгээрэй. Их Эзэн таныг удирдан чиглүүлж, та илүү ихийг сурч, Сүнсийг мэдрэх болно.

Аяана А., 13 настай, Филиппин, Лагуна

Хол байлга

Би Сүм дээр судраа ашиглахгүй л бол утасныхаа дууг хааж, халаасандаа байлгадаг. Харин ариун ёслолын үеэр утсаа огт ашигладаггүй. Би утсаа ашиглаж уруу татагдахгүйн тулд утсаа гараасаа хол байлгадаг.

Виллиам В., 17 настай, АНУ, Виржиниа

Эдгээр хариулт тусламж, ойлголт өгөх зорилготой бөгөөд Сүмийн сургаалын албан ёсны мэдэгдэл биш юм.



Найзууд маань гэрлэлт, гэр бүлийн талаарх бидний итгэл үнэмшилд эргэлзэх үед би юу гэж хариулбал зүйтэй вэ?

“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-т Тэргүүн Зөвлөл ба Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгынхан “эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна” (familyproclamation.lds.org) хэмээсэн байдаг.

Энэ тунхаг нь “илчлэлт авах үйл явц”-аар дамжин ирдэг “мөнхийн үнэний тухай мэдэгдэл” бөгөөд “жирийн нэг мэдэгдэл” биш юм (Даллин Х.Өүкс, “Төлөвлөгөө ба Тунхаг,” 2017 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 15, 14). Та үүнийг батлах хувийн итгэл үнэмшлээ мөн эдгээр үнэний танд авчирсан адислалуудыг хуваалцаж болно.

Бид бусдад хариулахдаа өөрийгөө зөвтгөх юм уу маргалдахаас зайлсхийж, тэднийг хайрлахыг хичээх хэрэгтэй. Нээлттэй, чин сэтгэлээсээ мэдэхийг хүсэж байгаа хүмүүс чин сэтгэлийн хариулт авах эрхтэй. Гэхдээ хэн нэгэн нь нухацтай хандаагүй, таны үзэл бодлыг тохуурхан, басамжилж эсвэл маргалдахыг хүсэж байгаа нь илт байвал ярихаас зайлсхийвэл зохино (Матай 7:6-г үзнэ үү).

Чи юу гэж бодож байна вэ?

“Сэтгэлийн дарамтад орсон найз нөхдийнхөө эргэн тойрныг би хэрхэн эерэг болгож чадах вэ?”

Хэрэв хүсвэл хариултаа өндөр нягтралтай зургийн хамт liahona.lds.org хаягаар (“Submit an Article or Feedback” дээр дар) 2019 оны 7-р сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Хариултын хэмжээг тохируулах эсвэл тодорхой болгохын тулд хянан засварлах магадлалтай.



ГҮЙ!

НЭГ ОРОЙ би гэртээ очихоор алхаж байв. Гэр маань найзуудтайгаа өмнө нь уулзсан газраас хэдхэн гудамжны зайтай байсан ч гэгээ тасарч, харанхуй болсон байлаа. Би хаашаа алхаж байгаагаа ч сайн харж чадахгүй байв.

Гурван залуу намайг дагаж байгааг би мэдлээ. Тэднээс холдох гэж хурдан хурдан алхаж эхэлсэн ч тэд намайг дагасаар л байв. Миний дотор айдас төрж эхлэхэд надад гүйе гэсэн тодорхой бодол орж ирэх нь тэр! Би гүвээ өөд гүйж эхлэв. Тэр гүвээ маш өгсүүр байсан ч би өөрт байхгүй нэгэн хүчийг мэдэрсэн юм. Энэ миний хүчээс давсан зүйл байв.

Тэр залуус ч бас гүйж, намайг гүйцэж эхэллээ. Би дараа нь яах ийхээ мэдэхгүй байв. Дахиад л, нарийн гарцаар урууд гэсэн

тодорхой бодол төрлөө. Би уруудаж байхдаа цагдаагийн ажилтан байхыг хараад гайхав. Бүх гудмаар гүйсэндээ тамирдан, амьсгаадсан би түүнээс тусламж гуйв. Тэр залуус цагдаатай ярьж байгааг маань хараад, намайг хөөхөө больж, явцгаасан юм. Миний аюулгүй байдлыг хангах үүднээс цагдаагийн ажилтан намайг гэрт хүргэж өгөв.

Тэр орой хүлээн авсан сүнслэг өдөөлт маань санаанаас гарахгүй байлаа. Тэнгэрлэг Эцэг надад тусалсныг мэдэж байсан тул би амар амгаланг мэдрэв. Би Түүний удирдамжинд талархан залбирсан юм. Хэрэв бид Сүнсний дуу хоолойг дагах юм бол аюулгүй байх болно гэдгийг би мэднэ.

Мартин С., Аргентин, Пуэрто Мадрин

“Та хамгийн шилдэг хөтөч болох Ариун Сүнсний шивнээг хэрхэн дагахыг сурч болно. Энэ бол хувийн илчлэлт юм. Биднийг сүнслэг аюулаас сэрэмжлүүлдэг үйл явц бий.”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын ерөнхийлөгч Бойд К.Пакэр (1924–2015), “Spiritual Crocodiles,” *Ensign*, May 1976, 31.

— Би өдөөлтийг сонсож, дагахад хэрхэн бэлэн байж чадах вэ?

1. Тайван бай.

Нам тайван орчинд тунгаан бодож, эргэцүүлэн бодох цаг гаргах нь Сүнсийг сонсоход тань туслах болно (Дуулал 46:10-ыг үзнэ үү).

2. Наманчил.

Наманчлал нь таныг цэвэршүүлдэг ба тэгснээр Сүнс таны хамтрагч байх болно (Алма 34:36-г үзнэ үү).

3. Суралц.

Та Их Эзэний үгсийг мэдсэнээр Түүний дуу хоолойг танихад илүү хялбар болдог (Сургаал ба Гэрээ 1:38-ыг үзнэ үү).

ОРНООСОО БОСОХ НЬ МИНИЙ ҮҮРЭГ

НЯМ ГАРАГТ ихэвчлэн ээж намайг сүмд явахад бэлдэж, цуглаан эхлэхээс өмнө очихын тулд сэрээдэг байв. Харин нэг ням гараг ээж намайг сэрээсэнгүй. Би сэрээд, сүмд явахаар бэлдэхдээ гэрийнхнийхээ гаргадаг шуугианыг сонсохгүй байгаагаа анзаарав. Цаг руу сандран хараад, гучин минут хоцорсон байснаа ухаарлаа. Би ариун ёслолоос хоцорсон байв. Бас Ням гаргийн ангиас ч хоцорсон бололтой.

Би сандран тэвдэж, хаягдсан мэт санагдаж байлаа. Ээж намайг яагаад өглөө сэрээгээгүй юм бол? Тэр үргэлж намайг сэрээдэг шүү дээ. Сүмд хоцроохгүйн тулд намайг сэрээх нь ээжийн үүрэг биш, харин миний үүрэг гэсэн бодол гэнэт надад төрсөн юм. Би Тэнгэрлэг Эцэгтэй өөрөө гэрээ байгуулсан ба гэрээгээ сахих нь миний үүрэг байв.

Ээж тэр орой яагаад намайг сүмд явуулахаар сэрээгүйгээ тайлбарласан юм. Тэр намайг дахин сэрээхгүй мөн өөрийн гэсэн гэрчлэлтэй болохын тулд өөрөө хичээл зүтгэл гаргах ёстой гэв.

Тэр долоо хоногийн турш би эцэг эхийнхээ гэрчлэлээр үргэлж амьдраад байж чадахгүй гэдгээ мөн өөрийн гэрчлэлийг хүчирхэгжүүлэхийн тулд хэрхэн илүү шаргуу хичээх талаар бодож байгаагаа мэдсэн юм. Тэр өдрөөс хойш би сүмдээ цагтаа очиж, ариун ёслолоос хүртэхийн тулд ням гараг бүр эрт босох гэж ихэд хичээх болсон. Би сүнслэг байдлын хувьд бие дааж сурч байгаа.

Лиан Алвэс, Бразил, Сеара



ӨШИГЛҮҮЛСЭН Ч САЙХАН СЭТГЭЛЭЭР ХАНДСАН

БИ ХУДАЛДАН авсан хоол хүнснийхээ төлбөрийг хийхээр ээжтэй хамт дараалалд зогсож байв. Хүн ихтэй байсан тул ээж худалдан авалтаа хийхийн тулд өмнө зогсох хүү рүү тонгойхоос өөр зам байсангүй. Тэр хүү ээж рүү өшиглөж эхлэв. Түүнийг хоёр дахь удаагаа өшиглөхөд ээж хойш ухраад, “Намайг өшиглөхөө болиорой?” гэв.

Хүүгийн ээж эргэж хараад, өшиглүүлж байгаа чинь өөрийн тань буруу гэж ээжид хэллээ. Тэр бас биднийг есөн шидээр доромжлов. Би түүнийг эргэж хараад, кассчинтай хүртэл бүдүүлэг харьцаж байгааг нь харлаа. Бид тайван байсан ч дотроо уур хүрч байв. Энэ явдал миний дургүйг хүргэж байлаа. Болсон явдалд ээж бид хоёрын буруу байхгүйг би мэдэж байсан ч дотроо гомдсоор байв.

Бид гэртээ ирснийхээ дараа өрөөндөө орж, судраа гаргав. Минут хэртэй уншсаны дараа надад залбирах хэрэгтэй гэсэн мэдрэмж төрлөө. Залбирмааргүй санагдсан ч би өвдөг сөгдөн, залбирч эхлэв. Сүүлд нь би бидэнтэй муухай харьцсан эмэгтэйн төлөө залбирч байгаагаа мэдсэн юм. Өмнө нь мэдэрч байгаагүй тийм амар амгаланг би тэгэхэд л мэдэрсэн. Миний сэтгэлд түүнд уурлах зай байхгүй байсан ба би хайрыг мэдэрсэн.

Тэрэса Г., АНУ, Айдахо



“Бүү айгтун, учир нь Би чамтай хамт байна”

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулга
Ахлагч Дэвид А.Бэднар

Цэргийн нэгэн алдартай удирдагч: “Хэзээ ч айдсаасаа зөвлөгөө бүү ав”¹ хэмээх мэдэгдлийг онцлон хийсэн байдаг.

Өнөөдөр бид эргэн тойронд болж буй зүйлсээ бодож үзэх юм бол амьдралд бидний урт удаан хугацаанд хүсэн хүлээж байсан зүйлс итгэж найдаж байснаар маань болох болов уу гэж айж, эргэлзэн, мэдэхийг хүсэх олон шалтгаан олж болно.

Та нарын зарим нь материаллаг болон сүнс-лэг байдлын хувьд амжилтад хүрэх чадвартаа эргэлзэж эсвэл итгэл мөхөсдөж байж болох юм. Магадгүй, бүр Их Эзэн дэмжинэ, чиглүүлнэ хэмээх амлалтаа биелүүлснийг олон хүний амьдралаас олж харсан ч үүнийг өөрийнхөө амьдралаас олж харах боломжтой байгаа эсэхэд эргэлзэж байж болох юм. Та үйл явдал хэрхэн өрнөхийг урьдчилан харж чадахгүй тул тухайн боломж бололцоог ашиглахдаа итгэлгүй байгаагаасаа болж уг зам дээр эхний алхмаа хийхээс эмээж байж болох юм. Эсвэл та итгэлээр үйлдэж, урагш алхаж чадалгүй алдаа гаргахаас санаа зовж, айж явдаг зүйлээсээ болж бүтэлгүйтэх магадлалаа нэмэгдүүлж байж ч магадгүй.

Айдсаасаа зөвлөгөө авахгүй байна гэдгийг энгийн үгээр тайлбарлавал, бид айдас, тодорхойгүй байдалд өөрийн амьдралын чиг шугамыг тодорхойлох, хандлага, зан авиртаа сөргөөр нөлөөлөх, чухал шийдвэртээ буруу нөлөө үзүүлэх эсвэл энэ дэлхий дээрх бүх ариун журамтай, сайн сайхан эсвээс сайшаалтай бүхнээс холдуулах эсвэл анхаарлыг сарниулах боломж олгохгүй байхыг хэлнэ. Мөн айдсаасаа зөвлөгөө авахгүй байна гэдэг нь

Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл маань бидний айдсыг ялан дийлж, Түүнд тууштай байн, урагшлан явахыг хэлнэ. Эцэст нь, айдсаасаа зөвлөгөө авахгүй байна гэдэг нь Бурханы удирдамж, зааварчилгаа, амлалт болон бидний амьдралд сонгосон цаг хугацаанд итгэхийг хэлнэ. Бид айдсаасаа зөвлөгөө авахгүй байж сурснаар зааварчилгаа, хамгаалалт, урт удаан үргэлжлэх баяр баясгалангаар адислагдах болно гэдгийг би амлаж байна.

Христэд итгэх итгэлээ хөгжүүлж, Түүний амлалтад итгэснээр харанхуйд бидний замыг наад зах нь дараа дараагийн алхмаа хийхэд хангалттай гэрлээр гэрэлтүүлэх болно гэдэгт төгс итгэлтэйгээр бид алхаж чадна.

Иосеф Смит “Хэрэв бид итгэлтэй байвал бидэнд айх зүйл байхгүй”² хэмээн тунхагласан.

Ерөнхийлөгч Томас С.Монсон (1927–2018) “Бүү ай. Зоригтой бай. Ирээдүй та нарын итгэл лүгээ адил гэрэл гэгээтэй байна”³ хэмээн зөвлөсөн.

Та ирээдүйтэй итгэл дүүрэн нүүр тулах юм бол таны бүхий л зөв шударга оролдлого болон амьдралын бүхий л өдөрт Аврагч таны нүүрний өмнө явж, баруун гар талд мөн зүүнтээ байж, Түүний Сүнс та нарын зүрх сэтгэлд байх болно (Сургаал ба Гэрээ 84:88-ыг үзнэ үү). ■

2012 оны 12-р сарын 15-нд Хавай дахь Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн үгээс авав.

ЭШЛЭЛҮҮД

1. In Mary Anna Jackson, *Memoirs of Stonewall Jackson* (1895), 264.
2. *The Personal Writings of Joseph Smith*, ed. Dean C. Jessee, rev. ed. (2002), 338.
3. Томас С.Монсон, “Зоригтой бай,” 2009 оны 4-р сарын Ерөнхий чуулган.

Тэр 1952 оны 6-р сарын
15-нд **Калифор-**
нийн Сан
Леандрод
төрсөн.



Тэр Өмнөд
Германд
НОМЛОЛД
үйлчилсэн.

1974-2004 онд
Айдахо дахь
БЯИС-д
ерөнхийлөгчөөр
үйлчилж байсан.



Ахлагч **ДЭВИД А.БЭЭДНАР**



1975 онд
Солт
Лэйкийн
ариун сүмд
Сьюсан Робинсонтой
гэрлэсэн.



Тэр багадаа
гэр бүлийн-
хэндээ
жимсээ
нөөшлөхөд
тусалдаг
байв.

Жимснүүд шилэн саванд
нь орохоос илүүтэй
гэдсэнд нь ордог байсан
гэж тэр хошигнон
ярьдаг.



Тэрээр
ахлах
сургуулийнхаа
хөл бөмбөгийн
багт
хамгаалагч байжээ.

Флаг-футбол тоглолт дээр тэр
эхнэртэйгээ танилцжээ. Тэр холын
зайн дамжуулалтаараа эхнэрийнхээ
анхаарлыг татсан
байна.



Техасын Технологийн
Их Сургууль болон
Арканзасын Их
Сургуульд тус тус
профессороор
ажилладаг байв.

Бригам Янгийн Их
Сургуулийг төгссөн.

Пурдюгийн Их Сургуульд байгууллагын
төлөв байдлаар **докторын**
зэрэг хамгаалжээ.



2004 оны 10-р
сарын 7-нд
Арван хоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
гишүүнээр дэмжигдэн
батлагдсан.



Гурван
хүүтэй

Дуртай дууллаудынх нь нэг нь
“Израилын
Цагаатгагч”
(Сүмийн дуулал болон
хүүдийн дууны ном, ху. 5)





ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

**ГЭР БҮЛЭЭ ТӨЛӨВЛӨЖ
БАЙНА УУ?**

*Энэ сард залуучууд хүүхэд
төрүүлэхэд тулгарч буй
асуудлууд болон тэдгээрийг
хэрхэн даван гарах талаарх
өөрсдийн туршлагыг хуваалцав.*

42

ӨСВӨР ҮЕИЙНХЭНД
ЗОРИУЛАВ
**ЗОРИЛГО ТАВИХ
УДИРДАМЖ**

52

ҮХЭЛ БА ГАШУУДАЛ
**БУРХАНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨГ
ОЙЛГОХ НЬ**

54

ШИНЭ ГЭРЭЭ
**ГАЛИЛЫН
ХҮМҮҮСТЭЙ ТАНИЛЦ**

26, 56

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ



Найз



**Бүгд Найрамдах
Доминикан
Улсаас**

мэндчилж байна!

Н8-Н11 хуудас



Ерөнхийлөгч
Рассэлл М.Нэлсон

ЭЦЭГ ЭХДЭЭ ТАЛАРХДАГ БАЙХ



Та ямар нэгэн сайн сайхан зүйл тохиолдохыг хүсэн хүлээж байсан уу? Таныг хүлээж байх зуур юу танд тус болох вэ?

Бүх элэнц эмээ, өвөө маань наймуулаа Европт Сүмд нэгдсэн. Тэд Сүмд маш их итгэлтэй байсан юм. Дараа нь зарим өвөг дээдэс маань сайн мэдээний дагуу амьдрахаа больсон. Үүнээс болж эцэг эх маань намайг бага байхад сүмд тийм ч их явдаггүй байлаа.

Би эцэг эхдээ хайртай байв. Тэд надад маш чухал сургамжийг заасан юм. Тэд бидэнд аз жаргалтай гэр орныг өгсөнд би талархаад ч баршгүй. Гэхдээ манай гэр бүл сүмд бараг явдаггүй байсан тул би бага байхаасаа л миний амьдралд ямар нэгэн зүйл дутагдаж байгааг мэддэг байв. Нэг удаа би нийтийн унаанд сууж, Сүмийн тухай ном олохоор номын дэлгүүр лүү явж билээ. Би сайн мэдээний талаар суралцах дуртай байлаа.


Би мэргэн ухааны үгийн талаар олж мэдсэнийхээ дараа, эцэг эх маань үүнд заасны дагуу амьдрахгүй байгааг ухаарсан. Гэсэн ч би тэднийг тэр хуулийн дагуу амьдраасай гэж ямар их хүссэн гээч! Тиймээс

би гэрт байсан архи бүрийг бетонон шалан дээр хагалж билээ. Аав намайг шийтгэх байх гэж би бодсон ч тэр надад энэ талаар ганц ч үг хэлээгүй.

Би өсөж том болох тусам сайн мэдээний талаар суралцсаар байв. Тэнгэрлэг Эцэгийн гайхалтай сайхан төлөвлөгөөг би ойлгож эхэлсэн. Би 16 насандаа баптисм хүртсэн юм. Би Христийн мэндэлсний баярын үеэр өөртөө “Би баярын өөр ямар ч бэлэг авхыг хүсэхгүй байна! Би зүгээр л ээж, аавтайгаа ариун сүмд лацдан холбуулмаар байна” гэж олонтоо хэлдэг байв. Би энэ мөрөөдлөө биелэхийг олон жил хүлээсэн. Эцэг эх минь 80 нас хүрсний дараа л бид гэр бүлээрээ лацдан холбуулсан даа. Би тэр өдөр агуу их баяр баясгаланг мэдэрсэн. Тэд хоорондоо болон надтай лацдан холбогдсон гэж бодохдоо би өдөр бүр баяр баясгаланг мэдэрдэг. ●

2018 оны 4-р сарын Ерөнхий чуулганы “Сүмд болон бидний амьдралд зориулсан илчлэлт” үгээс авав.

Будах хуудас



“Тэнгэрлэг Эцэгтээ
зүрх сэтгэлээ уудал.
Хариулт, тайтгарал ава-
хын тулд Түүнд ханд.”

—Ерөнхийлөгч
Рассэлл М.Нэлсон

ШИНЭ БҮЛГЭГ

Жэйн Макбрайд

Бодит түүхээс сэдэвлэв

“These many blessings make me feel so thankful to be me” (Children’s Songbook, 11).

Ээжийгээ орж ирэхэд Сара өрөөндөө хайрцгаа задалж байлаа.

“Бид энэ ханыг шараар будаж болох уу?” гэж тэр ээжээсээ асуув.

Тэд дөнгөж саяхан өөр байшинд нүүж ирсэн юм. Сара шинэ өрөөндөө зориулан, ширмэл хөнжил бас хөшиг сонгож чаджээ.

“Болно гэж бодож байна. Шар өнгө бол аз жаргалын өнгө шүү дээ” гэж ээж нь хэллээ.

Сара орныхоо дэргэдэх жижиг тавиур дээр хэдэн ном тавив. Аав нь ослоор өнгөрснөөс хойш сүүлийн үед ээж нь үргэлж аз жаргалтай байхаа больсон байлаа. Сара

харах дуртай аавынхаа зургийг өглөө бүр сэрэхдээ харж байхын тулд номнуудынхаа хажууд болгоомжтой гэгч тавив.

Тэр хамар шуухитнах чимээнээр ээжийнхээ нүдэнд нулимс цийлэгнэж байгааг харлаа.

Сара ээжийнхээ бэлхүүсээр чанга тэврээд, “Ээж ээ, би танд хайртай” гэв.

“Би чамд бүр ч их хайртай” гэж ээж нь хариуд нь хэллээ.

Хичээл эхлэхийн өмнөх бямба гарагт Сара ээжтэйгээ хуучин хувцсаа өмсөн, өрөөнийхөө голд тавилгуудаа зөөж тавиад, шар будагтай саванд будгийн өнхрүүш болгоомжтой гэгч нь дүрлээ. Хэсэг хугацааны дараа хана ч тэр, тэдний нүүр, хувцас ч тэр шар болсон байв!



“Чам дээр нарны гэрлийг цацсан юм шиг харагдаж байна” гээд ээж нь инээмсэглэлээ.

Сара хөхрөн, “Харин таны хажууд гадил жимс дэлбэрсэн юм шиг харагдаж байна!” гэв.

Тэд цэвэрлэж байхдаа ч инээлдсээр байв. Сара маргааш Хүүхдийн хэсэгтээ, нөгөөдөр сургуульдаа явах талаар бодоод, инээмсэглэхээ болив.

Тэднийг будгийн багсаа угаалтуурт зайлж байхад тэр ээждээ “Би сүмд болон шинэ сургуульд явна гэхээс санаа зовж байна. Би багш, хүүхдүүд гээд ямар ч хүнийг ч танихгүй шүү дээ” гэлээ.

Ээж нь усаа хаагаад, Сараг тэврэв.

“Чи найзтай болно шүү дээ. Чи минь бусдыг өөртөө татах сайхан сэтгэлтэй. Чи өөрөөрөө байхад л найзууд аяндаа ирэх болно” гэв.

Сараагийн сэтгэл бага зэрэг амарсан ч санаа зовсон хэвээр л байлаа.

“Аав энд байж, надад адислал өгдөг ч болоосой. Тэр намайг хичээлд орохоос өмнө байнга өгдөг байсан” гэв.

Ээж хэсэг зуур чимээгүй байснаа, “Нагац ах Вайэ-таас гуйвал яаж байна? Тэр чамд дуртайяа адислал өгнө гэж би бодож байна” гэж ээж хэлэв.

Сара ч толгой дохилоо. Магадгүй, адислал тус болох байх.

Тэр орой Сарагийн нагац ах толгой дээр нь гараа тавин, түүнд адислал өгөв.

“Амьдралынхаа шинэ бүлгийг эхлүүлж байгаа энэ үед Аврагч чамайг харж хандаж байгаа гэдгийг



мэдээсэй хэмээн би адисалж байна. Тэр хэзээ ч чамайг ганцааранг чинь орхихгүй” гэж тэр хэлсэн юм.

Сараагийн анхаарлыг *шинэ бүлэг* гэсэн үг ихэд татав. Тэр ном унших дуртай бөгөөд номны шинэ бүлэг эхлэхэд үргэлж догдолдог байлаа.

Маргааш нь Сара ээжтэйгээ хамт сүмд явав.

Ариун ёслолын дараа ээж нь Сарад Хүүхдийн хэсгийн ангиа олоход нь тусаллаа. Ангид байсан нэг охин түүн рүү инээмсэглэн, сайн уу гэж мэндлээд,

хажуугийн хоосон сандлаа заан “Чи хүсвэл

энд сууж болно шүү” гэв.

Сара ч “Баярлалаа. Намайг Сара гэдэг. Би энд шинээр ирсэн” гэж хэллээ.

“Намайг Мелоди гэдэг. Би ч бас энд шинээр ирсэн! Ирээд хоёр долоо хоног болж байна” гэв.

Нэг их удалгүй Мелоди, Сара хоёр Хүүхдийн хэсгийн бусад хүүхэдтэй ярилцаж байлаа. Багш нь маш сайхан хүн байв.

“Сургууль дээр ч бас ийм байгаасай!” гэж Сара тэр орой орондоо орохдоо бодлоо.

Маргааш нь Сара шинэ сургууль руугаа автобусаар явав. Тэр гуравдугаар ангийнхны дунд Хүүхдийн хэсгийн хэдэн хүүхэд байгааг хараад баярлалаа.

Тэр шинэ найзуудтайгаа хамт өдрийн хоолоо идэж байхдаа “Тэнгэрлэг Эцэг минь, баярлалаа” хэмээн дотроо залбирав. “Эцсийн эцэст энэ сайн бүлэг байх бололтой.” ●

Зохиогч нь АНУ-ын Колорагод амьдардаг.

Ахлагч Күк Бразилд айлчлав




Ахлагч Квинтин Л.Күк, Күк эгч хоёр Сүмийн гишүүд дээр айлчлахаар Бразилд очив. Тэд Есүс Христийн хайрын талаар зааж, хуваалцахаар очсон юм.



Тэд Бело Хоризонте хэмээх томоохон хотод айлчиллаа. Энэ хотын нэр "үзэсгэлэнт тэнгэрийн хаяа" гэсэн утгатай. Ахлагч Күк энэ хотод хэзээ ч харж байгаагүй хамгийн үзэсгэлэнтэй нар жаргахыг харсан гэв.

Бид гэрэл болсноор дэлхийд сайнаар нөлөөлдөг.





Ахлагч Күк болон Күк эгч хоёр
номлогчийг бэлтгэх төвд айлчлан очсон.
Номлогчид Есүс Христийн гэрлийг
өдөр бүр хуваалцдаг!




Хүүхдүүд Бурханы төлөөлөгчтэй
уулзсандаа маш их баяртай байв.

НАР ЖАРГАХЫГ ХАР

Ахлагч Күкийн нэгэн адил нар
жаргахыг харж баясах цаг
гаргаарай. Нар жаргаж байгааг
харснаа зураарай. Дараа нь
найз хэрэгтэй байгаа ангийн
хүүхэд, хөрш эсвэл гэр бүлийнхээ
гишүүнийг бодно уу. Зургаа
тэдэнтэй хуваалцаж, тэдний
өдрийг гэрэлтүүлээрэй.

Дэнлүү хий



Цаасан аяга

Нүх цоологч эсвэл үзүүртэй харандаа
Гар чийдэн эсвэл гэрэлтдэг савх

1. Нүх цоологч юм уу харандаа ашиглан аягыг тойруулан нүх гарга. Ёроолд нь бас нүх гарга эсвэл бүхэлд нь зүсэж ав (том хүнээс тусламж ав).
2. Аягаа хүссэнээрээ чимэглэ. Дараа нь аяган доороо гэрлээ эсвэл гэрэлтдэг савхаа тавь.
3. Гэрлээ унтраагаад, дэнлүүгээ гэрэлтэхийг хараарай!

Санаа: Хэрэв танд цаасан аяга байхгүй бол та зургийн цаас хуйлан, үзүүрийг нааж болно.

Чи гэр орондоо, хөрш саахалт
айлууддаа болон сургууль дээрээ
хэрхэн гэрэл болж чадах вэ?

Ианыг хүлээсэн нь

Жошуа Ж.Перки

Сүмийн сэтгүүлүүд
Бодит түүхээс сэдэвлэв



“Надад юу
ТОХИОЛДСОН
ЮМ БЭ?”
гэж Иан
асуув.

“We like to be in Primary; we’re happy that you came too” (Children’s Songbook, 256).

Иан сэрээд, ээжийнхээ дуулахыг сонслоо. Энэ нь “Би Аврагчийн хайрыг мэдэрдэг” гэдэг дуу байв. Энэ Ианы Хүүхдийн хэсгийн дуртай дуу байлаа! Тэр ээжтэйгээ хамт дуулж эхлэв.

“Чи сэрчихэв үү” гэж ээж нь асуулаа. Ээж нь инээмсэглэсэн ч нүдэнд нь нулимс цийлэгнэж байв. Иан аавыгаа ээжийнх нь дэргэд сууж байгааг харлаа. Аав нь ч бас баяртай байгааг харагдав.

“Би чиний дуртай дууг өдөр бүр чамд дуулдаг байсан” гэж ээж нь хэллээ.

Иан ээж рүүгээ дахин инээмсэглэсэн ч толгой нь өвдөв. Үнэндээ түүний бие бүхэлдээ, ялангуяа хөл нь бүр их өвдөж байлаа. Тэр эргэн тойрныг болгоомжтой гэгч харав.

Тэр гэртээ биш байлаа. Тэр танихгүй өрөөнд төмөр орон дээр хэвтэж байв. Дараа нь тэр сувилагчийг мөн ойр хавьд нь өөр олон ор байхыг олж харав. “Энэ эмнэлэг бололтой” гэж тэр бодов.

“Надад юу тохиолдсон юм бэ?” гэж тэр асуулаа.

Ээжийнх нь царай дүнсийн, “Чи золгүй осолд орсон. Чиний дээрээс төмөр хаалга унаж, чи эмнэлэгт хоёр долоо хонож байна. Гэхдээ чи удахгүй зүгээр болно оо” гэв.

Хоёр долоо хоног оо! “Хөөх, ямар удаан унтаа вэ” гэж Иан бодлоо. Тэр хамгийн сүүлд сүмийн байранд Хүүхдийн хэсгийн хөтөлбөрт бэлдэж байснаа л санаж байв. . . .

Өө, үгүй байлгүй дээ! Хөтөлбөр!

“Би Хүүхдийн хэсгийн хөтөлбөрөөсөө хоцорчихсон уу?” гэж Иан асуулаа. Тэр хөтөлбөрт оролцохыг маш удаан тэсэн ядан хүлээж байсан! Тэр найзуудтайгаа хамт дуулах дуртай байв.

Ээж нь инээмсэглэн, толгойгоо сэгсрээд, “Үгүй дээ, чи хоцроогүй. Тойргийнхон чамайг сэрж, хөтөлбөрт оролцож чадах болтол хойшлуулахаар шийдсэн” гэв.

“Үнэн гэж үү?”

“Үнэн” гэж аав нь хэллээ. “Хүүхдийн хэсгийн бүх хүүхэд бишпоос хүлээхийг гуйсан. Тэд чамайг

оролцуулахыг хүсэж байгаа. Энэ жил оролцоно гээд чиний хэчнээн их догдолж байсныг тэд мэдэж байсан.

Иан Хүүхдийн хэсгийн хөтөлбөртөө оролцох болсондоо баяртай байв. Гэвч тэр эхлээд биеэ сайжруулах хэрэгтэй байсан ба үүнд хугацаа шаардагдах

“Чи алхаж чадах уу?” гэж Чэйсийг асуухад “Мэдэхгүй ээ” гэж Иан хариулав.

Чэйс “Хичээгээд үзэх үү?” гэлээ. Тэр түүнд босоход нь туслахад Иан хөлөө болгоомжтой гэгч газарт тавив. Тэр босохоор биеэ урагш хөдөлгөлөө. Зогсож чадлаа! Энэ бол сар гаруй хугацаа өнгөрсний эцэст



байлаа. Тэр эмнэлэгт нэг хэсэгтээ л хэвтэх ёстой байв. Тэр эцэст нь гэртээ ирсэн ч алхаж бас тоглож ч чадахгүй байлаа.

Харин найзууд нь түүнийг эргэж ирэв. Иан тэднээс сургууль болон сүмийн талаар асуув. Харин тэд хэзээ буцаж ирэхийг нь түүнээс асуулаа.

Тэр тэдэнд “Хөлөө бүрэн эдгэтэл очихгүй. Би одоо болтол алхаж чадахгүй байгаа” гэв.

10-р сар өнгөрч, 11-р сар гарахад Иан аажим аажмаар сайжирчээ. Нэг өдөр найзууд нь түүнийг ирж, хамт кино үзэхэд урив. Ианы ээж, аав хоёр түүнийг тэнд очиход тусаллаа.

“Хөл чинь өвдсөөр л байна уу?” гэж найз Чэйс нь түүнээс асуув.

Иан “Тийм ээ. Гэхдээ өдөр өдрөөр дээрдэж байгаа” гэлээ.

хийсэн анхны алхам байв. Хүн бүр алга ташив.

“Энэ чинь чи одоо буцаад сүмдээ явж болно гэсэн үг!” гэж Чэйс хэллээ.

Түүний зөв байлаа! Хэдэн долоо хоногийн дараа Ианы хөл огтхон ч өвдөхөө больсон юм. Эмч нар хөлийнх нь гипсийг авч, оронд нь чиг тавилаа. Ням гараг болоход Хүүхдийн хэсгийн хөтөлбөр эхлэх цаг болов.

Иан ариун ёслолын цуглаан дээр индрийн өмнө найзуудтайгаа алхан гарлаа. Тэр цэх зогсоод, ээж, аав хоёроо харж инээмсэглэв. Тэр дуугаа чадлынхаа хэрээр чанга дуулж байлаа. Түүний ээлж болоход тэр микрофонд ойртож зогсон, гэрчлэлээ хуваалцав. Тэр Хүүхдийн хэсгийн найзууддаа талархаж байгаагаа хэлжээ. Тэр бас Хүүхдийн хэсгийн хөтөлбөрийн нэг хэсэг нь байсандаа баяртай байв. ●

Энд өгүүлсэн хүү Бүгд Найрамдах Доминикан Улсад амьдардаг. Энэ улсын тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл дараагийн өгүүллийг уншина уу!

DIOS PATRIA LIBERTAD

Доминиканы Бүгд Найрамдах Улсаас МЭНДЧИЛЖ байна!



Сайн уу?
Намайг Марго
гэдэг. Энэ бол
миний дүү
Паоло.

Бид Доминиканы Бүгд
Найрамдах Улсаар
аялж байна. Ирээд,
бидэнтэй нэгдээрэй!

Доминиканы Бүгд Найрамдах Улс

Доминиканы Бүгд Найрамдах Улс нь Карибын тэнгист, Хаити улстай хиллэсэн арал дээр оршин тогтнодог. Доминиканы Бүгд Найрамдах Улсад 10 орчим сая хүн амьдардгийн 130000 нь Сүмийн гишүүд юм.

Сан-Доминго



Доминиканы Бүгд Найрамдах Улсад хүмүүс испани хэлээр ярьдаг. Энэ хүү El Libro de Mormón буюу Мормоны Номыг барьсан байна.



Доминиканы Бүгд Найрамдах Улсад олон хүүхэд бэйсболл тоглох дуртай. Энэ бол тухайн улсад хамгийн өргөн тархсан спорт юм.



Өнгөрсөн жил бошиглогч Доминиканы Бүгд Найрамдах Улсад айлчилж, хүмүүст хандан испаниар ярьсан.



Доминиканы Бүгд Найрамдах Улс нэг ариун сүмтэй ба энэ нь Сан-Домингод байдаг. Дээр нь "Santidad al Señor: La Casa del Señor" гэж бичсэн байдаг ба энэ нь "Их Эзэний өргөөнд; Ариунаас ариун" гэсэн утгатай.



Доминиканы Бүгд Найрамдах Улсын иргэд халуун орны жимс, ногоог өргөн хэрэглэдэг. Энэ хөвгүүд наргил модны сүү ууж байна.

Та бас Доминиканы Бүгд Найрамдах Улсаас ирсэн үү? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна.

Доминиканы Бүгд Найрамдах Улсаар бидэнтэй хамт аялсанд баярлалаа. Одоо бид дараагийн аялалдаа гарлаа!



Доминиканы Бүгд Найрамдах Улсын зарим найзтайгаа уулзъя.



"Би Хүүхдийн хэсгийн жаахан хүүхдүүдийг шуугилдах үед тэдэнд туслах дуртай. Би цаасан дээр дуу бичээд, тэдэнд дуулахад нь тусалдаг. Би мөн судраас уншиж ойлгоход нь тэдэнд тусалдаг."

Амбар О., 11 настай,
Доминиканы Бүгд Найрамдах Улс




"Би Есүст хайртай бөгөөд Түүнтэй маш ойр байгаагаа мэдэрдэг. Би бас сүмийн дуулал болон Хүүхдийн хэсгийн дуунуудад дуртайй."


Иан Р., 8 настай,
Доминиканы Бүгд Найрамдах Улс

Ариун Сүн


Марисса
Сүмийн



Тэр зүрхэн тус газрыг
хучих дулаан **хөнжил**
мэт байдаг. Тэр таныг
гуниглаж, түгшсэн үед
тайтгаруулдаг.



Тэр таныг аюулаас
сэрэмжлүүлэх **аюулын**
дохио мэт байдаг.
Тэр таныг хохироох
зүйлсээс хамгаалан, хол-
дуулж чадна.



Тэр зөөлөн **багш** мэт байдаг.
Тэр танд юу үнэн болохыг
хэлж, сурсан зүйлсээ санахад
тань тусална.

СҮНС БОЛ . . .

Виддисон
ЭТГҮҮЛҮҮД

г гишүүн. Энэ нь Тэр бидэнд
Есүс Христ хоёртой хамтран
дунд бие махбод гэж байхгүй
г гэж дууддаг.

дэг бэлэг. Та уснаас
ий баталгаа” хэмээх онцгой
таныг Ариун Сүнсийг хүлээн

лт. Та ариун ёслолоос
гэсэн амлалт өгдөг. Тэнгэрлэг
сийг тантай хамт байлгана

Тэр Тэнгэрлэг Эцэгийн элч мэт байдаг.
Ариун Сүнс танд Бурханы хайрыг мэдэрч,
Түүний таныг мэдээсэй гэж хүсэж байгаа
зүйлсийг ойлгоход тусална.



Тэр танд явбал зохих
газраа мэдэхэд тань
туслах тэмдэг мэт
байдаг. Сонголт хийхэд
тань таныг мөнх
амьдралд хүргэх зам дээр
үлдэхэд тусална.

Тэр таны үргэлж хамт байхыг хүсдэг
хамгийн сайн найз шиг байдаг. Та сайн
сонголт хийснээр Түүнийг өөртэйгөө
хамт байхад урьдаг.

СУДРУУД ДЭЭР:

Иохан 14:26

Галат 5:22

2 Нифай 31:17-18

Сургаал ба Гэрээ 130:22



Залуу эмэгтэйчүүдийн
ерөнхий ерөнхийлөгчийн
хоёрдугаар зөвлөх
Бэки Крэйвин

Жишгийнхээ дагуу амьдрах нь

“Мөн ямар ч цагт Бурханы гэрчлэгч болж зогсох нь” (Мозая 18:9).

Ав маань армид байсан тул намайг бага байхад манайх их нүүдэг байв. Нүүхийн хамгийн хэцүү хэсгийн нэг бол найзуудаа орхиж явах байдаг байлаа. Би ичимхий байсан учраас миний хувьд шинэ найзтай болох нь хүндхэн даалгавар байв. Аз болоход сургууль дээр ч, Хүүхдийн хэсэгт ч хүмүүс үргэлж эелдэг ханддаг байлаа. Сүм

дээр бидний өөр байх огтхон ч хамаагүй байдаг байв. Бид бүгдээрээ зүгээр л найзалдаг байсан.

Сүм дээр бусдад туслах нь надад ичимхий байдалаа даван гарахад тусалсан юм. Энэ нь бүр Хүүхдийн хэсгээс эхэлсэн. Би хуваалцах цаг дээр судраас хуваалцаж, ангидаа чанга дуугаар уншдаг байсан. Ийнхүү би бага багаар өөртөө илүү итгэлтэй болж байв. Энэ нь намайг итгэл үнэмшлийнхээ төлөө зогсоход тусалсан юм.

Намайг дөрөв юм уу тавдугаар ангид байхад манайх АНУ-ын Мэрилендад амьдарч байлаа. Манай сургуульд Сүмийн гишүүд олон байсангүй. Тиймээс надад Сүмийн гишүүн болон гишүүн биш найзуудын аль аль нь байсан.

Намайг өсвөр насанд байхад зарим найз маань миний жишиг таарахгүй зүйл хийдэг болов. Гэхдээ тэд надаар тэр зүйлээ хийлгэх гэж шахдаггүй байлаа. Найзууд маань миний итгэл үнэмшлийг хүндэлдэг байсанд би баярладаг. Заримдаа сургуулийн найзүүд хийдэг бүхнийг хийж чадахгүй болохоор ганцаардаж байгаа юм шиг санагддаг байсан ч жишгээ дагаж байгаадаа үргэлж өндөр сэтгэгдэлтэй явдаг байв. Би юу ч болж байсан сайн мэдээний дагуу амьдарна гэж шийдсэн юм. Миний гэрчлэл Хүүхдийн хэсэгт болон гэр бүлийн үдшийн үеэр илүү хүчирхэгжиж байв. Би Бурханы хүүхэд гэдгээ мэддэг болсон.

Олон жилийн дараа сургуулийн найзуудаас маань хоёр хүн Сүмд нэгдсэнийг би олж мэдлээ. Би ямар их баярласан гээч! Намайг багадаа сайн мэдээний дагуу амьдарч байгааг харсан явдал тэдэнд номлогчдыг сонсох шийдвэр гаргахад тусалсан гэж тэд надад хэлсэн.

Хайрт залуу найзууд аа, та нар бидний Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд билээ. Та энэ чухал үнэнийг өдөр бүр санаж байх юм бол сайн мэдээний дагуу амьдрахад илүү амар хялбар болно. ●



Би ЭЕЛДЭГ байж чадна.

Би
**Ариун
Сүнсийг
сонсож
чадна.**

Би Хүндэтгэлийн
өдрөөр Есүс
Христийг дурсан
санахад надад
тусалдаг зүйлсийг
хийж чадна.

Би Бурханд
төдийгүй бусдад
мөн өөртөө
хүндэтгэлтэй
хандаж чадна.

Би
ЗОХИСТОЙ
хувцаслан,
биеэ зөв
авч явж
чадна.

Би буруу зүйл хийсэн үедээ
НАМАНЧИЛЖ, дахин хичээж
чадна.



Би **шударга**
байж чадна.

Би зөвийг сонгож чадна

Би ярихдаа
сайн үгс
хэрэглэж чадна.

Би ариун сүмд ороход одооноос
бэлтгэж чадна.

Би Бурханы
талаар
хүндэтгэлтэй
ярьж чадна.

Би
САЙН
НАЙЗУУДТАЙ
болж чадна.

Би оюун
ухаан, бие
махбодоо
эрүүл
байлгаж чадна.

Би эцэг эхээ
ДУУЛГАВАРТАЙ
ДАГАЖ,
гэр бүлдээ
ТУСАЛЖ
чадна.

Би сайн зүйлсийг
уншиж, үзэж,
сонсож чадна.

Есүс надад хайртай. Би Түүнийг алхам
алхмаар хэрхэн дагахад суралцаж чадна.



Өөрийгөө таниулж, илэрхийлэх боломж



Би ганцаардаж байсан найзтайгаа хамт тогложсон.

Алексис Х., 7 настай, Канад, Нова Скотиа



Би санваар хүлээн авч, ээжтэйгээ хамт олсон гэр бүлийнхээ нэрсийг ариун сүмд авч очин, баптисм хүртээхийг тэсэн

ядан хүлээж байна.

Бригам В., 11 настай, Австрали, Викториа




Би Есүсийн талаар суралцах дуртай. Түүний бидний төлөө хийсэн золиослолд би талархдаг.

Сара Д., 6 настай, Бразил, Рио Гранде до Сул



Филип В., 8 настай Англи, Ланкашир



Би сургуулийнхаа тоглоомын талбай дээр хог байгааг харав. Найзтайгаа хамт хогийг авч хаяж болох уу гэж би захирлаасаа

асуусан. Би сайн иргэн байгаадаа баяртай байна.

Еллиа Д., 10 настай, Герман, Баден-Вюртемберг




Би эрэгтэй дүү нараа асарч, ээждээ тусалдаг.

Саманта С., 8 настай, Герман, Берлин



Фэранми Ф., 8 настай, Нигери, Лагос



Халимтай
мэндлээрэй!

Кэйти Ричи

Бодит түүхээс сэдэвлэв

“Үнэгүй авснаа үнэгүй өг” (Матай 10:8).

Маркус тэр өглөө танихгүй хүү ангид нь орж ирэхийг харав.

Хүн бүрийг нам гүм болоход хатагтай Бэкэр “Бүгдэд нь өглөөний мэнд, Түүнийг Халим гэдэг. Тэр манай сургуульд шинээр ирж байгаа. Үнэндээ бол манай улсад шинээр ирж байгаа юм” гэлээ.

Халим сайн байна уу гэж мэндлэхдээ шал руу ширтсээр байв. Маркуст түүний дуу хоолой нэг л өөр юм шиг санагджээ. Хатагтай Бэкэр цааш нь,

“Бид түүнийг энд ирсэнд мөн манай ангид орж байгаад баяртай байна. Бүгдээрээ түүнийг халуун дотноор хүлээн авна гэж найдаж байна” гэж хэллээ.

Хатагтай Бэкэрийг Халимд суух газрыг нь зааж өгөх үед Маркус өөрөө шинэ улсад ирж, шинэ сургуульд шилжиж ирэхээр болсон бол хэчнээн их сандрах байсан бол гэж бодов.

Өглөөний зуушны дараа хатагтай Бэкэр хүн бүрд зориулсан бэлэг байгаа гэлээ. Маркус түүнийг цүнхнээсээ юу гаргаж ирэхийг харахаар өндийв. Жижигхэн хувингууд байлаа. Тэр хувинг ангийн хүн болгонд тарааж эхлэв.

Багш Маркуст шар хувинг гардуулан өгөхдөө “Бидний хүн нэг бүрийн дотор хийсвэр хувин байдаг. Хүмүүс бидний төлөө сайн зүйл хийхэд хувин маань дүүрдэг. Бид ч бас бусдад сайн хандсанаар тэдний хувинг дүүргэж болно. Жишээ нь, ээж чинь чамайг тэврэхдээ хувинг чинь дүүргэдэг. Харин чи хэн нэгэнд сайхан үг хэлбэл тэдний хувинг дүүргэж байна гэсэн үг” гэв.

Маркус хамгийн сайн найз Калев руугаа харав. Тэр ч бас шар хувин авсан байлаа!

“Бид энэ долоо хоног хувингаа ширээн дээрээ тавьж, нэг нэгэндээ сайхан үгтэй зурвас бичих болно” гэж хатагтай Бэкэр хэлэв. Тэр цаасыг жижиглэн нугалаад, хувин руу хийн,



БИД ЭЕЛДЭГ БАЙЖ ЧАДНА.

“Бид бүгдээрээ сургууль, гэр орондоо эсвэл тоглож байхдаа ах дүүсэг сайхан сэтгэлийг хөгжүүлж чадна.”

President Russell M. Nelson, “These . . . Were Our Examples,” *Ensign*, Nov. 1991, 62.

“Энэ нь хүн бүрийн дотор хийсвэр хувин байдгийг сануулахад тусална. Бид хувинг дүүргэдэг хүмүүс болохыг хүсэж байна” гэв.

Маркус цаас гаргаж ирээд, Калевыг спортод сайн гэх мэтээр түүний тухай бичиж болох зүйлсийн талаар бодов. Харин дараа нь тэр Халим руу харлаа. Тэр гунигтай байгаа бололтой бөгтийн сууж байв.

Өмнө нь амьдардаг байсан газарт нь түүнд сайн найз байсан болов уу гэж Маркус бодлоо. Салах ёс хийж, алс хол газар луу нүүхэд хэцүү байсан байх даа.

Маркус ширээн дээрх цэвэр цаас руугаа харав. Түүнд нэг санаа төрж, тэр

“Хүндэт Халим аа,

Манай сургуульд тавтай морилно уу. Чамайг хүсвэл би завсарлагаанаар хамт тоглож болно шүү. Би чиний найз болж ч гэсэн чиний найз болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Маркусаас” гэж бичлээ.

Дараа нь цаасаа эвтэйхэн нугалаад, Халимын хувинд хийлээ. Халим инээмсэглэв. Маркуст халуун дулаан мэдрэмж төрж, дотроо баяртай байлаа. Тэр хувинг дүүргэгч болж байгаадаа баяртай байв. ●
Зохиогч нь АНУ-ын Айдаход амьдардаг.




Есүс ариун ёслолын талаар заасан



Есүс нас барахынхаа өмнө шавь нарынхаа хамт онцгой зоог барьсан юм. Үүнийг Сүүлчийн зоог гэж нэрлэх болсон.


Есүс талх аваад, адислав. Тэрээр
талхаа шавь нартаа өгч,
Өөрийг нь дурсан санахад
туслахын тулд үүнээс
идэхийг тэднээс хүсжээ.



Есүс аяга аваад, шавь
нартаа өгөв. Тэрээр
Өөрийг нь дурсан
санахад туслахын тулд
үүнээс уухыг тэднээс
хүсжээ.

Есүс мөн шавь
нартайгаа хамт
сүмийн дуулал
дуулав.





Би долоо хоног бүр Есүсийн хүссэний дагуу ариун
ёслолоос хүртсэнээр Түүнийг дурсан санаж болно. ●

*Есүсийн заасан зүйлсийг Матай 26:26–28;
1 Коринт 11:24–25-аас уншина уу.*

Есүс ариун ёслолыг бидэнд өгсөн



Эрхэм хүндэт эцэг эхчүүд ээ,

Эцэг эх нь ариун сүмд лацдан холбогдоогүй олон гэр бүл бий. Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийм нэгэн гэр бүлд өсөж торнисон. Бид гэр бүлийн нөхцөл байдал ямар байхаас үл хамааран үр хүүхдээ ариун сүмийн агуу адислалуудаас хүртэх хүсэлтэй болгохын тулд тэдэнд зааж болно. Бид бас өвөг дээдэстээ эдгээр адислалыг хүртэх боломж олгохын тулд тэдэнд гэр бүлийн түүхээ хөтлөхөд тусалж чадна. Та ерөнхийлөгч Нэлсон гэр бүлээ ариун сүмд лацдан холбогдохыг хэрхэн хүсэн хүлээсэн талаар Н2 хуудас дээрээс уншиж болно.

Та энэ сарын *Найз* сэтгүүл дээрх түүх, үйл ажиллагааг танай гэр бүл хэрхэн ашигласан талаар бидэнд бичнэ үү.

Хүндэтгэсэн,

Найз

Жич: Хэрэв танайх хүүхэдгүй бол *Найз* сэтгүүлийг хүүхэдтэй хүнд өгөхийг бодоорой.

New Friend

**50 E. North Temple St.,
Room 2393
Salt Lake City, UT 84105-3220,
USA.
liahona@ldschurch.org**



**Дотор нь нуусан Лиахонаг
олоорой!**

НАЙЗ ҮН ХАВТСАН ДЭЭРХ
зураг чимэглэлийг Шэйн Клэстэр

ГАРЧИГ

- H2** Тэргүүн Зөвлөлөөс: Эцэг эхдээ талархдаг байх
- H4** Шинэ бүлэг
- H6** Төлөөлөгчид дэлхий даяар: Ахлагч Күк Бразилд айлчлав
- H8** Ианыг хүлээсэн нь
- H10** Доминиканы Бүгд Найрамдах Улсаас мэндчилж байна
- H12** Ариун Сүнс бол . . .
- H14** Жишгийнхээ дагуу амьдрах нь
- H15** Би зөвийг сонгож чадна
- H16** Ухаалаг санаа зурагт хуудас: Есүс надад хайртай
- H17** Өөрийгөө таниулж, илэрхийлэх боломж
- H18** Халимтай мэндлээрэй
- H20** Судрын түүхүүд: Есүс ариун ёслолын талаар заасан
- H23** Будах хуудас: Есүс ариун ёслолыг бидэнд өгсөн